Тэгвэл зохиолд Сэлэнгийн отог хасаг буриадуудын дунд гэрлэх ёс ямархуу байсныг дараах байдлаар дүрсэлжээ. Жишээ нь, “...*Балжуу хөгшин, Арандалын авааль гэргий юм. Арандал өөрөө Ацын буриад тосгон дахь хасаг цэргийн сурвалжит гэр бүлд ганц хүү нь болон төрсөн хүн. ... Хэрэндээ зэгсэн том аж ахуйтай, нүсэр хүнд ажилд байнга дарагдан байдаг энэ айлд бүсгүй хүн аргагүй шаардагдаад ирэхлээр эцэг нь арга сүвэгчлэн, ядуу гөрөөчний охин, хорин гурван настай Балжууг арван зургаан настай хөвгүүндээ гэргий болгон авчээ...*” [13] гэж гэр бүл болоход эцгийн үүрэг их, хүүхдийнхээ заяа буянг эцэг эх нь толгой мэдэн шийдэж байсныг харуулна.

Арандал сэтгэлгүй хүнтэйгээ эцгийнхээ шахаасаар гэрлэж байсан бол хожим нь үр хүүхдээ гэрлүүлэхэд арай өөр бодол тээж явсаныг зохиолд “...*Жалам охины дөнгөж арван тав хүрмэгц удамтай чадалтай айлын хөвгүүд өрсөлдөн ирж, бэлэг сүй тавьцаан, эцэг эхээс нь гуйж гувшиж эхэлсэн юм. Арандал, охиныхоо хувь заяаны талаар эцэг өвгөдийн ёсыг эс баримтлан, зовлон үзсэн хүний ухаалаг зангаар хандаж, өөрийн нь санал хүслийг чанд харгалзав...*” [36] гэсэн хэдий боловч цагаа тулахад эцгийнхээ зөвшөөрлөөр охиноо хадамд өгөх болсон тухай зохиолд тодорхой өгүүлсэн байдаг.

Сэлэнгийн буриадууд эртнээс ямар шүтлэгтэй байсан талаар Сайнцак Юмовын бичсэнээр “... *Анханай 6 обогто буряадууд Монголой Сэцэн хаанай мэдэлдэ байхааа буддын шажантай байгаа, хожомынь Монголхоо ерэнэн 8 отогоорхид өөһэдын шажанай ламанартай ерэнэн. Тийгээд байхадаа Сэлэнгын буряадуудта бөөгэй мүргэл шүтэлгэ юрэ хээээд байгаагүй...*” (Юмов С., 1992, 159) гэсэн бол доктор А. Оюунтунгалаг “...*Буриадын оюуны соёлд ламын шашин нөлөөлөх болсон нь ХҮШ зууны дунд үе юм. Буриадад бурхны шашин нь халхаар дамжин дэлгэрчээ...*” (2008, 119) гэсэн байна.

Тэдний шүтлэг, бишрэлийн тухайд “...*Арандал, Жаламынхаа эхээс мэндэлсэн өдөр Ичин гавжид амь насы нь даатган, өндөр зээрд үрээгээ алд хадгийн хамт өргөсөн ажээ...*” [36] гэж, мөн “...*1919 оны намрын сүүл сард Ац, Минж, Хүдэр, Хиагтын сүсэгтэн, Барайван дацанг шинэ газар шилжүүлэн нүүлгэж дуусаад, Агын Сүүгэл дацны Ганжуур гэгээн гэгчээр аравнайлуулж их ёслол болоход Арандал хоёр эхнэрээ дагуулан очив...*” [42] гэж гарах бөгөөд энэ нь буриадууд чин сүжигтэй байсныг илтгэнэ.

Мөн буддын шажин амьдралын бүхий л үйлд нэвтэрсэн болохыг оршуулгын зан үйлийн талаар “...*Хоёр хоногийн дараа Ац голын зүүн эргэн дэх зулзаган модтой нарлаг дулаан энгэрт хээрийн салхинаа дэрвэх маанийн цагаан дарцаг доор Данзангийн цогцос мөнхөрч билээ...*” [40] гэж бичсэнээс харагдана.

Буриад түмний өдөр тутмын аж амьдрал, аж төрөх ухаан, арга нь халхчуудаас ялгаатай болохыг зохиолд багагүй дүрсэлсэн байна. Тэдний өдөр тутмын ажлын талаар “...*Жалам үхэр адууны шир элдэн, том талхины хөшүүр мод элгэндээ тэврээд зүтгэж явна. Гарамцоо хашаа хороон дотуур эргэлдэж, үхэр малынхаа аргал хоргол арилгаж бууц хэрзэнг ховхолж байлаа. Гэрт Жаламын хоёр жаал шагай няслан тоглож, Тамжид хусан тэвшнийхээ хитэг дээр мах хэрчиж суулаа...*” [158] гэж зураглажээ. Хусан тэвш, арьс элдэх талхи зэрэг нь буриад айлын таних тэмдэг бөгөөд оросоос дэвшилтэд олон зүйлийг өөриймшүүлэн авсны гэрч ч гэж хэлж болно.

Буриад зоны соёлын нэг чухал зүйл бол тэдний хоол ундны зүйлс юм. Энэ талаар зохиолд “...*Эх нь хоёр үнээнийхээ сүүг хонуут өнжүүтээр модон саванд байлгаж эдүүлээд, цөцгийг нь хамж аван, мойл жимстэй хольц хутгана...*” [179], айлчин гийчнээ ямар идээ, ундаагаар хүндэлдэгийг “...*Ашинга харуулын Буян занги хөвчийн урцанд ингэж дайлуулан, орос гурилын бин, зэрлэг гахайн гадар өөх, үхрийн тарган мах, хатаасан талх, цөцгийн тос, мойлтой өрөм, буцалгасан ээдэм зэргийг дээжлэн зооглосноор үл барам давсалсан загас ч амсаж үзлээ. Зочилгын ширээн дээр зөвхөн архи л байсангүй...*” [114] гэж энгийн тодорхой илэрхийлжээ. Энэ бол буриад түмний хоол хүнсний хэрэглээ нь оросын аж төрөлд хэрхэн ойртсон байсныг илтгэнэ.

Буриадуудын олонх нь хөвч, тайгад нутаглахын хэрээр модоор гэр байшин барих, хашаа хороо босгох, тэрэг, чаргаа хүртэл өөрсдөө хийх дархчуул олонтой байв. Зохиолд өгүүлснээр Тавхаан нүүж ирээд “...*Баатар вангийн хошуунд буудаллан, Дөш нарс гэдэг газрыг сонгон авч, түр зуурын өвөлжөө бууц төхөөрөв. Хуурай нарс огтолж өдөр шөнөгүй ажиллан болхидуу боловч, уугим дулаан байшин, заамал дүнзэн хашаа сэлтийг барив...*” [207] гэж бичсэнээс харахад тэд эсгий гэрт сууж дасаагүй нь харагдана.

Оросын пийшин барих аргыг сурч, айл бүр хэрэглэдэг байсныг “...*Чулуун зууханд хуурай түлээ шатаж, данхтай цай даргин буцалж байна. Эртлэн боссон эцэг эх нь бургасан шүүрээр*

хотныхоо хог шороо шүүрдэж, унасан малгайгаа авах завгүй хөдөлцөөнө...” [209] гэж Тавхааныхан шинэ нутагт байшин бариад мөн л пийшингээ барьж, гэр орноо халааж байсныг, мөн л их ажилсаг хүмүүс болохыг үзүүлжээ.

Буриадууд орост байхдаа буудай тариалах, хүнсний ногоогоо өөрсдөө тарьж ургуулахаас гадна гол ажил нь хадлан хадаж, малаа тэжээх аргад суралцсаныг хасаг эр Аррандалынхны аж амьдралаас харж болох бөгөөд малаа тэжээх өвс хадлангаа Тамжид, Гарамцоо гурав нийлээд хадуур, тармуур зэрэг техникийн хүчээр авсныг “...*Ундрахын булан гэдэг үржил шимтэй нугад Аррандал өвс хадаж, гэрийн чинээ бараатай хоёр зуугаад бухал тавилаа. Ургац сайн, хур бороо бага байсан болохоор амь зуулгын энэ гол нэгэн ажил нь тун урагштай бүтжээ. Хориодхон хоногийн дотор хадаж хамаад нуруулдсанаар барахгүй бүр хашаалж амжив...*” [498] гэж бичсэнээс гадна энэ бол буриад, халхчуудын амьдралын хэв маяг, амьжиргааны ялгааг үзүүлсэн тодорхой хэсэг мөн.

Буриадууд хэдийгээр монгол угсаатны нэг бүлэг хэдий боловч 300 гаруй жил оросын хил хязгаарт сууж, тэдний ахуй соёлд уусаж, зарим талаар өөрсдийн гэсэн өвөрмөц ёсоо алдалгүй сахиж ирсэн нь халхчуудаас баахан төсөө, ялгаатай болсоныг зохиолд багагүй дурдсан байна.

Зочин тухайн айлд ирээд “...*Тэр зочин малгайгаа авч сугандаа хавчуулаад ар хорийн заншлаар хүн бүрийн өмнө очиж толгой дохин мэндлэв. Болуу Санжмаа хоёрыг ч орхилгүй, тэдний өмнө бөхийн, — Та мэнд үү? Та мэнд үү? гэж ёс гүйцэтгэн амар амгалангийг нь асуулаа...*” [574] гэсэн байна. Мөн буриадууд айлд орж ирээд эхлээд бурхан шүтээнд нь мөргөөд, дараа нь гэрийн эзэдтэй мэнд мэддэг уламжлал байв. Энэ талаар зохиолд “...*Бидэн шиг л юм. Харин гэрт нь оруутаа, мэнд усгүйгээр шууд очоод бурханд мөргөхөд их гайхдаг юм. ...Тэгэхэд нь ичмээр гэж Гарамцоо өгүүлэв. Хүнээс ичлээ гээд бурхан шүтээн, буриад ёсоо орхичихно гэдэг даанч тоогүй хэрэг дээ гэж эцэг нь зэмлэнгүй хэлэв...*” [268] гэж бага охин Гарамцоо нь нутгийн халх айлуудаар явж, хийсэн тэрэг, чаргаа борлуулах, хэдэн амьжиргааны мал олж ирэхээр яваад ирээд гэрийнхэндээ хуучилж байгаа энэ хэсгээс тодорхой харагдана.

Тэдний хэл яриа ялгаатай, болохыг анх нүүж ирсэн Тарвааны бодлоор “...*Тэдний хурдан ярих гэдэг жигтэйхэн салхин сэнс шиг дуржигнаад л өнгөрхий нь яана. Тарваан ганц ч үг ойлгохгүй*

хоцровч “*Ай хөөрхий нэг хэлтэн, нэг шажинтан гэсэндээ хэлмэрч л лав хэрэггүй юм байна*” гэж бодож явлаа...” [207] гэж бичжээ. Одоо ч гэсэн буриаддууд аажуу, аялгаар хэлэлцдэг нь хэвээрээ. Энэ бол нэг гаралтай боловч нутгийн аялгууны ондоошил, хүн зоны аж амьдралын хэвшил, хил хязгаар тусгаар суусан хүмүүсийн бодит байдал болохыг уран сайхны аргаар гаргасан нь энэ юм.

Б. Нямаагийн “Арандалынхан” роман нь Сэлэнгийн хасаг буриад отгийн аж амьдрал, туулсан замналыг бодит хүний ярианд тулгуурлан баримтаг уран сайхны аргаар боловсруулан бичсэн зохиол. Тус зохиолд буриад түмний онцлогийг харуулсан дүр, дүрслэл багагүй байгаа нь угсаатны зүйн талаас судлавал зохих зүйлийн нэг болж байна.

Тус романд Ац тосгоны Сэлэнгийн отгийн хасаг буриад болон Шисаана, Ярууна нутгийн хорь буриадын аж амьдрал, нүүдэл суудлыг ХХ зууны эхэн үеийн Оросын улс төрийн нөхцөл байдлын ээдрээт түүхийн дэвсгэр дээр өргөн дэлгэр харуулж, дүрсэлсэн нь анхдагч зохиол болж байна. Хасаг цэргийн өнгөрсөн түүх, тухайн үеийн байдлыг өвгөн Васил, түүний ганц хүү хасаг цэрэг Арандалын дүрээр, цагаатны цэргийн эмгэнэлт хувь заяаг бага хүү Дугарын дүрээр, улаантны ялалт, хувьсгалт цэргийн амьдралыг том хүү Баваасан нарын дүрээр харуулсан нь түүх, хувьсгалын сэдвийг буриад зоны амьдралын дэвсгэр дээр уран сайхны аргаар харуулсан хэрэг юм.

Буриадын тэр дундаа хасаг буриад отгуудын амьдралын хэвшил нь бусад жирийн буриад ардын амьдралтай адилхан байсныг зохиол дахь дүрслэлүүд харуулж байна. товч дүгнэхэд тус роман нь буриадын ёс заншил, аж төрөл, шашин мөргөл, нүүдэл суудал, аж ахуй эрхлэх онцлог зэргийг угсаатны бодит ахуй амьдралаас сэдэвлэн уран сайхны аргаар дүрсэлсэн томоохон уран бүтээл болсон байна.

Литература

1. Бадамдаш Д. Буриад зоны зан үйлийн зарим тэмдэглэл, өгүүлэл // “Буриад судлал” сэтгүүлийн № 3. Улаанбаатар: Китаб ХХК, 2010. Х. 56.

2. Батжавхлан нар. ХХ зууны Монголын уран зохиол / Ерөнхий редактор: С. Байгалсайхан, Зохиогчид: Э. Батжавхлан, Ш. Баттөр, А. Мөнх-Оргил. Улаанбаатар: Жиком пресс ХХК, 2017. Х. 381.

3. Баярмаа Б. Б. Нямаагийн “Арандалынхан” романд буриад түмний ахуй амьдрал, ёс заншил, түүхэн үнэн туссан нь, магистрын зэрэг горилсон бүтээл / Удирдагч: профессор Д. Оюунбадрах, Шүүмжлэгч: профессор С. Энхбаяр, МУБИС-ийн Эрдэм шинжилгээний номын сан. Улаанбаатар: Төмөртрейд ХХК, 2012. Х. 15–20.

4. Билигсайхан Ч. Монгол романы тухай бодол, өгүүлэл, “Цог” сэтгүүлийн № 2. Улаанбаатар: УХГазар, 1977. Х. 34.

5. Билэгсайхан Ч. “Монгол романы уламжлал, шинэчлэл” өгүүлэл, “Цог” сэтгүүлийн № 4. Улаанбаатар, 1990. Х. 51.

6. Дашдорж Д. “Арандалынхан романы тухай” өгүүлэл // “Монгол роман дахь зарим дүрүүд” ном. Улаанбаатар, 1982. С. 152.

7. Дашдорж Д. Арандал өвгөний адармаатай дүр, өгүүлэл, “Утга зохиол урлаг” сонин. Улаанбаатар: УХГ, 1990. С. 8.

8. Жамбалсүрэн Н. // Зарим романы хэл найруулгын тухайд, шүүмж, “Утга зохиол урлаг” сонин 5-р сарын 2. Улаанбаатар: УХГ, 1974. Х. 4.

9. Мөнх Ц. Цаг үе, утга зохиол, шүүмжлэл. Улаанбаатар: УХГ. 1980. Х. 76–80.

10. Нацагдорж Б. XVIII зууны Өвөр байгалын буриадын нийгмийн байгуулал // “Буриад судлал” сэтгүүлийн № 6. Улаанбаатар: Китаб ХХК, 2016. Х. 101–120.

11. Нямаа Б. Арандалынхан. Улаанбаатар: УХГ, 1988. 570 х.

12. Оюунтунгалаг А. Монгол улсын Буриадууд. Улаанбаатар: MGL Design LLC, 2008. 119 х.

13. Уэллек, Р. Уоррен О. Уран зохиолын онол. Улаанбаатар: Өнгөт хэвлэл, 1999. 210 х.

14. Ринченсамбуу Г. Түүхэн үйл явдлыг уран зохиолд тусгасан нь, “Утга зохиол урлаг” сонины 5-р сарын 4. Улаанбаатар: Сүхбаатар хэвлэл, 1979. Х. 4.

15. Хабтаев П. Т. История Бурят-Монгольской АССР. Изд. 2-е, испр. и доп. Улан-Удэ: Бурят-Монгольское кн. изд-во, 1954. Т. 1. С. 280–287.

16. Чимитдоржиев Ш. Б. Бурядад түүхэ бэшэгүүд. Улаан-Удэ: Бурядад номой хэвлэл, 1992. 159 с.

**УРАН ЗОХИОЛ ДАХЬ ЧОНЫН ДҮР ДҮРСЛЭЛД ХОЛБОГДОХ
ЗАРИМ СУДАЛГААНЫ ТУХАЙД**
(НЕКОТОРЫЕ ВОПРОСЫ ИЗУЧЕНИЯ ОБРАЗА ВОЛКА
В ХУДОЖЕСТВЕННОЙ ЛИТЕРАТУРЕ)

© **Дүгэрсүрэн Оюунгэрэл**

докторант,

Университет Дорнод

Монголия, 21071, г. Чойбалсан, микрорайон 10

gerelee2424@gmail.com

© **Самбуу Гансүх**

магистр,

Университет Дорнод

Монголия, 21071, г. Чойбалсан, микрорайон 10

shagaalai@gmail.com

Аннотация. Дэлхийн аль ч улс үндэстний утга зохиолд бүхий л нийгэм, цаг үеийн турш хүн гол дүр байсаар ирсэн хэдий ч адгуусан амьтан, араатан жигүүртэн гэх мэт амьтдын дүр томоохон байр эзэлдэг. Түүний дотроос чонын дүр, дүрслэл ихээхэн өвөрмөц шинжтэй билээ. Зарим улс түмнүүд чоныг өөрсдийн уг гарвал, хувь заяатай холбон домоглож, сүлдлэн шүтэж байхад зарим нь сөрөг үнэлэмжээр буюу утга зохиолын түүхэндээ “дорд үзэгдсэн дүр” гэх ба чоныг үзэн ядах шалтгаанаа хүнд байдаг амьтнаас өвлөж ирсэн араатан шинж чанартай холбож тайлбарлах нь ч бий.

Дээрх байдлаар чоныг улс үндэстний угсаа гарвал гэж үзэх хандлага, домогзүйн дүр болох талаас; чонын төрөл, бүрэлдэхүүн, амьдрал зохицол, чонын ав хийгээд авлах арга ухааны тухайд; чонын зан араншин, мөн чанар хийгээд үүнтэй эсрэгцүүлэн хүний чононд хандах өсөрхүү хийгээд ёсорхуу байдлын тухай уран зохиолд хэрхэн урласных судлан шинжилсэн хэд хэдэн бүтээлүүдийн талаар энэхүү өгүүлэлдээ өгүүлэх болно.

Ключевые слова: Дэлхийн улс үндэстэн, сэтгэлгээний ялгаатай байдал, уран зохиол, чонын дүр дүрслэл, судалгаа.

ABOUT SOME RESEARCH WORKS RELATED
TO THE IMAGE AND DEPICTION OF WOLVES IN THE LITERATURE

Dugersuren Oyuungerel

Doctoral student,

Dornod University

Mongolia, 21071, Choibalsan City, Microdistrict 10

gerelee2424@gmail.com

Sambuу Gansuh

Master,

Dornod University

Mongolia, 21071, Choibalsan City, Microdistrict 10

shagaalai@gmail.com

Abstract. Man has been the main character of literature of nations around the world during all societies and times. However, animals; beasts, and birds also play one of the major roles in the genres of literature. Particularly the image and depiction of wolves are very unique among them. While some nations worship wolves as their origin, believing in ancient myths that wolves were their ancestors, some have a negative connotation regarding wolves as " the most unwanted character" in literary history and numbers of people attribute their hatred of wolves to the cruel nature of human beings inherited from beasts.

Keywords: nations in the world, differences in thinking, literature, image and depiction of wolves.

Уран зохиол нь оюунт хүний сэрэл, сэтгэхүй, мэдрэмж, зөн билиг, сэтгэл зүрхнээс төрж, уншигчдын сэтгэл оюунд адил тэгш дамжин амьдардаг урлагийн онцгой төрөл (2, х. 377) бөгөөд дүрслэх боломж, илэрхийллийн цар хүрээнд хүний сэтгэл, оюун санааны далд чинадын ертөнцийг нээн харуулах, шинжлэх боломжоороо урлагийн бусад төрлөөс давуу.

Тэгвэл тухайн зохиолынхоо уран сайхны зорилтыг шийдэхийн тулд үзэгдэл юмс, хэрэг явдлын уялдаа холбоог хангах, түүнд шаардлагатай зүйлсийг үйл явдал руу татан оруулах, хэнд, юунд хэрхэн хандах, юу гэж үзэж үнэлэх, ямархуу нөхцөл бололцоо бүрдүүлэх, бусад дүрийн хэрэг явдалтай уялдуулах, зохиолчийн ертөнцийг үзэх үзэл, сэтгэлзүйн хандлага, зорилго сэлтийг хамтад илэрхийлдэг онолын цогц ойлголт бол дүр юм (2, х. 137). Зохиолд ерөнхийдөө эерэг гол дүрийг дагасан эерэг зан төрх бүхий, эсрэг гол

дүрийг дагасан сөрөг зан төрх бүхий, мөн гуравдагч буюу дундын хэв шинж бүхий дүрийн систем бүрэлдсэн байдаг.

Харин “Зохиол нь бидний амьдралтай зэрэгцээ шугаманд оршин буй бас л нэгэн амьдрал”. Зохиол гэдэг анхны өгөгдөхүүн, түүнийг тайлбарлахад хоёр дахь өгөгдөхүүн гарна. Тайлбарлах боломж хязгааргүй учраас, уг зохиол гагцхүү тухайн тайллын хүрээнд л төгс үнэ цэнэтэй.

Зохиолд дүрслэгдэн, өгүүлэгдэж буй юмс цаанаа бэлгэдлийн утгыг давхар агуулдаг. Зохиолч тийм бэлгэдэл бодоогүй байлаа ч бичвэр бий болох явц өөрөө далд ухамсарт биежсэн давхар бэлгэдлүүдийг агуулж байдаг. Өнөө үед судлаач, шинжээчид ч зохиолоос цаад бэлгэдлийг нь олж харахыг нэг язгуур мөрдлөгөө болгож байна (1). Тиймээс аливаа урлаг, уран зохиолыг ухаарах, утгыг тайлах оролдлогууд үеийн үед байсаар ирсэн билээ.

Дэлхийн аль ч улс үндэстний утга зохиолд бүхий л нийгэм, цаг үеийн турш хүн гол дүр байсаар ирсэн хэдий ч адгуусан амьтан, араатан жигүүртэн гэх мэт амьтдын дүр томоохон байр эзэлдэг. Түүний дотроос чонын дүр, дүрслэл ихээхэн өвөрмөц шинжтэй.

Зарим улс түмнүүд чоныг өөрсдийн уг гарвал, хувь заяатай холбон домоглож, сүлдлэн шүтэж байхад зарим нь сөрөг үнэлэмжээр буюу утга зохиолын түүхэндээ “дорд үзэгдсэн дүр” гэх ба “чоныг үзэн ядах шалтгаанаа хүнд байдаг амьтнаас өвлөж ирсэн араатан шинж чанартай холбож тайлбарлах” (Jesse, 2000) нь ч бий.

Дээрх байдлаар чоныг улс үндэстний угсаа гарвал гэж үзэх хандлага, домогзүйн дүр болох талаас; чонын төрөл, бүрэлдэхүүн, амьдрал зохицол, чонын ав хийгээд авлах арга ухааны тухайд; чонын зан араншингийн чанарууд хийгээд үүнтэй эсрэгцүүлэн хүний чононд хандах өсөрхүү хийгээд ёсорхуу байдлын тухай уран зохиолд хэрхэн урласныг судлан шинжилсэн хэд, хэдэн бүтээлүүдийн тухай энэхүү илтгэлдээ өгүүлэх юм.

Бид монгол уран зохиол дахь чонын дүр, дүрслэл, бэлгэдэлзүйг судлан шинжлэх ажлынхаа хүрээнд энэ удаад чонын дүр, дүрслэлийг өрнө, дорно, монголд хэрхэн судалсныг тодруулж, зарим бүтээлээр жишээлэн ярих болно. Ерөнхийд нь ажиглахад тухайн улс үндэстний соёл, аман ба бичгийн уран зохиолыг судлан, тодорхой санал дэвшүүлж, дүгнэсэн судалгааны бүтээлүүд цөөнгүй олдож байна.

Монголчууд бид ч тэдний нэгэн адил чоныг өөрсдийн өвөг хэмээн шүтэж, чонын тухай аман яриа, зан үйл, олон арван домог, үлгэр, оньсого таавар, тоглоом наадам бий болгож, өч төчнөөн

зохиол бүтээлийг туурвисан арвин баялаг сантай ард түмэн юм. Энэ нь ард түмний зан заншил, нүүдэлчин ахуйтай нягт холбоотой хөгжиж, нийгмийн бүхий л цаг үеийн соёл, урлаг, уран зохиолд тусгалаа олж, шинэ санаа, утга агуулгаар баяжин хөгжсөөр байна.

1. Тотем шүтлэг талаас судалсан нь:

Чоныг улс үндэстний угсаа гарвал гэж үзэх хандлага, домогзүйн дүр болох талаас нь эрдэмтэн Б. Я. Владимирцов, Г. Н. Потанин, С. Дулам, Г. Сүхбаатар нар судалжээ. Харин чонын төрөл, бүрэлдэхүүн, амьдрал зохицол, чонын ав хийгээд авлах арга ухааны тухайд Т. Наранхүү судалж, “Монгол нутгийн чоно” /2000/ номоо хэвлүүлсэн бол, Г. Аким монголчуудын домоглох сэтгэлгээ, чонын үрсэг, ухаантай, ханилгаатай, эртэй, заяандаа үнэнч, тусч зан зөнг баримтаар гарган, үүнтэйгээ эсрэгцүүлэн хүний чононд хандах өсөрхүү хийгээд ёсорхуу байдлын тухай “Тэнгэрийн нохой” хэмээх уран нийтлэлийн /баримтад түшиглэсэн/ ном, Р.Самдановж “Тэнгэрлэг тавилан” /2003/ судалгаа нийтлэлийн бүтээлийг тус тус бичиж хэвлүүлсэн байна.

Тухайлбал, эрдэмтэн Г. Сүхбаатар “Хүннү, түрэг, монголчуудад чоно тотем байсан байна. Гэвч уг тотемыг шүтэх хэлбэрийн угсаатны өвөрмөц шинж нь хүннү, монголчуудад (уртын дуу үүссэн тухай домог, Чингис хааны угсаа гарвалын домог г.м) нэгэн ижил байхад, түрэгчүүдийн хувьд хүннү, монголоос шал өөр байна. ...Түрэгчүүдийн угийн домогт тэднийг чононоос гаралтайг өгүүлсэн бөгөөд үүнтэй холбогдон түрэгчүүд чононы алтан толгойн дүрстэй тугтай байдаг байв” (6, х. 177) гэснээс гадна “Бүр Хүннүгийн өмнөх нүүдэлчин аймгуудыг эртний Хятадын сурвалж бичигт “нохой харь угсаатан” (6, х. 156) гэж тэмдэглэсэн байдаг тухай дурдсан байна.

Финландын Дорно дахины судлалын төвөөс Жерард Клаусоны “Turks and wolves” буюу “**Түрэг ба чоно**” (1964) жижиг ном хэвлүүлсэн байна. Энд “чоно” гэх үгийн гарлыг тодорхойлж, “Түрэг хэлэнд чоныг “bog”, “kur” гэж хоёр янзаар хэлдэг ба эдгээр үгсийн аль аль нь 13-р зууны үеийн Монголчуудын Нууц Товчоон дахь чоно 'chinu' гэдэг үгээс өөр байна. Мөн эндээс Түрэг, монгол угсаатан бие биенээ мэдэхээс өмнө чоныг нэрлэсэн үгтэй байсныг харж болно.” (5) ...“Түрэгийн эртний түүхийн сурвалж бичгүүдэд тэд өөрсдийгөө чонын гарвал угсаатай гэх ба тэдний дайн байлдааны сүлд нь алтаар хийсэн чонын толгой байжээ. Энэ нь Түрэгүүд тотемик итгэл үнэмшилтэй бөгөөд мөн өөрсдийгөө чонын

увдистай гэж үздэгийг харуулж байна” хэмээгээд Монголын түүхийн сурвалж бичиг, аман зохиолоос эш татан харьцуулж бичжээ.

Удаах бүтээл нь ОХУ-ын судлаач, түүхийн ухааны доктор Р. С. Липецкийн “Монгол, Түрэг угсаатны тууль дахь чонын дүрийн хувирал” бөгөөд тус өгүүлэл нь Өвөг дээдэс-чоно, Хөтөч-замч чоно, Тэжээн торниулагч чоно, Хүн чоно, “Чоно” нэр, Шившлэг, Чоныг шүтэх соёл, эмчилгээний зан үйл (4) гэсэн 7 дэд хэсгээс бүрдэнэ. Уг дэд сэдвүүдийг Түрэг, Монгол, Киргиз, Алтай, Башкир, Якут, Ойрад, Буриадын домог, туульс зэрэг аман зохиолын жишээгээр баримтжуулж, олон судалгаанаас эш татан бичжээ. Энд нэгэн сонирхолтой зүйл нь “хүн түр хугацаанд чоно болон хувирах ч оюун ухаанаа хадгална. Уг чадварыг эхний ээлжинд бөө нар, баатрын эсрэг дүр болох буга чөтгөр, зарим баатрууд эзэмшдэг. Туулийн ийм хүншүүлэх дүрийн шилжилтийн үеийг "зөнч чонын" дүр эзэлдэг” болохыг өгүүлээд, эцэст нь “Монгол, турк угсаатны тууль ярианд амьтныг дүрслэх зүй тогтлын өөрчлөлт зөвхөн чонын жишээн дээр тодорхой харагдахаас гадна бар, бух, морь, бүргэд, начин шонхор гэх мэт амьтад дээр ч харагддаг. Гэхдээ туульс болон бусад ардын аман зохиолын төрлүүдийг харьцуулж судлахаас гадна тухайн улс үндэстнүүдийн археологи, угсаатны зүй, хэл шинжлэл ба уран зургийн өгөгдлүүд дээр тулгуурлах шаардлагатай. Ингэсэн тохиолдолд салангид байсан мэдээллүүд нийлж тод томруун түүхэн дүр төрх бий болно” (4, х. 133) хэмээн дүгнэжээ.

Мөн тотем талаас судалсан өөр нэг бүтээл нь 2019 онд хэвлэгдсэн “Хөх чоно, хүрэн баавгайн үр сад” номд буй судлаач Жан Сөгхо “**Зүүн хойд Азийн балар эртний болон эрт үеийн соёлын уг гарвалын судалгаа**” /Зүүн хойд Азийн балар эртний болон эрт үеийн суурь соёлыг ижил төстэй гурван шинжид тулгуурлан тайлбарлах нь/ юм. Тус өгүүлэл 1. Зүүн хойд Азийн хадны сүг зураг дахь толгой дээрээ гэрлэн цацрагтай хүний дүр төрх ба түүний өөрчлөлтүүд, 2. Амьтны тотем(шүтлэг)-ын домог, 3. Гэрлийн тусгалтай холбоотой домог, 4. Домгоор уламжлагдсан балар эртний зураг дахь дүрслэлийг унших нь 5. Зүүн хойд Азийн балар эрт болон эрт үеийн суурь соёлын ижил чанарын асуудал гэсэн хэсгүүдтэй. Үүний 2-р хэсэг буюу Амьтны тотем(шүтлэг)-ын домог хэсэгт “Турван улсын нөхсөн судар”-т өгүүлсэн Эртний Чосень улсын өвөг эцэг болох Таньгүний төрсөн домог; мөн “Жү улсын тэмдэглэл”, “И Ёгийн намтар”-ын Түрэг аймгийн бүлэгт

Түрэг аймгийн үндэслэгч Ашинагийн төрсөн домог; Амур мөрний Нанай овгийн үндэслэгч Актенкагийн төрсөн домог; “Монголын нууц товчоо”-нд Бөртэ чино(хөх саарал чоно), Гуамарал(эм цагаан буга)-ын ер бусын ураг барилдлагын тухай дурдаад, “энэ мэтчилэн Зүүн хойд Азийн олон ан гөрөөчин, нүүдэлчин үндэстний өвөг дээдсийн тухай домогт гол дүр нь амьтан байгааг харж болно. Энэ амьтад хоорондын нэгдэл, амьтан болон ер бусын оршихуйн нэгдэл, амьтан болон хүн хоорондын нэгдэл гэх мэт бүтэцтэй байгаа юм... Эдгээр олон үндэстний домгийн ялгаатай тал гэвэл баавгай, бар, чоно гэх мэт овог аймаг бүрийн тотем болгон шүтдэг амьтны төрөл зүйл нь өөр өөр байна. Монгол үндэстний хувьд хөх саарал чоно болон эм буга байхад, Таньгүний домогт баавгай болон бар гарч байгаа бөгөөд эцэстээ баавгай нь хүн болон хувирдаг. Нанай овгийн домогт бар гарах ба Үсүнь болон Гоча, Түрэг аймаг зэрэгт нь чоно гарч байна.

...Ийнхүү өргөн уудам Евро Азийн эх газрын нүүдэлчдийн ертөнцөөс бурханлаг оршихуй болон амьтан, амьтан болон амьтан, мөн амьтан ба хүн хоорондын ер бусын ураг барилдлагаас өвөг дээдэс нь мэндэлж, хожим улс орныг байгуулж буй дүр төрхийг нэгэн ижил олж харах боломжтой” (3, х. 29) гэж нийтлэг ба өвөрмөц шинжүүдийг ажиглан дүгнэсэн нь сонирхолтой байна.

2. Уран зохиолын дүр болох талаас судалсан нь:

Монголчууд бидний дунд “Тэнгэр заяат” — тэнгэрлэг амьтан хэмээн хүндлэгдэх, бас хэрцгий догшин, ховдог шунахай, санаа муутын төлөөлөл болж дүрслэгдэх чоныг уран зохиолын дүр болох талаас нь судалсан бүтээл мэр сэр байна. Тухайлбал, Чехийн Мазарык их сургуульд докторын зэрэг хамгаалсан Жана Браборковагийн “Interpretations of Wolves in Literature and Various Literary Approaches to their Existence — The Story of a Wolf” диссертаци байна. Жана Браборкова уг диссертация 7 бүлэгтэй бичсэн бөгөөд эхний бүлгүүддээ чонын түүх, хүн ба чонын харилцааны өөрчлөлт, чонотой холбоотой бусад зүйлсийн тухай өгүүлсэн бол зургадугаар бүлгээс аман зохиол /үлгэр, зүйр цэцэн үгс/ ба түүхийн номууд дахь чонуудыг, долдугаар бүлэгтээ Жек Лондоны “Цагаан соёот” болон Рудьярд Кипплингийн “Ширэнгэн ой” зохиолуудад шинжилгээ хийжээ.

Тухайлбал, “Чоно тухайн газар нутгаа өөрийнх гэдгээ бусдад зарлан тунхаглах, тэд хол байх ёстойг сануулах, одоогийн байршлаа бусдад мэдээлэх аль эсвэл харилцааны зорилгоор ульдаг. Өөрөөр

хэлбэл энэ нь нийгмийн харилцаа холбоогоо баталгаажуулж, сэтгэл хөдлөлөө илэрхийлж, мөн сүргийн доторх харилцаагаа хадгалж байгаа явдал юм. Лондон чоно улихыг "Харанхуйн хаа нэгтэйгээс маш гунигтайгаар удаан уйлах"(London, 1994, p. 6) хэмээн тодорхойлсон байдаг. Лондонгийн Цагаан соёот хэмээх зохиолд эдгээр чононууд бусадтай харилцах зорилгоор ульж байгаа юм... Мөн Лондоны дүрслэлд чононууд нохойг хэрхэн хурдан, амархан барьж иддэг тухай дүрслэл нь тэднийг хэр зэрэг хүчирхэг, бас хор хөнөөлтэй амьтад болохыг тодруулж өгсөн. Энэхүү эшлэл нь чоныг үргэлж идэш гэжээл хайж явдаг, олзоо маш хурдан идэж, ямагт илүү ихийг идэхийг хүсч явдаг өлсгөлөн араатан гэж харуулж байна”¹ гэсэн бол Рудьярд Киплингийн “Ширэнгэн ой” номын шинжилгээний хэсэгт чонын нийтлэг шинж чанар болох сониуч байдлын тухайд онцолж бичжээ.

Чонын дүрийг чадварлаг бүтээж, хүн байгалийн харилцан шүтэлцээ, хамаарлын асуудлыг дэлхийн тавцанд дэвшүүлж гаргасан нэгэн үнэ цэнтэй бүтээл Киргизийн нэрт зохиолч Чингиз Айтматовын “Цаазын тавцан” юм. Энэ зохиолын чонын дүрийн тухайд Монгол улсын Боловсролын их сургуулийн профессор С. Хөвсгөл “**Өрнө дахины уран зохиол**” /түүхэн найруулал/ номдоо “...Энэ зохиолын чонын дүрслэл өвөрмөц болсон. Зохиолч чонын амьдралыг хүншүүлэн дүрсэлсэн байдаг. Базарбай архины мөнгө олохоор бэлтрэгнүүдийг хулгайлж байхад, Акбара Кенжешийг өөрийн үртэй адилтган боддог. Балмад хүмүүс Авдийг үнэн үгнийх нь төлөө хайр найргүй зодож, бүр цовдлон алж байхад, Акбара ямар ч гэмтэл учруулалгүй дээгүүр нь харайж гардаг. Тэрчлэн анаша хэмээх мансууруулдаг ургамлыг хоёр чоно жилд нэг л удаа үнэрлэдэг байхад хүмүүс донтон, хамаг амьдралаа үрдэг” (7, х. 321)-ийг эсрэгцүүлэн өгүүлсэн байна.

Монгол уран зохиол дахь чонын дүр, дүрслэлийн зарим судалгааг дурдвал, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн профессор Д. Цэнд багшийн удирдлага дор оюутан Ч. Үл-Олдохын бичиж хамгаалсан “Монголын уран зохиол дахь өвөрмөц нэгэн дүрд өгөх үнэлэлт” /2004/ бакалаврын дипломын ажил байна. Тэрээр тус ажлаа удиртгалаас гадна “Монгол өгүүллэг дэх чонын дүр дүрслэл, уран чадвар”, “Монголын орчин үеийн тууж дахь чонын дүрийн

¹ Braborcova J. Interpretations of Wolves in Literature and Various Literary Approaches to their Existence - The Story of a Wolf. <https://is.muni.cz>. 2015.

уран чадварын асуудал”, “Чоныг дүрсэлсэн зохиолуудын хэл найруулгын уран чадварт хийсэн ажиглалт” гэсэн гурван бүлгээр бичсэн бөгөөд төгсгөлд нь “Монголын уран зохиол дахь чонын дүрийг цаашид судлах нь дэлхийн монгол судлал, чоно судлал, уран зохиолын дүр судлалд ихээхэн хувь нэмэр оруулах ач холбогдолтой” (9, х. 39)-г онцолжээ.

Дараагийн нэг томоохон судалгаа бол Өвөрмонголын Төвийн үндэсний их сургуулийн профессор Т. Намжил багшийн удирдлага дор Ү. Хастана гэж хүний бичиж хамгаалсан **“Монгол уран зохиол дахь чонын дүрийн судлал”** (2005) диссертаци юм. Тус ажил нь удиртгал, дүгнэлтээс гадна гурван бүлэгтэй ба “Монгол угсаа гарлын домог, домог яриан дахь чонын дүр” хэмээх нэгдүгээр бүлэгтээ Монгол ба Түрк үндэстнүүдийн угсаа гарлын тухай домог, домог яриан дахь чонын дүрийг харьцуулан шинжилж, “Хүннү, Түрк, Монгол энэ гурван том нүүдэлчин үндэстэн урьд хожид монголын өндөрлөгийг эзэргэж, адил газар оронд адилхан арга маягаар оршиж байсны улам хэдийгээр угсаа гарлын домгийн үйл явдлын мотив нь адилгүй боловч домгийн цөм болох чоно шүтээний байр суурь нь хувирсангүй мөртөө, эдгээр үндэстний соёл, зориг санааны бэлгэдэл болж, бүхий л умард оронд уламжлагдан дэлгэрсэн” (8)-ийг ажиглан дүгнэсэн байна.

Тэрээр хоёрдугаар бүлэг буюу “Адил бус шашин соёлын орчин дахь чонын дүр” хэсэгт голдуу адил бус соёлын нөлөөгөөр зохиогдсон сурвалж бичиг дэх Бөртэ чонын адил бус дүрийг буюу бөө мөргөл, бурхны болон исламын шашны соёлын орчин дахь чонын дүрийн ялгаатай байдлыг анхааран шинжилжээ.

“Монголын соёлын хөгжил хувирлын явц дахь чонын дүр” хэмээх гуравдугаар бүлэгтээ голдуу монгол домог, домог ярианд онгон шүтээн гэгдэж байснаас аажмаар жигшигдэх, муушаагдах болсон, түүнчлэн одоо үеийн монгол уран зохиолд олон талын бэлгэдэл дүрээр илрэх болсон чонын дүрийн улирал хувьслын явцыг задлан шинжилсэн байна.

Судлаач тус сэдэвт ажлаа дүгнэхдээ “Монгол уран зохиол дахь чонын дүрийн улирал хувьсал нь шүтээн дүр, араатны дүр, бэлгэдэл дүр зэрэг гурван шатаар хөгжин хувирч иржээ” (8) гээд, “чонын дүрийн судалгааг монгол уран зохиолын бүхэл цогцод цаашлан бүхий л умардын нүүдэлчин үндэстнүүдийн түүхэн хөгжилтийн явцад хамран оруулж хүндэтгэн судалбал зохино” гэсэн санааг дэвшүүлсэн нь сайшаалтай ч Монгол нутагт буй судалгааны эх

хэрэглэгдэхүүн, ялангуяа монголын орчин үеийн уран зохиолын судлагдахууныг төдийлөн ашиглаагүй нь ажиглагдана.

Мөн XXI зууны эхээр хэвлэгдэж, дэлхийг шуугиулсан, чонын өгүүлэмжтэй нэгэн том бүтээл бол Хятадын нэрт зохиолч Жанг Рунг “**Чоно тотем**” /Jiang Rong “Wolf totem”/ роман юм. Уг романыг 2004 оны сүүлчээр хэвлүүлсэн ба түүнээс хойш дэлхийн 40-өөд орны хэлээр орчуулагдан, сая сая уншигчдын хүртээл болсон билээ. Жанг Рунг “Г. Аким Монголд анх удаа, би Хятадад анх удаа монгол чоно ба хүний харилцан шүтэлцээ, хүн байгаль, нүүдэлчний соёлын талаар тодорхой баримтат зохиол бичсэн юм байна” хэмээн тодотгосон нь бий. Түүний “Чоно тотем” романаас сэдэвлэн, Францын найруулагч Жан Жак Анногийн бүтээсэн “Чонон сүлд” уран сайхны кино ч мөн дэлхийг шуугиулсан. Тэгвэл энэ зохиолч болон зохиолын тухай, “чонон сүлд”-чонын тухай, номоор дамжуулан дэвшүүлсэн үзэл санааны тухайд уншигчид, судлаачид эерэг, сөрөг хоёр үнэлэмжийн талбарт бичилцэж байна. Бид энэ удаад Монгол Улсын судлаачдын зарим өгүүлэл, шүүмжээс эш татъя.

Тухайлбал, утга зохиол судлаач, профессор Ч.Билигсайхан “Монгол чонын тухай хятад зохиолчийн сонгомол бүтээл” өгүүлэлдээ “Энэ романыг уншсаны эцэст Хятад орон үсрэнгүй өндөр хөгжлийн замдаа нэгэнт орж дэлхийн том хүчирхэг гүрэн болж байгааг мэдрэхийн хажуугаар өөрсдийнхөө дутагдал хоцрогдлыг ч бусдын нүднээс далдлан нуухаа больж нийтэд гарган тавьдаг болсныг харж болно. Хятад орны хөгжлийн зам дахь саад, экологийн сүйрэл, суурьшлын хор хөнөөлийг үнэнээр нь дэлгэн тавьж дэлхийн уншигчдад зоригтой хүргэж байгааг аргагүй том гүрний ухаан авъяас төгөлдөр зохиолчийн сэтгэл оюуны тэнхээ юм даа гэж бодогдож байна. Их үйл явдал, том хэрэг үйл, их утга зохиол том зохиолчийг төрүүлдэг нь үнэн ажээ. 1949 оноос хойших Хятадын шинэ утга зохиолд “Чонон сүлд” шиг роман тийм ч олон гараагүй болов уу. Зян Рун зохиолч үйл явдлын цар хүрээг уран бүтээлч хүний хувьд билгийн хараагаараа харж ухааран экологийн сүйрлийг дэлхий нийтийн өмнө бодитой, зоригтойгоор дэлгэн харуулжээ”¹ гэсэн бол утга зохиол судлаач Ц.Буянзаяа “**Чонон сүлд ба хонин сэтгэлгээ**” өгүүлэлдээ “Оюун санааны бүтээлийг, тэр тусмаа уран зохиолын бүтээлийн чансааг тодорхойлох хамгийн

¹ Билигсайхан Ч. Монгол чонын тухай хятад зохиолчийн сонгомол бүтээл. <https://news.mn/r/627070>

энгийн арга бол тухайн бүтээлийг өвтэйгээ харьцуулан үзэх арга байдаг. Зян Руний “Чонон сүлд” роман хэр зэрэг үнэ цэнтэй зохиол болсныг бид Д. Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” туужтай харьцуулан үзэж болно. Энэ хоёр зохиолын үндсэн агуулга буюу тал нутгийн чононы “сэтгэлгээний асуудал” бол тун төстэй юм. Нэг ёсондоо эдгээр зохиолд байгальд дасан зохицож, байгалийн хүчинд өөрийн арга ухаанаараа амь зууж явдаг чонын амьдралыг хүний амьдралтай уялдуулан бичсэн нь, чонын амьдралаар дамжуулан монгол хүний байгалийн хуультай зохицон амьдардаг арга ухааныг нээн бичсэн нь нэг агуулгатай байгаа болно. Гол ялгаа нь “Чонон сүлд” хэмжээгээрээ том боловч өгүүлэмжээрээ тун гүехэн юм. Харин “Хөгшин чоно ульсан нь” тууж бол хэмжээгээрээ жижиг боловч өгүүлэмжээрээ гайхамшигтай гүнзгий билээ. Туурвилзүйн хувьд “Хөгшин чоно ульсан нь” дахин давтагдашгүй сонгодог туурвил юм. “Чонон сүлд” бол байдаг л нэг бандгар усан роман юм. Ахуйн үнэний хувьд ч энэ хоёр зохиол мөн эсрэг, тэсрэг”¹ гэж дүгнэжээ.

Тэгвэл уг романы тухайд Хятад судлаач Я. Ганбаатар “**Зян Рунгийн “чонон сүлд” хийгээд монголчууд бид**” нийтлэлдээ “Романы хэлэх гэсэн эхний санаа бол “Чоно бол байгалийг тэнцвэржүүлэгч” гэсэн санаа бол харин хэлэх гэсэн удаахь санаа нь “Нүүдэлчид бол чоно. Чоно байгалийг тэнцвэржүүлэгч бол нүүдэлчид хүн төрөлхтнийг тэнцвэржүүлэгч мөн” гэсэн санаа юм. Энэ бол хүн төрөлхтний түүх судлалд урьд өмнө ч байсаар ирсэн “тэнгэрийн элч, тэнгэрийн гэсгээл, тэнгэрийн ташуур” хэмээх ойлголтын шинэлэг хэлбэр мөн. Шуудхан хэлэхэд зохиогч номондоо хятад үндэстнээ хоньтой зүйрлэж, монгол үндэстнийг чонотой зүйрлэн, ер нь энэ хоёр үндэстний бүх зүйлийг, хүмүүсийнх нь зан чанар, ааш аяг, тэсвэр хатуужил, зүрх зориг, зүрхгүй хулчгар байдал, хамаг бүхний, амь амьдралын эх сурвалж, уг үүсгэл болсон байгаль дэлхийтэй зохицон харьцах байдал, хандлагыг ч харьцуулан жишиж өгүүлжээ. Энэ тухай Билиг өвгөн: “Танай хятадууд өвс идсээр байгаад хонь шиг болсон улс, харин манай монголчууд мах иддэг чоно л гэсэн үг. Тийм болохоор чи жаахан ч гэсэн чонын зүрх зоригтой болбол зүгээрсэн”(36-р тал) гэж өгүүлж байна.

¹ Буянзаяа Ц. Чонон сүлд ба хонин сэтгэлгээ. <http://www.sonin.mn/news/culture/11606>

Зохиолд чонон сүлд, чоно шүтлэг, чоно шүтээн, чонон араншин, чонын үзэл санаа, номхон хонь, хятад хонь, хонийн үзэл санаа, чоно үндэстэн, талын чоно, далайн чоно, цус сэлбэлт зэрэг олон үг хэллэг, нэр томъёо, үндэсний үзэл, үндэсний ухамсар, сэргэн мандалт, хүчирхэгжилт, доройтол зэрэг ойлголт, ухагдахуун тааралдана. Жишээ нь: чонон араншин гэж юуг хэлж байна вэ? гэхүл энгийнээр хэлэхэд энэ бол маш их эрч хүчтэй, хийморь лундаатай, оргилуун халуун зан чанар, байгаль хийгээд нийгмийн хатуу ширүүн нөхцөлд амьдрахын төлөө, орших, эс оршихын төлөө эцсээ хүртэл тэмцэгч шинж юм. Түүхчид, судлаачид үүнийг өөр өөрөөр нэрлэсээр байдаг. Л. Н. Гумилёв, монголын түүхч Д. Гонгор, Н. Ишжамц нар тэднийг урт дурын хүмүүс гэсэн бол эртний түүх бичлэгт хүлэг баатад, нөхөд, нохос, тал нутгийн баатрууд, эрх чөлөөт нүүдэлчид... гэх мэт өөр нэрс ч бий. Тэд бүгдээрээ эрэлхэг дайчин, хийморьлог, тэнгэрлэг хүмүүс, нэг үгээр хэлэхэд чонон араншинтай хүмүүс авай”¹ гэх зэргээр судлаачид, улс төрчид, уншигчид өөр өөрийнхөөрөө харж үнэлж, дүгнэсээр байна.

Дээрх байдлаар, уран зохиол дахь чонын дүр дүрслэлийг судалсан тодорхой шүүмж, өгүүлэл, судалгааны ажлуудыг ерөнхийд нь ажиглахад, тухайн улс үндэстний гарваль түүх, үүслийн тухай домгийн сэтгэлгээтэй холбож тайлбарласан нь түгээмэл бол нөгөө хэсэг нь хүншүүлэл буюу хүмүүний аж амьдрал, зан араншин, сэтгэл санааны ертөнцөд буулгаж тайлах, мөн чонын өөрийнх нь төрөлх араншин, амьдралын онцлог, хүн байгалийн харилцан шүтэлцээнд уялдуулж судлах, хам ба цуваа цагийн үүднээс ижилсэл, ондоошлыг тодорхойлох оролдлогууд бас ажиглагдаж байна. Сүүлийн үеийн бүтээлүүдийг үнэлж дүгнэхэд улс төр, үндэстэн хоорондын харилцаа, иргэншлийн асуудлыг хөндсөн далд утгат санааны үүднээс хандах хандлага бас шинээр гарч ирж байна гэж хэлж болохоор байна.

Литература

1. Аюурзана Г. Утга зохиолын тухай яриа. Улаанбаатар, 2004. 99 с.
2. Галбаатар Д. Уран зохиол: Онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь. Улаанбаатар, 2012. 137 х.
3. Жан Сөгхө нар. Хөх чоно, хүрэн баавгайн үр сад. Улаанбаатар, 2019. Х. 29.

¹ Ганбаатар Я. Зян рунгийн “чонон сүлд” хийгээд монголчууд бид. <https://news.mn/r/627070>

4. Липец Р. С. Лицо волка благословенно... // Стадиальные изменения образа волка в тюрко-монгольском эпосе и генеалогических сказаниях). М.: Советская этнография, 1981. С. 120–133.

5. Clauson S. G. Turks and wolves. Helsinki, 1964. P. 5

6. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар, 1980. 156 с.

7. Хөвсгөл С. Өрнө дахины уран зохиол. Улаанбаатар: Жиком пресс, 2013. 321 с.

8. Хастана Ү. Монголын уран зохиол дахь чонын дүрийн судлал. Бээжин, 2005. 95 х.

9. Үл-Олдох Ч. Монголын уран зохиолын өвөрмөц нэгэн дүрд өгөх үнэлэлт. Улаанбаатар, 2004. Х. 39.

ЦЕНТРАЛЬНЫЙ ОБРАЗ РОМАНА Ц.-Ж. ЖИМБИЕВА «ТЕЧЕНИЕ»

© **Серебрякова Зоя Александровна**

доктор филологических наук, доцент,
профессор кафедры языкознания и литературы,
ВСГИК

Россия, 670031, г. Улан-Удэ, ул. Терешковой, 1
serebryakovaza@mail.ru

Аннотация. В статье анализируется образ Сэрэнцу, центральной героини романа Ц.-Ж. Жимбиева «Течение», наиболее убедительно и полно раскрытый женский характер бурятской романистики прошлого века. Сэрэнцу — из тех людей, кто, независимо от времени, которое может быть лучше или хуже, всегда стараются быть лучше, гармонично сочетая в себе самые позитивные национальные, общечеловеческие, женские качества, а также те, что были обусловлены обстоятельствами советской эпохи. Ее образ отличается достоверностью, точностью деталей, яркой индивидуальностью. Важнейшими смысловыми доминантами романа являются показанные через характер и судьбу главной героини труд, красота и духовное богатство. Благодаря глубокому художественному постижению этого образа, через вплетение в повествование лирически-субъективированных мотивов писателю удалось уловить личностное измерение советской эпохи. Талант и знание романистом жизненного материала позволили ему создать глубокий, общезначимый образ прекрасной бурятской женщины.

Ключевые слова: образ; характер; женский образ; героиня; центральный образ; литература; бурятский роман, советский период.

THE CENTRAL IMAGE OF THE NOVEL
TS.-J. ZHIMBIEVA "CURRENT"

Serebryakova Zoya Alexandrovna

Doctor of Philology, Associate Professor,
Professor of the Department of Linguistics and Literature,
VSGIK

Russia, 670031, Ulan-Ude, Tereshkova st., 1
serebryakovaza@mail.ru

Abstract. The article analyses the image of Serentsu — central character of Ts.-Zh. Zhimbiyev's novel "The Stream", the most persuasive and fully disclosed women character of Buryat novel in the last century. Serentsu are the person, who, without regard to the time, which may be more good or more bad, always try to be better, harmonically combining the most positive national, human, woman qualities and qualities, which were determined by circumstances of Soviet epoch. Her image is very authentic, accurate, strikingly individualized. The most important notional dominants of the novel are labor, spiritual wealth and beauty, which are shown through temper and destiny of the main character. Thanks to deep comprehension of this image and to inclusion in the narrative lyrical-subjective motives, the writer managed to catch the personal dimension of Soviet epoch. The talent and knowledge of life's material allowed the novelist to create a deep, generally valid image of Buryat woman.

Keywords: image, temper, woman image, woman character, central image, literature, Buryat novel, Soviet period.

В романе Ц.-Ж. Жимбиева «Урасхал» («Течение»), увидевшем свет в 1978 г., привлекает внимание образ доярки Сэрэнцу Баторовой. В отличие от остальных бурятских романов, в нем центральной героиней стала женщина, и это открыло перед писателем возможности не только для раскрытия новых граней народного характера, но и для более глубокого показа личностного смысла советской эпохи, а также общечеловеческих качеств самого убедительно и полно раскрытого женского образа бурятской романистики XX века.

На фоне ее типичных положительных героев этот персонаж выделяется, прежде всего, своей достоверностью. Прозаик убедительно воспроизвел суть этой цельной, стойкой натуры, преданной делу, честной, нравственно чистой, доброй, искренней, отзывчивой и чуткой и вместе с тем глубоко любящей близких, преданной семье, умеющей быть настоящим другом, тонко чувствующей женщины,

которую по праву можно назвать интеллигентной. Окружающие отзываются о ней как о замечательном и прекрасном человеке. Автор точен в фактических подробностях, придающих полноту и объемность центральному образу, помогающих его постижению. Героиня остается верной памяти не вернувшегося с войны мужа, бережно хранит их общие реликвии, предупредительна и заботлива к свекру; показана как любящая и мудрая мать тоскующего без отца маленького сына и ради спокойствия приемной дочери отказывающаяся от нового брака.

Широта души и щедрость сердца Сэрэнцу простираются далеко за пределы семьи: она помогает оказавшейся в отчаянной ситуации незнакомой девушке, становится приемной матерью сироте и растит ее как родную дочь, пытается понять каждую из доярок и помочь советом и делом.

При создании этого образа Ц.-Ж. Жимбиев избежал свойственного многим коллегам по цеху схематизма и показа растворения личности в коллективе как своего рода апофеоза советской реальности. Напротив, Сэрэнцу остается самостоятельной личностью, обладающей яркой индивидуальностью.

Это проявляется, в частности, в ее отношении к убеждениям, пристрастиям, поступкам людей. С одной стороны, будучи дисциплинированным членом партии, она испытывает дискомфорт, когда вынуждена считаться с верованиями окружающих: чтобы убедить свекра поскорее переехать на ферму в неблагоприятный, согласно приметам, день, она очень кстати вспоминает обычай, позволяющий якобы «снять» негативные последствия табу, но чувствует неудобство перед стариком из-за этой вынужденной хитрости; упрекнув подругу, кланявшуюся встреченным в городе священникам, она, не желая ссориться, закрывает эту тему.

Героиня следует общепринятому уважению к старшим, тактично принимая религиозность свекра, с сочувствием выслушивая жалобы старой доярки на недуги, трудности в воспитании сына и т. п. Не демонстрируя привязанности к давним обычаям, Сэрэнцу и не отказывается от того, что исстари было и во многом остается привычным в обиходе: оставляет подношения на месте исполнения обрядов, провожая в дорогу сына, вместе с другими доярками, как повелось, брызгает вслед молоком.

Присущее бурятскому характеру заботливое отношение к домашним животным проявляется не только в ее эмоциях, но и дей-

ственно: она выдаивает не доенную несколько дней чужую корову, настаивает, чтобы погонщики перегоняли скот там, где он может подкормиться, мягко уговаривает доярку получше относиться к животным и т. п.

С другой стороны, как отмечалось, «традиционное в ее образе обогащено лучшими чертами советского характера — открытостью и прямодушием» [5, с. 57]. Если окружающие предпочитают не замечать, что наивная и житейски неопытная девушка может всерьез увлечься местным дон-жуаном, то Сэрэнцу искренне пытается ее предостеречь.

Центральная героиня «Течения» относится к тем, кто, по словам Г. Д. Гачева, независимо от времени, которое может быть лучше или хуже, всегда стараются быть лучше [1, с. 383].

Она не раз проявляет находчивость и настойчивость: спасает человека от рассвирепевшего быка, первой начинает заготавливать веточный корм, одерживает верх над нерадивым гуртовщиком и т.д.

Благодаря ключевому образу воссоздан не только свойственный советскому времени пietet к образованию и высокий статус учителя, но и убедительно раскрыто ее духовное богатство, в том числе не реализованный в силу обстоятельств познавательный потенциал, выражающийся в сожалении, что ей пришлось совсем недолго поучиться, но в каждый свой приезд в поселок она оказывается у школы: ноги сами несут ее туда: «У нее всегда возникало какое-то особое торжественное чувство, стоило ступить на аккуратно расчищенные ... дорожки школьного двора». Слыша голос учителя географии, она думает: «Интересно рассказывает. Не только детям, ей любопытно послушать. Вот бы побывать в какой-нибудь из далеких стран... Что она видела дальше телячьего выгона? Даже в Улан-Удэ ни разу съездить не привелось» [2, с. 121–122].

Общаясь с начинающими доярками и доярками, Сэрэнцу одобряет их намерения учиться в институте или техникуме, сбор гербария местных растений, изучение их полезных свойств и составление рациона кормов, желание до всего дойти самим, больше всех радуется, что юноши запустили давно не работавшие доильные установки. «Ей нравилось, когда ребята принимались обсуждать прочитанные книги, спорить об услышанном по радио. Тут они казались старше своих лет. И хотя не совсем могла согласиться Сэрэнцу, а кое-что казалось ей просто непонятным, эти разговоры вызывали у нее чувство уважения к так много знающим детям» [2, с. 245].

С. С. Имихелова справедливо относит романиста к тем авторам, в произведениях которых образы природы, труд степняков «вписаны в историческую, культурную жизнь нации» [3, с. 42].

Название романа символично: в воспоминаниях доярки, решившей в одиночку спасти скот на пятачке суши, текут, как река, три десятилетия ее жизни, начиная с лета 1945 г. Символ реки определяет неторопливость и обстоятельность повествования. «Но за этим ... изображением спокойного течения жизни ощущается глубокое осмысление писателем жизни рядового советского человека, его труда, мужания, борьбы и роста, сопряженного с изменениями ... самой жизни. И в результате, и это главная удача автора, перед читателем раскрывается нравственная красота главной героини ..., повседневная, обычная жизнь которой воспринимается как подвиг верности, подвиг труда, материнства», — утверждал В. Ц. Найдаков. Подчеркивая народные истоки ее натуры, он писал, что «именно это дает Сэрэнцу силы на действительно героический подвиг, который она совершает во время большого наводнения» [4, с. 202–203].

Наиболее обстоятельно воссоздана самая трудная для нее ситуация конца войны и первых послевоенных лет, в полной мере позволившая автору раскрыть главное в образе.

Оказавшись по поручению парторганизации колхоза на отстающей, расположенной на отшибе ферме, героиня органично вливается в сложившийся маленький коллектив, вместе со всеми преодолевая бескормичу, разруху, нехватку рабочих рук, десятилетия трудясь с предельным напряжением сил, без отпусков, выходных, за мизерное вознаграждение, в одиночку, как все, поднимая детей.

После назначения старшей дояркой, осознавая возросшую ответственность за ферму, она и вовсе, по словам подруги, за своей работой забыла о себе: трудилась, будучи больной, не смогла из-за массы дел участвовать в совещании передовиков и отправила туда свою коллегу. Одна из доярок искренне недоумевает: «Вы всегда за самую тяжелую работу беретесь. За всех нас беспокоитесь. Что вы за человек?» [2, с. 209].

Вопреки склонности соцреализма к описанию конфликта передовика производства с антиподами, Сэрэнцу не борется с нерадивой дояркой, никого не критикует, не просит помощи у начальства. Напротив, чаще всего ей приходится уступать и в интересах дела мириться с тем, что ей, как новичку, передали самых строптивых

коров, с тем, что старшая доярка Удамбра старается выжить ее с фермы в отместку за то, что некогда Зандан, муж Сэрэнцу, женился на ней, а не на Удамбре и т.д. Это показывает не только стойкость, умение руководствоваться общими интересами центральной героини, но и ее миролюбивость и великодушие. Не случайно приемная дочь помнит наказ матери: никогда никого не попрекать за прошлое.

Одной из смысловых доминант романа является трудовой героизм женщины, вынесшей на себе все тяготы военных и послевоенных лет. Несмотря на почти неизбежную для деревенской прозы бытописательность, именно труд играет в нем роль универсальной ценности. Работа Сэрэнцу — не только выражение социалистической сознательности, но и проявление естественной потребности человека в созидательной деятельности, и выполнение долга перед собой, своими близкими, страной и народом. В данном случае имеет место совпадение позиций героини и повествователя.

Концепт красоты, в отличие, например, от долга, относительно редко приобретал значение доминанты в выдержанной в основном в суровых тонах бурятской романистике 1940–1970-х гг. Главная же героиня «Течения» в полной мере воплощает в себе также и эту экзистенциальную ценность.

Благодаря, главным образом, характеру Сэрэнцу в объективно-эпическое повествование вплетаются лирически субъективированные мотивы. Несмотря на все трудности, в ее эмоционально-возвышенном, глубоко личностном восприятии дойка — самая красивая работа на свете, в звуках ударов струек молока ей слышится музыка; она так чувствует его аромат: «Всеми травами степи пахнет теплое белое молоко!» [2, с. 29–30].

Через взгляд повествователя передается радостное чувство доярки от наконец-то урожайного на травы сенокоса: «Соперницы ...отстали от нее, хотя обе мечут сено без усталости. Сэрэнцу будто порхает по лугу. Работается ей легко. Настроение, какого с незапамятных времен не было — петь хочется. Копешки ставит — одну к одной. Примнет вершинку, прочешет аккуратно граблями, основание поправит, отойдет, оглядит со всех сторон и — следующую» [2, с. 106].

Духовное богатство героини включает и чуткость к прекрасному, и способность к эстетизации окружающего мира. Добираясь пешком до села, она любит осенним пейзажем, размышляя об

осени человеческой жизни: «Рдеют на солнце прибрежные осинки, колышутся на легком ветерке. Разные бывали осени за годы, что провела она здесь, но эта — редкая по красоте. Когда-то и в человеческой жизни приходит осенняя пора. Была бы она такой же красивой, мягкой, долгой ...» [2, с. 121].

Углубленный психологизм в детализации придает характеру убедительность, т. к. все действия и помыслы Сэрэнцу являются его следствием, а обстоятельствам — предметность.

Прекрасен связанный с памятью о муже поэтический образ невиданного дерева, благородного красного сандала из любимой им песни, которую постоянно слушают в ее семье.

И в пожилом возрасте Сэрэнцу глубоко чувствует красоту природы: «Красное солнышко перевалило за полдень. Над степью колышется марево. Ветер гонит волны по высокой траве. Зеленеют кусты по берегам мелководной и тихой речки ... Кажется, всегда так и будет — зелено, покойно, красиво» [2, с. 241].

Лаконично, как бы мимоходом, намечены немногие черты ее внешнего облика: тонкая стройная фигура, толстые черные косы, ямочки на зардевшихся щеках, но опосредованно, через восприятие разных персонажей читатель имеет возможность дорисовать его: они считают героиню красавицей, красивой, вспоминают ее милое лицо, говорят, что ее имя похоже на сирень и т. д.

В финале романа нет соцреалистической заданности и торжества справедливости: героиня, отказавшись эвакуироваться, остается среди безбрежного разлива ухаживать за почти сорока чужими коровами, забредшими на ферму, в ожидании спада воды. Вместо помощи из проплывающей лодки получает совершенно лишние начальственные указания хорошенько присматривать за скотом. Надеясь на скорое окончание наводнения, Сэрэнцу, по своему обыкновению вспоминает о муже, детях и внуках, озабочена оповещением хозяев заблудившегося скота, мечтает, как на ферме соберется одной семьей работающая там молодежь и как она скоро впервые в жизни поедет в отпуск, и притом на далекий южный курорт, к теплому морю.

Талант и доскональное знание писателем материала позволили ему создать глубокий, имеющий общезначимое, не ограниченное ни границами одной конкретной эпохи, ни рамками гендерной или сельской темы, образ прекрасного человека, центральной героини романа «Течение».

Литература

Abstract. The article is devoted to the translation of the Buryat chronicle texts into Russian language. The Buryats had a rich pre-revolutionary written heritage in Mongolian script. The genre of chronicle was the most developed. The chronicles were popular with readers who copied them and kept them in the family archives. In the 30s. XX century the Old Mongolian script was declared as "anti-people's", the works in the Mongolian script and their authors fell into the category of prohibited. Only in the era of democratization of society at the end of the XX century began to talk and write about the literature in Mongolian

script. However, because the tradition of teaching Mongolian script was completely discarded, the literature on this letter turned out to be inaccessible to the people. In this regard, a problem arose of translating the old Mongolian texts into Russian.

Keywords: the Old Mongolian script, the Buryat chronicles, translation into Russian, compound syntactic complex (CSC)

Одной из важных проблем изучения языка летописных памятников Бурятии являются вопросы перевода летописных текстов со старомонгольского на русский язык и переложения на современный бурятский язык. Следует отметить, что по данной проблеме отсутствуют какие-либо изыскания, кроме замечаний Ц. Б. Цыдендамбаева о переводах Н. Н. Поппе и Г. Н. Румянцева [11]. Некоторые аспекты перевода с монгольского на русский рассмотрены Е. О. Хундаевой [10].

Оценивая переводы летописей Т. Тобоева и В. Юмсунова, осуществленные Н. Н. Поппе [8], Ц. Б. Цыдендамбаев считает, что переводчику удалось сделать лишь подстрочный, а не эквивалентный перевод этих текстов на русский язык. В результате, как отмечено, Н. Н. Поппе “превращает лучших бурятских летописцев Т. Тобоева и В. Юмсунова в глазах читателей на русском языке в неуклюжих сочинителей” [11: 19]. Автор не подкрепляет свое замечание конкретным анализом переводов и поэтому его замечание о качестве перевода Н. Н. Поппе остается на уровне субъективного впечатления, навеянного конъюнктурными соображениями того времени и утвердившимся в нашей стране официальным отношением к личности Н. Н. Поппе в тот период.

В научном плане Н. Н. Поппе отличался исключительной плодотворностью: его наследием являются около 60 монографий, сотни научных статей, которые не утратили своей актуальности и в настоящее время. Неоценим вклад Н. Н. Поппе и в изучение письменных памятников бурят. Он впервые предпринял издание оригинальных текстов бурятских летописей [7, 5, 6], учитывая, что издание памятников на старописьменном монгольском языке представляет собою вообще большие технические трудности, значимость публикаций неоспорима. Также он впервые ввел в научный оборот материалы бурятских летописей, осуществив переводы летописных текстов на русский язык [8]. Сам же Н. Н. Поппе высоко оценивал эти труды: подводя в мемуарах итоги своей научной деятельности, он поставил на первое место свои ранние работы, а именно: словарь Мукадди-

мат ал-Адаб, статью о Лейденской рукописи, книгу о квадратной письменности и *издание бурятских летописей* (курсив наш. — Л. Б.), исходя, прежде всего из того, что концепции и реконструкции устаревают, а введенные в научный оборот факты имеют непреходящую ценность [16: 279].

Ц. Б. Цыдендамбаев в своей статье, посвященной переводам художественной литературы с русского на бурятский язык, приходит к такому выводу: данные переводы “зачастую еще не являются художественными, во многом производят впечатление подстрочников (подчеркнуто нами — Л. Б.). В них не чувствуется или почти не чувствуется творческого подхода к работе, без чего, понятно, не может быть подлинного художественного перевода” [12: 142]. Причину автор видит в том, что нашими переводчиками слово (причем отдельно взятое, выхваченное из контекста) ошибочно принимается за единицу перевода. А надо брать не слово в отдельности, а исходить из общего контекста и смысла высказывания. По мнению Ц. Б. Цыдендамбаева, переводчик должен отталкиваться от предложения как выразителя мысли и наименьшей единицы перевода. При таком подходе мы встречаемся с необходимыми добавлениями или, наоборот, пропусками отдельных слов, если это помогает переводчику вернее воспроизводить мысль подлинника.

Далее ученый пишет: “Более того, переводчик учитывает логику и смысл изложения автора на более широком участке контекста, а также различие в грамматическом строе русского и бурятского языков, в результате чего в переводе имеют место закономерные объединения или разъединения отдельных предложений” [Там же]. По нашему мнению, переводчик в большинстве случаев должен исходить не столько даже из предложения, сколько из более широкого контекста, а именно сверхфразового единства, а в нашем случае из сложного синтаксического комплекса (ССК), представляющего тематическое, смысловое и грамматическое единство тесно связанных между собой нескольких предложений летописного текста.

Обычно на практике переводчик переводит предложение за предложением и, если оно большое, разбивает его на ряд частей и работает над каждой частью отдельно. Исследователи перевода находят, что “такой подход (опора на предложение) является плодотворным” [4: 54]. Но обязательное условие — каждое предложение надо соотносить с более широким контекстом, т. е. сочетать микро- и макротексты.

С. Ш. Чагдуров предлагал различать минимальный контекст (словосочетание), развернутый (предложение и сложное целое), максимальный (смысловая перспектива произведения в целом) и сверхконтекст (культурно-историческое окружение слова, язык эпохи) [13]. Из указанных типов контекста переводчик чаще всего имеет дело с развернутым контекстом (предложение и сложное синтаксическое целое).

Из анализа перевода Н. Н. Поппе летописных текстов вытекает, что он в целом придерживается изложенного здесь подхода к пониманию контекста, и с учетом его разновидностей добавляет не заданные оригиналом слова или употребляет заимствованные слова без пояснений. Например, в восьмой главе летописи Вандана Юмсунова “*ĵang aburi-yin uĉira*” (‘О нравах’) в 4-м сложном синтаксическом комплексе (ССК) говорится: «*1773 on-aĉa qoyisida: nituy-ud bükün-dü daĉang-ud bariġdaĵu: teden büri-dü burqan-u šasin-u öngge büri-yin surġuli-nar bolun: törü-yin ġajara-ĉu mongġol ros kelen-ü surġuli-nar olan negegdeġü: teden-düir: ĵalayus ber olan-iyar oruġulaydun surulcaġu ba ĵarim-ud anu: ros-un büri degedü surġulinarun ġajara yabulcaġsaġar edüge ĉay-tu ĵon-u aburi jan anu: büri dotuġadu orun-u metü bolġu sayġiruġsaġar bayinam*» [1: 180].

Перевод Н. Н. Поппе: ‘После 1773 года в каждой местности были выстроены дацаны. В каждом из них возникли всякого рода буддийские духовные училища и открылись во множестве, даже при светских учреждениях, училища монгольского и русского языков. Туда отдавались в большом количестве молодые люди, учились там, и с тех пор как некоторые из них стали ходить в русские высшие учебные заведения, народные нравы в настоящее время продолжают улучшаться, становясь совсем похожими на таковые внутри страны’ [8: 79].

Если бы Н. Н. Поппе сделал подстрочный перевод, он выглядел бы примерно так: ‘После 1773 года, в каждой местности выстраиваясь дацаны, в каждом из них всякого рода божеской религии и, даже в государственных местах монгольский русский языка школы во множестве открываясь, в них, в большом количестве включенные молодые люди учиться и даже некоторые из них, ходя в русские высшие учебные места в настоящее время народные нравы, становясь похожими внутренней страны улучшаясь пребывают?’.

Дословно переведенный на типологически другой по своему строю язык данный отрывок, безусловно, и воспринимается как не-

что несуразное, хотя для знатоков старомонгольского языка в оригинале это вполне нормальное изложение. Так, известный монгольский ученый Б. Ринчен полагал, что такой стиль является изысканным, и ошибочно полагал, что бурятским авторам почти не был известен язык светской монгольской литературы и что они владели лишь письменным языком сутр, которым переведены буддийские сочинения, изданные в дацанах. “Материалы Жамцарано показывают, как упорно он работал, — пишет Б. Ринчен, — над преодолением бурятизмов и оборотов “языка сутр”, овладевая под руководством ургинских стилистов лексикой и фразеологией монгольского литературного языка” [9: 49]. Видимо, ученый полагал, что такими же длинными конструкциями должны переводиться и предложения в художественных произведениях русских писателей. Вместе с тем это может иметь и нежелательные последствия. Это хорошо проиллюстрировано в исследовании Ц. Ц. Бальжинимаевой “Лингвостилистические особенности перевода художественных произведений с русского на бурятский и монгольский языки” [2: 26–30].

Автор в сопоставительном плане рассматривает перевод одного ССЦ из романа Н. Островского “Как закалялась сталь”. Писатель в начале ССЦ дает три коротких предложения: “Подходя к дому, Тоня увидела сидящих в саду Лизу Сухарько, Нелли и Виктора Лецинских. Виктор читал. Они, видимо, ожидали ее”. То же находим у бурятского переводчика Б. Абидуева: “*Тоня гэртээ дүтэлжэ ябахадаа саад соо һууһан Лиза Сухарькое ба Лецинскийн Нелли Виктор хоёрые хараба. Виктор уншажа һууба. Тэдэнэр Тоншин ерэхые хүлээжэ һууһан хэбэртэй*”.

Б. Ринчен объединяет все три предложения в одно простое предложение с условным деепричастным оборотом, который не задан оригиналом. Значение предположения, выраженное вводным словом *видимо*, в переводе не выражено:

Тоня гэртээ ирэхэд цэцэрлигийн дотор суусан Сухарькогийн хүүхэн Лиза, Лецинскийн Нелль бас бичиг уншиж байсан Виктор үзвэл тэд нар хүүхний харьж ирэхийг хүлээж суусан байлаа.

По сравнению с переводом Б. Абидуева в последнем отрывке совершенно не ощущается ни стиль, ни ритм повествования Н. Островского. Этому способствует и излишнее употребление слова *хүүхэн* (два раза), *харьж ирэхийг* вместо *Тонягийн ирэхийг*.

Из сопоставления этих переводов видно, что бурятский перевод по стилю ближе к оригиналу, чем монгольский; в нем чувствуется

присутствие лапидарного, ясного и четкого стиля Н. Островского. И одну из причин такой удачи можно видеть в том, что переводчик обращал большое внимание на адекватную передачу ССЦ оригинала, на его шлифовку с тем, чтобы оно производило такое же впечатление, как и оригинал. Поэтому после первого перевода необходимо вернуться к нему и в рамках ССЦ внимательно рассмотреть каждую фразу, оборот речи, слово, выявить и исправить упущения, пропуски, неверно понятые места.

В подстрочном переводе ССЦ из летописи В. Юмсунова, синтаксически адекватный перевод его на русский язык не представляется возможным ввиду того что в русском языке отсутствует подобная синтаксическая конструкция, как старомонгольский сложный синтаксический комплекс (ССК). В предисловии к переводам летописей Т. Тобоева и В. Юмсунова на русский язык Н. Н. Поппе указывает: "...мы стремились дать максимально точный перевод. Перевод стилистически не отделан сознательно, так как нам не хотелось слишком отдаляться от подлинника. Единственное, что мы себе позволили, — это передачу очень длинных предложений подлинного текста рядом более кратких (курсив наш. — Л.Б.). Это нам казалось целесообразным в целях большей удобочитаемости перевода" [8: 3].

Дело в том, что в старомонгольских сложных синтаксических комплексах задействованные в них субъекты действия оформляются в именительном падеже и вместе с зависимыми словами в переводе могут трансформироваться в простые предложения. В приведенном выше ССК о духовных и светских училищах имеется шесть таких субъектов-подлежащих: *dačang-ud* 'дацаны', *burqan-u šašin-u surγuli-nar* 'буддийские духовные училища', (*mongγol ros kelen-ü*) *surγuli-nar* 'училища (монгольского и русского языков)', *jalayus ber* 'молодые люди (молодежь)', *jarim-ud anu* 'некоторые из них', (*jon-u*) *aburi jan anu* '(народные) нравы'. Каждый субъект вместе со своей группой оформляется в виде простого предложения, причем конечный инфинитный глагол такой группы трансформирован в личный глагол. Предикативные основы данных предложений предстают в таком виде:

dačang-ud bariγdaǰu — были выстроены дацаны;

(*burqan-u šašin-u*) *surγuli-nar (negegeǰü)* — возникли (духовные) училища;

(*mongγol ros kelen-ü*) *surγuli-nar negegeǰü* — открылись училища (монгольского и русского языков);

jalayus ber oruylaydun surulcaqu — (туда) отдавались молодые люди;

jarim-ud anu (degedü suryuli-narun yaĵara) yabulcaysayar — некоторые из них стали ходить (в высшие учебные заведения);

(jon-u) aburi jan anu sayijiruysayar bayinam — (народные) нравы продолжают улучшаться.

В личные глаголы или в сочетания глаголов в личной форме с инфинитивом трансформированы соединительные деепричастия *bariydaju*, *negegedjü*, сочетание слитного деепричастия с формой на *-qu* — *oruylaydun suralcaqu*, продолжительное деепричастие *yabulcaysayar*. Финитное сказуемое, выраженное сочетанием продолжительного деепричастия со вспомогательным глаголом — *sayijiruysayar bayinam*, оформлено составным сказуемым, образованным глаголом в личной форме (с ослабленным лексическим значением), играющим вспомогательную роль, и инфинитивом другого глагола, выражающим основное значение этой конструкции — ‘продолжает улучшаться’.

Поэт С. Шервинский при переводе периода из поэмы Х. Намсараева “Слово старого гэлэна” также трансформирует инфинитные глагольные формы старомонгольского языка в личные формы глагола: *баруун хүрэн ошожо* — воспитывался (при дацане), *лама боложо* — стал ламой, (*барас шэнгээр*) *бажаганажа* — (как барс на людей) порывивал, (*луу шэнгээр*) *лужаганажа* — (как лютый дракон) покрикивал и т. д.

То, что С. Шервинский использует тот же способ перевода инфинитных форм, что и Н. Н. Поппе, свидетельствует о том, что последним был выбран наиболее верный путь перевода характерных для старомонгольского языка форм.

Выражение мыслей посредством громоздких конструкций, которые неискушенному читателю представляют известную трудность для правильного и быстрого восприятия текста, в селенгинских и особенно баргузинских летописях встречаются значительно реже, чем в хоринских. Но если они употребляются, то переводятся в большинстве случаев так же, как и у Н. Н. Поппе, с расщеплением их на краткие предложения. Так, в летописи Дамби-Жалсана Ломбоцыренова имеется следующий ССК: «*qoridai, ikirid, buljad yurban eĉige-yin üri ündüsün bayiyal-i toĵoriju küsiqülen bayiday ayula qada oi usun-bar nutuylaĵu, ködüge ba usun-u angÿuri-bar amis-ıyan teĵiyejü, burqan nom blam-a quvaray šasin ĉayan-u yosu ülü medekü, caĵaja ...*

terigüten-e böge iduyan-iyar takiyulju mörgükü sitülye-tei nada kiçi boljuу-a ügei zerlig ulus aуsan bayin-a» [6: 6].

В переводе Б. Д. Доржиева и Ш. Б. Чимитдоржиева этот ССК предстает в таком виде: ‘Потомки Хоридоя, Эхирита и Булагата жили в лесах, горах и степях вокруг Байкала, добывая еду на пропитание охотой и рыболовством. Они не были знакомы с религиозными книгами, не знали лам, хуvaraков, религию. Не было у них писанных законов. У них господствовал шаманизм, проповедовали они шаманские верования, проводили молебствия в лесу и горах, у воды’ [3: 104].

Как видим, в переводе ССК делимитирован на 4 самостоятельных предложения, при этом инфинитные глагольные и другие формы переведены личными глаголами.

В книге “*Бурядай түүхэ бэшэгүүд*” (‘Бурятские исторические хроники’) [15] этот ССК переложен на современный бурятский язык следующим образом: «*Хоридой, Эхирэд, Булгад гурбан эсэгийн үринэр Байгалые тойрожо, хада уулаар, ой тайгаар, тала дайдаар, уһа мүрэнүүдые зубшан нютагладаг бэлэй. Ан гүрөөл агнажа, загана барижа амидардаг, бээ тэжээдэг бэлэй. Эртэ сагта тэдэндэ бурхан ном байгаагүй, хубарагууд байгаагүй, сааза хуули үгы һэн. Уула хадада, ой тайгада, уһанай дэргэдэ бөө удаганда мүргэжэ, шүтэжэ ябадаг зон байһан гээшэ*» [15: 127]. В данном переложении рассматриваемый ССК предстает также в виде четырех отдельных предложений.

Как книга “*Бурядай түүхэ бэшэгүүд*” (1992), так и переводы бурятских летописей “Бурятские летописи” (1995) преследуют прежде всего цель ознакомить широкие читательские круги с летописным наследием бурят. Поэтому летописи не транслитерированы латиницей, в переводах и переложениях пропущены трудные и непонятные места. Например, в приведенном отрывке при переводе и переложении не отражены такие выражения: *bayiyal-i toyoriju küsiqulen bayiday* (*aуula qada oi*); *čayan-u yosu*; *aq-a yeke-či ügei*; *nada kiçi boljuу-a ügei zerlig ulus aуsan bayin-a*. Кроме того, в тексте появляются не заданные оригиналом лексемы (степи) (вокруг Байкала).

В переводах же Н. Н. Поппе пропуски и опущения не допускаются, трудные места все же находят свое отражение в переводе. Например, в пятом абзаце первой главы говорится: «*tere anu degereki 9 köke mongyol jon-iyar daqayulan yabuju: kitad töbed terigülen barayun ba: qoyitu жүг-үд-ун eris-үн 13 qayan orud-i medel-degen*

abuγad: ner-e aldar anu edüge tuqayilabasu: edüge-yin yirtinčü-yin aǰıy-a yebropu qoyar ʎaǰar-tur degürin aldarsıju: tedeger orud-tur yeke erke medel-tei boluγsan aǰıyü:» [1: 95].

Рассмотрим переложение на современный бурятский язык (Л. Д. Шагдаров, Л. Б. Бадмаева): “Тэрэнь хүхэ монгол зоноо дахуулан ябажа, Хитад, Түбэд, мүн баруун, хойто зүгэй 13 хаан оронуудые мэдэлдээ абаад, мүнөөнэй Ази, Европоор дүүрэн алдаршажа, тэдэ оронуудта ехэ эрхэ мэдэлтэй болоһон байна” [15: 36].

При сличении с оригиналом выясняется, что опущены из текста следующие слова и словосочетания: *degereki 9, terigülen, eris-ün, edüge tuqayilabasu, edüge-yin yirtinčü-yin, qoyar ʎaǰar-tur*.

Рассмотрим, как этот ССК переведен Н. Н. Поппе: “Он повел за собою свой народ вышеупомянутых девяти синих монголов, подчинив своей власти Китай, Тибет и прочие тринадцать царств героев запада и севера. Слава о нем прогремела примерно повсюду в Азии и Европе нынешнего мира, и он получил большую силу и власть над теми странами” [8: 44].

Как видим, пропущенные при популярном переложении на современный бурятский язык слова и словосочетания получили соответствующие переводы: *degereki 9* — вышеупомянутые 9, *terigülen* — прочие, *eris-ün* — героев, *edüge tuqayilabasu* — примерно, *edüge-yin yirtinčü-yin* — нынешнего мира.

Дело в том, что некоторые из этих слов трудно правильно воспринять, потому что они, как видно из перевода, представляют собою переименованные авторами летописей написания старомонгольских слов. Так вм. *eris-ün* должно быть *eres-ün* ‘молодцов, храбрецов’, вм. *terigülen* — *terigüten* ‘другие, прочие’.

Н. Н. Поппе, безусловно, обладал обширными познаниями в области монголистики, к тому же он глубоко вник в тексты бурятских летописей, будучи в экспедиции в Аге (1930 г.) он общался с учеными ламами, возможно, он консультировался с ними по языку бурятских летописей, поэтому его переводы являются наиболее полными, точными и адекватными.

Для достижения высокого качества перевода, нам представляется, что необходимо творчески совмещать элементы частного решения проблем перевода на уровне слов и словосочетаний, и целого текста (перевода всей мысли на уровне предложения, сверхфразового единства, всего текста в целом). В процессе перевода языковые особенности и смысловое содержание текста постоянно вносят от-

дельные коррективы в работу переводчика, что позволяет ему добиваться еще большей точности и выразительности. Не менее важно умение вникнуть в смысловое содержание единицы перевода (сегмента предложения, синтагмы), правильно понять мысль автора и точно выразить ее на другом языке.

Таким образом, следует подчеркнуть, что коммуникативная сущность текста делает его открытым для всех участников акта коммуникативной деятельности, коммуникативной ситуации и среды существования текста. Она является основой всей совокупности его функций (социальной, системной, регулятивной, когнитивной, эмоциональной, референциальной; способа хранения и передачи информации, отражения психической жизни индивида, продукта определенной исторической эпохи, формы существования культуры, отражения определенных социокультурных, этнокультурных традиций и др.). Признание коммуникативной сущности текста вводит его в круг интересов всех гуманитарных наук.

Литература

1. Бадмаева Л. Б. Летопись Вандана Юмсунова — памятник письменной культуры бурят XIX в. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2007. 394 с.

2. Бальжинимаева Ц. Ц. Лингвостилистические особенности перевода художественных произведений с русского на бурятский и монгольский языки. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2006. 108 с.

3. Бурятские летописи / сост. Ш. Б. Чимитдоржиев, Ц. П. Ванчикова (Пурбуева). Улан-Удэ, 1995. 198 с.

4. Крупнов В. Н. В творческой лаборатории переводчика. М.: Междунар. отношения, 1976. 192 с.

5. Летопись баргузинских бурят. Тексты и исследования издали А. И. Востриков и Н. Н. Поппе. М.; Л.: Изд-во АН СССР, 1935. 75 с.

6. Летописи селенгинских бурят: Хроника убаша Дамби Джалцан Ломбоцэрэнова (1868 г.) // Тр. Института востоковедения. XII. М.; Л.: Изд-во АН СССР, 1936. 55 с.

7. Летописи хоринских бурят. Вып. 1. Хроники Тугултур Тобоева и Вандана Юмсунова. Текст издал Н. Н. Поппе // Тр. института востоковед. IX. М.; Л.: Изд-во АН СССР, 1935. 172 с.

8. Летописи хоринских бурят. Хроники Тугултур Тобоева и Вандана Юмсунова / пер. Н. Н. Поппе // Тр. Института востоковедения. XXXIII. М.; Л.: Изд-во АН СССР, 1940. 106 с.

9. Ринчен Б. К истории перевода в Монголии // Мастерство перевода. Улаанбаатар, 1988. № 5. С. 49.

10. Хундаева Е. О. Некоторые аспекты перевода с монгольского языка на русский // Языки и письменные источники монгольских народов: материалы междунар. конф., проведенной в рамках Конвента монголов мира (Улан-Удэ, 14–18 июля 2010 г.) / отв. ред. Л. Д. Шагдаров, Л. Д. Бадмаева. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2010. С. 241–247.

11. Цыдендамбаев Ц. Б. Бурятские исторические хроники и родословные. Улан-Удэ: Бурят. кн. изд-во, 1972. 662 с.

12. Цыдендамбаев Ц. Б. Переводы художественной литературы с русского языка на бурят-монгольский // Свет над Байкалом. Улан-Удэ, 1955. С. 142.

13. Чагдуров С. Ш. О выразительности слова в художественной прозе. Улан-Удэ: БКНИИ, 1959. 89 с.

14. Шагдаров Л. Д., Бадмаева Л. Б. Особенности текстовой организации бурятских летописных текстов // Языки и письменные источники монгольских народов: материалы междунар. конф., проведенной в рамках Конвента монголов мира (Улан-Удэ, 14–18 июля 2010 г.) / отв. ред. Л. Д. Шагдаров, Л. Д. Бадмаева. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2010. С. 99–106.

15. Бурядай түүхэ бэшэгүүд / сост. Ш. Б. Чимитдоржиев. Улаан-Үдэ: Бурядай номой хэблэл, 1992. 240 н.

16. Poppe N. Reminiscences. Bellingham, 1983. С. 279.

АМАН ЗОХИОЛ ДАХЬ ХҮҮХДИЙН ҮНЭЛЭМЖ, ХАНДЛАГА (ОЦЕНКА И ОТНОШЕНИЕ К ДЕТАМ В УСТНОМ НАРОДНОМ ТВОРЧЕСТВЕ)

© Ч. Бямбацэцэг

Монгольский госуниверситет образования

Монголия, г. Улан-Батор, VIII хороо, Бага тойруу-14

byambatsetseg@msue.edu.mn

Аннотация. Монгол ардын аман зохиолд амьтан юмс үзэгдлийг хүнчлэх сэтгэлгээний онцлог элбэг туссан нь тэдгээрийн дүрслэлийн гүн бүтцэд хүн байдагтай холбоотой. Монголчууд хүн, түүнийг танин мэдэх өөрийн гэсэн арга ухаантай ард түмэн болох нь өвгөд дээдсийн минь бидэнд уламжлан үлдээсэн өв сангаас тодорхой харагдана. Ийм ч учраас аман зохиолд туссан монгол хүүхдийн шинж чанар ямар зүйлтэй уялдан холбогдож, монгол соёл, сэтгэлгээний онцлогийг тээж, монгол хүн болж өсөн торниж буйг тодруулахын тулд монгол хүүхдийн дүр дүрслэлээс эцэг эх, ах дүүс, хүүхдэд туслагч бусад баатруудын хоорондын харилцаа, хандлагаас монголчууд үр хүүхдээ хэрхэн үнэлж, хайрлаж ирсэн талаар өгүүлэх болно.

Ключевые слова: үнэлэмж, хандлага, харьцаа, харилцаа, эцэг эх үр хүүхдийн хандлага, бусад хүмүүсээс хүүхдэд хандах нь.

ASSESSMENT AND ATTITUDE OF CHILDREN IN FOLKLORE

Ch. Byambatseg

Mongolian State University of Education

Mongolia, Ulan Bator, VIII khoroo, Baga toyruu-14

byambatsetseg@msue.edu.mn

Abstract. Thinking characteristics to personify animals, things and acts are commonly observed in Mongolian folklore and this relates to describing the human represented by other forms. As the traditions, customs and heritages of our ancestors, Mongolian people have their own method and wisdom to know humans. Therefore, I will consider how the Mongolian people assess and love their children taking into account the description of Mongolian children and relations and attitudes between their parents, relatives and other characters to identify what is related to characteristics of Mongolian child in the folklore and what is the Mongolian culture and thinking characteristics and how to grow as the Mongolian person.

Keywords: Assessment, attitude, behavior, relations, attitude of parents and children and attitude of other people to child.

Үнэлэмж гэдэг үг нь эртний грекийн “axia” (үнэт зүйл) гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд орос хэлний “ценность”, англи хэлний “value” гэсэн үгтэй утга дүйдэг ажээ.

Үнэлэмжийн тухай онол нь орчин үеийн философийн салбарууд дотор үүссэн хугацаагаараа харьцангуй шинэд нь ордог боловч байр суурь, нөлөөгөөрөө тэргүүн эгнээнд байдаг салбарын нэг юм. Үнэлэмж бол ямар нэг юмны үнэ цэн, утгат чанарыг тэмдэглэдэг ойлголт бөгөөд үнэлэмжийн талаарх ойлголт олон янз байдаг.

Судлаач Ц. Гомбосүрэн “Үнэлэмж бол тухайн субъектээс байгалийн юм уу, нийгмийн тодорхой үзэгдэлд бурхан тэнгэрлэгээр юм уу, бурхан тэнгэрлэг бишээр төсөөлөгддөг, ямар нэг далдлаг хүчинд өгч буй үнэлгээ мөн [1], судлаач Г.Чулуунбаатар “Байгаль, нийгэм, хүний амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч субъектийн зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл ажиллагааны нийлбэр цогцыг хамгийн ерөнхий байдлаар нь үнэлэмж хэмээх ойлголтоор илэрхийлж болно [2] гэж тодорхойлжээ.

Профессор С. Энхбаяр “Үнэлэмж бол логик бүтцээрээ гурван чухал элементтэй. Үүнд: 1. Үнэлэгч субъект. Энэ бол тухайн бодгаль юм уу бүлэг хүн, байгууллага, эсвэл улс орон бүр цаашилбал хэд хэдэн улс, ард түмэн, нийт хүн төрөлхтөн гэх мэт мөн. 2. Үнэлэгдэгч объект. Энэ бол материаллаг ба санаалаг, бодитой ба уран сэтгэмжийн, ерийн ба ер бусын гэх мэт зүйл мөн. 3. Үнэлгээ. Энэ бол холбогдох тодорхой объектийн талаар тухайн субъектэд төрж буй сэтгэгдэл, бишрэл юмуу жигшил, дүгнэлт, цэгнэлт зэрэг мөн. Үнэлэмжийн үр дүнд бий болдог онолын гол категорууд нь сайн ба муухай, буян ба нүгэл, ашигтай ба ашиггүй, ёстой ба ёстой биш, шударга ба шударга биш, үнэн ба худлаа гэх мэт ойлголт мөн” [3] болно гэж үнэлэмжийн тухай өгүүлсэн байдаг.

Эндээс үнэлэмж гэсэн ойлголтын талаарх эрдэмтэн судлаачдын үзэл санаануудыг нэгтгэн авч үзвэл үнэлэмж нь бие даан оршдоггүй, тухайн хүний аливаа зүйлийг үзэх үзэл бодол, мэдрэмжийн асуудал бөгөөд субъектээс тухайн зүйлийг үнэлсэн үнэлэмж, хандлага, харилцаа гэсэн өргөн утга агуулгын хүрээнд томьёолжээ. Үнэлэмж бол голдуу нийтээр хүлээн зөвшөөрдөг, үйл хөдлөлдөө дагаж мөрддөг нийтлэг тогтсон жишиг, итгэл үнэмшил, эрхэм дээд үзэл санаа юм. Үнэлэмж бол бодит зүйл биш, хүний хүсэл эрмэлзэл, ухамсартай холбоотой, тодорхой утга заадаг.

Тухайн үндэстний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан онцлогоос шалтгаалж юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарын тухай сэтгэлгээний тогтсон хэв шинж, жишиг хэмжүүр бий болдог байна. Энэ нь тухайн ард түмний юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарт өгсөн үнэлэмж байдаг. Ийм үнэлэмж нь сайн-муу, сайхан-муухай, таатай-таагүй, зохистой-зохисгүй гэх мэтээр юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар зэргийг эерэг, сөргөөр нь эсрэгцүүлэн айчилсан байдаг онцлогтой билээ.

Аман зохиолын төрөл зүйлд туссан монгол хүүхдийн үнэлэмж, монголчуудаас үр хүүхдэдээ хэрхэн хандаж ирснийг эцэг эх, хөндлөнгийн хүмүүс, адгуус амьтдаар төлөөлүүлэн аман зохиолын жишээн дээрээс авч үзэж байна.

Монголчуудын сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд хүнээр хүн хийх асуудал нь өрх гэр бүлийн гишүүдийн хувьд нэн чухал ажилд тооцогдох хэрэг юм. Аав ээжийгээ эрхэмлэн хүндлэх нь монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн гол цөм нь юм. Эцгийг “гал”, эхийг “ус” гэдэг болохоор үр хүүхдийг нь “гал”, “ус” хоёрын үр гэнэ. Тэгэхээр үр хүүхэд нь эцэгтээ их наалдаж эрхэлбэл галд шатах мэт, эхдээ нялуурч эрхэлбэл усанд живэх мэт болно. Эцгээсээ бие сэтгэлээр холдвол гаднах хүйтэнд галаас холдох мэт даарна, эхээсээ бие сэтгэлээр холдвол шим шүүснээсээ салсан ургамал мэт гандана гэж тайлбарладаг ардын мэргэн ухаан тун ч гүн гүнзгий агуулгатай [4] ажээ.

Ер нь монголчуудын гэрийн хүмүүжлийн сургаал нь гүйцэтгэх үүргийнхээ хувьд эцэг, эх хоёр тодорхой ялгаатай байсан төдийгүй арга барилын хувьд ч өөр өөрөөр ханддаг байсныг үлгэр домогт ийн өгүүлжээ. “Ухна унасан баатар” үлгэрт “...*Охин өөрийн мөрөөдлийн залуугаа хартал үзэшигүй муухай нусгай бор хүү байжээ. Охин хүүг хараад маш их уйлж, хаан аав, хатан ээж минь маш их загнана. Чи одоо түргэн яв гэж хөөжээ. Нусгай бор хүү явсангүй гэнэ. Хаан аав нь охиноо гэрээсээ хөөчихөж гэнэ. Харин хатан ээж нь хоёуланг нь үнсээд өлсөж ядрахын цагт хэрэглээрэй гэж тэр хоёрт нэг алтан ембүү өгчээ*”.

Энэхүү үлгэрээс харахад эцэг хүн гол төлөв буруушаах, загнах зэрэг түр зуурын шинжтэй хориглох аргыг хэрэглэдэг бол эх хүн голдуу ийм аргын эсрэг байж, эе эвтэй зөөлөн хандаж, амьдралд авах гээхийн ухаанаар ханддаг ажээ.

Монголчууд “хал нь гаднаа хайр нь дотроо” гэгч зарчмыг баримтлан үр хүүхдээ хүмүүжүүлж, хайрлан өсгөж иржээ. Ийнхүү

үр хүүхдээ хайрлан хамгаалж ирснийг үлгэр, домог, баатарлаг туульсийн зохиолоос олонтоо үзэж болно. Тухайлбал: “Алтан мөнгөн аргай”, “Хүрэл хүү”, “Чихэн чинээ хүү”, “Ганц үст галзуу шар баатар” зэрэг үлгэрт эцэг эхийн хайр, элбэрэлт нийгүүлсэнгүй сэтгэл, үр хүүхдэдээ хандаж буй хандлага илрэн гарч байна. Тухайлбал: “Анчин хүү” үлгэрт хүү, аав ээждээ энэ нутгийн ан гөрөөс ховордож эхэлснийг дуулгаад анд явах гэхэд эцэг эх нь хэдийгээр хориглосон ч *“Хүний газар болгоомжтой явж, бид хоёрыг үхэхээс өмнө эсэн мэнд л эргэж ирдэг юм шүү дээ”* гэж захиж буйгаас эцэг эхийн агуу их хайрыг мэдэрч болох юм.

Монгол ардын баатарлаг туульд хар бага насандаа дайсантай тулалдах, заяаны ханиа олж авахаар алс хол явахыг санаархах үед хаан аав, хатан ээж нь *“нас чинь бага, цус чинь шингэн”* гэх зэргээр хориг саад хийвч баатарлаг зоригтой үрс нь өдрийн сайн, сарын сайныг хоног тоолон арай хийн өнгөрөөж эх, эцгийн хориг саадыг үл тоон алс холын аян дайнд мордож буйгаар баатарлаг туульд өгүүлдэг.

Монголчууд эцгийн талын төрлийг хусавч үл арилах ясан төрөл, эхийн талын төрлийг “шахавч үл ширгэх цусан төрөл” гэж нэрлэдэг бөгөөд ясан төрөл гэж нэрлэдэг эцгийн талын төрлийг чухалд үздэг байна. Хүний цусан төрлөөс ясан төрлийг илүү үзэж, хүүхэд эцгийн овгийг авч, эцгийн гал голомтын үргэлжлэл болох ажээ. Үр хүүхдээ төдийгүй хамаатан саднаа “яс махны тасархай” хэмээн үздэг монгол сэтгэлгээний өвөрмөц онцлог бидэнд уламжлагдан иржээ. Хамгийн гол нь яс махны тасархайг хүн шиг хүн болгоход ясан ч бай, цусан ч бай төрлийн хамаатан саднууд хамтран хүчин зүтгэж үр хүүхдээ хүмүүжүүлж иржээ.

Монголчууд үр хүүхдэдээ хэрхэн хандаж ирсэн нь монгол ардын үлгэрийн төрөлд илүү ил тод ажиглагддаг юм. Ардын үлгэрт хүүхдэд эерэгээр хандаж, хүүхдийг хайрлаж ирсэн хүмүүс бол нас дээр гарсан өвгөн [Өнчин Бүш хүү], хоёр яргачин [Гал улаан хаан], сайн санаат эрлэгийн элч [Түмэн настай Түнжинхүү], адуучин өвгөн, цагаан сахалтай өвгөн [Баянжаргал] зэрэг яс махны тасархайнаас ангид хүмүүс хүүхдэд сайхан сэтгэлээр хандаж, их үйл хэргийг бүтээхэд нь тусалж буйгаар үлгэрт гардаг.

Хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл болох монгол ардын баатарлаг туульд хүүхдэд туслагч, хүүхдийг хамгаалагч өвгөн адуучин Агсалдай, үхэрчин зэрэг настан буурлууд, бэргэн эгчийн дүр цөөнгүй тохиолдож байна.

Эрдэмтэн Б.Катуу “Баатарлагийн туульст хөлөг баатрын тухай өгүүлэхээс урьд түүний адуу малыг малладаг Агсахал өвгөн болон хүүг ямагт дүрсэлсэн байдаг нь эрэлхэг зоригт эрхэм баатар эрсийн баатарлаг үйлс, ялалт амжилт тэргүүтэнтэй “амин хүйн” холбоотой байж, аргамаг хүлгийнх нь хүч тарга, ус бэлчээр, уяа сойлго зэргийг нарийн тохируулдаг онцгой үүрэг, ач холбогдлын илэрхийлэл бөгөөд Агсалдай өвгөн хэмээн тус тус өгүүлж байгаа нь бидний сонирхлыг зүй ёсоор татаж байна. Тэрээр ”Агсахал” гэдэг үгийн тухайд эрдэмтэн О.Сүхбаатар бичихдээ “Аг” түрэг хэлний “аг” буюу буурал, цагаан гэсэн үг, эрдэмтэн Х.Лувсанбалдан, Ц. Шагдарсүрэн нэр “Агсахал” гэдэг нэрийг баахан хувирган Агсалдай гэх мэтээр нэрлэсэн тохиолдол ч гардаг. Эрдэмтдийн энэ дүгнэлтүүдээс ажиглахад амьдралын баялаг туршлагатай, “хал үзэж хашир суусан” настан буурлуудаар адуугаа маллуулж, ашиг шимийг нь хүртэж байсан нь тодорхой харагдаж байна” [5] гэж Агсалдай хэмээх үгийн гарлыг бусад эрдэмтдийн саналтай өөрийн саналыг нэгтгэн судалгааны үндэслэлтэйгээр эш татаж тайлбарласан байна.

Аман зохиолд олонх бэргэн эгч нар муу санаатай, атаа хорсол ихтэй, хувирахдаа тайгын хар, шар үнэг болж хувирах байдалтайгаар дүрслэгдэх боловч ”Хөшөө чулуун зүрхт Хүвэй Буйдар хүү” тууль дахь бэргэн эгч төрсөн ахаас нь илүү сайхан сэтгэлтэйгээр дүрслэгдсэн байдаг.

“Өвгөдийн үг өв, хуучны үг хууль. Хөдсөн дээлтэй, хөх царайтай өвгөдийн үлдээсэн өв тэнгис далайн ус мэт шавхагдашгүй. Өвийг үл тоон хэрэгсэхгүй орхивол зөвийг ололгүй төөрөлдөн, буруу замаар хадуурна. “Өвгөд ирвэл үг нэмнэ”, “Хүүхэд ирвэл Хүч нэмнэ”. Өвгөдийн нэмж байгаа үг амьдралын ухааны торгон шүүлтүүрээр дамжаад ирсэн учир хаях юмгүй цэвэр, өөлөх юмгүй үнэн. Тунгаан бодсон өтгөсийн үг тулхтай бөгөөд тууштай. Зөвд хүч нэмнэ, бурууд хаалт болно. Залуу хүн хүчтэй, настай хүн ухаантай” [6] гэж өвгөдөөс сурах юм их болохыг залуу үедээ үлгэр домгоор дамжуулан сургаж ирснийг үеийн үед санаж явууштай хэрэг юм.

Хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл болсон монгол ардын үлгэрийн төрөлд хүүхдэд туслагч олон амьтан бий бөгөөд адгуус амьтны үлгэрт таван хошуу малыг сайн сайхны бэлгэдэл болгон дүрсэлсэн бол шидэт үлгэр ба баатарлаг тууль дахь хүүхдийн их үйл хэргийг морьгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Баатарлаг

туульд морины дүр нь хурдлан давхих ид шидтэй, ер бусын хүч чадалтай, эзэнтэйгээ ярилцдаг, эзэндээ зааж зөвлөдөг, эзэндээ тангаргалдаг, эзэндээ заяаны ханийг нь олж өгдөг ид шидтэйгээр дүрсэлсэн нь алс холын замд ижилдэн дасаж, эзэн болсон баатар эрээ хамгаалж ирсэн, хүлэг сайн морины жишээг олонтоо дүрсэлсэн нь хүүхдэд туслагчийн шинжтэй, хүүхдийг хамгаалагчийн үүрэгтэйгээр баатарлаг туульд гарч байна.

Таван хошуу малын бусад төрөл болох бухан бяруу [Алтан Мөнгөн аргай], шар үхэр [Шар үхэрт хүү] нь харгис хэрцгий хаан, муу санаат түшмэлийг ялан дийлэх их хүч, ухаан хайрлаж буйгаар үлгэрт гарч буй нь малчин хүний малдаа хайртай сэтгэлээ үлгэр домогтоо эерэгээр дүрсэлж харуулж буйн жишээ юм.

Их үйл хэрэг, шударга бус үйл хэргийн төлөө тэмцэж буй хүүхдэд таван хошуу малаас гадна хангарди шувуу [Бух хар нохой хийгээд бух хар шувуу], [Гал улаан хаан], Матар толгойт, арслан толгойт хүн бус төрлийн амьтан [Баянжаргал], могой, шаазгай [Хүрэлдэй], чоно [Өнчин Бэглэг] зэрэг амьтад хүүхдэд эерэгээр хандаж, дайснаа дарахад нь их хүч өгч, ид шидийн хүчээр хүүг ялалтад хүргэж буй нь хүүхдийг эцэг эх, өвгөд дээдсээс гадна амьтад хүртэл хайрлаж, хамгаалж ирсний бодит жишээг үлгэр, домгоос ухаарч болохын жишээ арвин их ажээ.

Шидэт үлгэр дэх өнчин ядуу хүүг “Янгирцаг болсон эмээлтэй, ясан хэдрэг болсон хашин хар морьгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Таван хошуу малын нэг болох адуун сүргээ эрхэмлэн хүндэлж, үлгэр домогтоо хүртэл найман хөлтэй, хүний хэл мэддэгээр дүрслэхийн зэрэгцээ эзэндээ үхэн үхтэл үнэнч байж, их тусыг бүтээж буйгаар үлгэрт дүрсэлсэн байдаг. Тухайлбал, “Алтан мөнгөн аргай” үлгэрийн найман хөлтэй найр алаг морь, “Хаан, хүргэн, хангарди шувуу”-ны үлгэр дэх шарга морь нь эзнээ гүн нүхэнд унаад аюулд орсон үед нь зуун алд мөнгөн дээс томуулан нүхнээс гарган авч буй хэсгээс үнэнч хүлэг морины дүрийг харж болно.

Аль ч улс үндэстэн үр хүүхдээ эрхэмлэн дээдлэх нь зүйн хэрэг боловч монголчууд бид үр хүүхдээ ямагт эрхэмлэн хүндэлж “Үртэй хүн жаргадаг, үндэстэй мод нахиалдаг” гэдэг яах аргагүй үнэн үг билээ. Айл бүхэнд аз жаргал, баяр баяслыг бэлэглэж байдаг, нандин эрдэнэ хүүхэд билээ. Гэр бүлийн аз жаргал, эх орны ирээдүй, хүн төрөлхтний залгамж үе хүүхэд хэмээх ариухан сайхан ертөнцийг хайрлаж, тэднийгээ оюун ухаан, бие бялдраар өв тэгш хүн болгож,

өсгөж хүмүүжүүлэх, их үйл хэргийг үргэлжлүүлэн монгол өв соёлоо тээгч иргэнийг бий болгоход ардын аман зохиолын үүрэг их болохыг ухаарч, үр хүүхдэдээ монгол соёл, монгол зан заншлаа өвлүүлэн үлдээх үүрэг хариуцлагыг насанд хүрэгчид бид хүлээх ёстой билээ.

1. Монгол хүний сэтгэхүйд эрх чөлөө, шударга ёсны үзэл санаа хүндтэй байрыг эзэлдэг. Монголчууд хэзээнээс задгай эрх чөлөөтэй байж, хүссэн зүгтээ дураараа нүүдэллэн аж төрж ирсэн уламжлал бидний мах, цусанд, генид шингэсэн байдаг. Тийм ч учраас монгол хүүхэд өсч томрон эрийн цээнд хүрсэн үеэсээ эрх чөлөө шударга ёсны төлөө тэмцэгч хүүхэд болж өсөж буйг монгол ардын үлгэр, домог, баатарлаг тууль дахь өнчин ядуу хөвгүүдийн дүрээс тодорхой харж болно.

2. Монголчууд хэзээнээсээ эд хөрөнгийг адаг баянд авч үзэж, үр хүүхдээ эрхэм баянд үзэж ирснийг ардын аман зохиолын бүхий л төрлөөс үзэж харах боломжтой юм. Хүүрнэсэн өгүүлэмж бүхий аман зохиолын төрөл болох үлгэр, аман яруу найргийн төрөл болсон монгол ардын туульсийн баатраас монгол хүүхдэд хандаж буй эцэг эх, бэргэн эгч, адуучин өвгөн, жирийн ядуу эмгэн, хүлэг морьд зэрэг хүн ба хүн бус төрөлт араатан жигүүртнүүд бүгд л хүүхдэд эерэгээр хандаж байна.

3. Монгол ардын үлгэр, туульд хүүхдэд сөргөөр хандаж, биелшгүй хүнд хэцүү даалгавар өгч алс хол, аян дайнд явуулах үед өнчин ядуу хүүхдүүд тухайн нөхцөл орчиндоо “амархан дасан зохицож, идээшин амьдрах чадвартай” болох нь монгол хүүхдийн овсгоо самбаа, эр зориг, тэсвэр хатуужилтай байдлаар илрэн гарч буйг шидэт үлгэр ба монгол ардын баатарлагийн тууль дахь хүүхдийн дүр, бусад дүр дүрслэлээс тодруулан харах үндэстэй юм.

Литература

1. Гомбосүрэн Ц. Философи. Улаанбатар, 2008. 292 х.
2. Дорждагва Т. Соёл судлал. Улаанбатар, 2010. Х. 86–87.
3. Энхбаяр С. Суурин соёл иргэншил ба нүүдэлчдийн аман зохиол дахь үнэт зүйлсийн ойлголтыг харьцуулах нь // Монгол судлалын чуулган сэтгүүл. Улаанбатар, 2011. № 10(45). Х. 110.
4. Эрдэнэ-Очир Г. Хүнээр хүн хийх монгол ухааны сурвалж. Улаанбатар, 1991. 132 х.
5. Катуу Б. Монгол туульсын судалгаа — I боть. Улаанбатар, 2013. 157 х.

6. Багабанди Н. Ихийг үзсэн хүн ихийг мэднэ. URL: baabar.mn/article/27458 (дата обращения: 20.01.2021). Текст: электронный.

**МОНГОЛ ДУУН УХААНЫ СУДРУУД ДАХЬ ХЯТАД ЗУРХАЙН
ТАВАН МАХБОДЫН УЛАМЖЛАЛ, ҮСГИЙН АНГИЛАЛ
(ТРАДИЦИИ И КЛАССИФИКАЦИЯ ПЯТИ ЭЛЕМЕНТОВ
КИТАЙСКОЙ АСТРОЛОГИИ В МОНГОЛЬСКОЙ ЛИНГВИСТИКЕ)**

© **Монхбаяр Өлзийсүрэн**

учитель,

Средняя школа № 121

Монголия, 210648, г. Улан-Батор, XXI хороо

Ulziisuren0424@gmail.com

© **Дашлхагва Ганболд**

доктор Ph.D., доцент,

Монгольский госуниверситет образования

Монголия, г. Улан-Батор, VIII хороо, Бага тойруу-14

Ganbold888@yahoo.com

Аннотация. Тус өгүүлэл нь монгол хэлний шинжлэлийн уламжлалыг гүнзгийрүүлэн судлахад чиглэсэн бөгөөд эртний дорно дахинд түгээмэл уламжилсан махбодын үзэл, онолын тусгал дуун ухаанд нөлөөлсөн тодорхой баримт болох үсгийн махбодын ангиллыг авч үзэж буй юм. Махбодын хоёр янз үзэл эш манай монгол бичгийн хэл зүйн зарим бүтээлд дурдагдсан байдаг ба түүнээс бид энд зөвхөн хятад хар зурхайн махбодыг үсгийн ангилалд ашигласан баримтыг энд жишээ сэлтээр харуулж байна.

Ключевык слова: Махбод, хар зурхайн махбод, Огторгуйн маани, үсгийн махбодын ангилал, эх хөвгүүн, нөхөр дайсны харьцаа, арга билиг.

TRADITIONS AND CLASSIFICATION OF FIVE ELEMENTS OF CHINESE
ASTROLOGY IN MONGOLIAN TRADITIONAL LINGUISTIC

Monkhbayar Olziyisuren

Teacher,

Secondary school number 121

Mongolia, 210648, Ulan Bator, XXI Horoo

Ulziisuren0424 @ gmail.com

Dashlhagwa Ganbold

Doctor Ph.D., Associate Professor,

Mongolian State University of Education

Mongolia, Ulan Bator, VIII khoroo, Baga toyruu-14

Ganbold888@yahoo.com

Abstract. This article seeks to delve deeper into the tradition of Mongolian linguistics and examines the classification of the elements of the alphabet, which is a well-known fact that influenced phonology and the reflection of the theory of the body, which is common in the ancient East. Two different views of the body are mentioned in some of our Mongolian written linguistic works, and here we give an example of the fact that only the Chinese black astrological element is used in the letter category.

Keywords: *Elements, Chinese zodiac elements, хар зурхайн махбод, The Lotus Sutra, classification of the elements of the alphabet, mother and son, friend and enemy relationship, method and wisdom (upāya, prajña)*

Махбодын тухай ойлголт нь дорно дахинд эртнээс эрдэм ухааны олон салбарт түгээмэл авч хэрэглэсэн ойлголт юм. Үүнийг манай дуун ухааны мэргэд монгол бичгийн хэл зүйн зарим сударт энэтхэг угшилтай одон зурхайн их таван махбод, хятад гарвальтай хар зурхайн таван махбодын үсгийн ангиллыг авч үзэж байсан билээ. Хятад хар зурхайн таван махбодын үсгийн ангиллыг монгол бичгийн хэл зүйн бичгүүдээс хамгийн анх Данзандагвын “Огторгуйн маани”, Билигийндалайн “Махбод нугудын товч”, Түмэд Галсангийн “Бүгд тайлбар бичиг”, Дугаржав мэйрэний “Монгол үсгийн чухлыг цуглуулсан бичиг”, хожим Г.Эрдэнэтогтохын “Монгол үсгийн шинэ толь” зэрэг бүтээлд тус тус авч дурдсаныг хэл шинжлэлтэн академич Д.Төмөртоого, Өвөр Монголын эрдэмтэн Ү.Мандах, Насан-Урт, Өлзийтогтох, Нуганзаяа нар өөрсдийн судалгаандаа ашиглаж, үзэл дүгнэлт бичжээ.

1. *Данзандагвын Огторгуйн маани-д* авч тайлбарласан энэхүү агуулгад, үсгийг хятад хар зурхайн махбодоор ангилсан ба энэхүү ангилал нь өмнө өгүүлсэн энэтхэг их таван махбодын үсгийн ангилал лугаа төдий зөрүүлэлгүй тэрхүү ангиллыг шууд дагасан онцлогтой юм. Гэхдээ үүнийг зөвхөн үсгийн ангиллын махбодод хуваасан тухайд нь хэлж байна. Тэгээд өмнөх ангилал лугаа адил яагаад тухайн махбодод багтаж буйг товч тайлбарлаад цааш мөн л шүтэн барилдлагын үр дүнгийн сайн муу үйл, дагаврын тухайд жишээ баримттай өгүүлжээ.

Дээрх баримтыг авч үзээд хэл шинжээч Т.Пагва “«Зүрхний толтын тайлбар»-ын гуравдугаар бүлгийн хоёр дахь зүйлд үсгийг «хятадын ёсоор» ялгажээ. Үүнд, Энэтхэгийнхээс нэлээд өвөрмөц бөгөөд өгүүлэх эрхтний оролцох байдлаас гадна хүний биеийн дотоод эрхтнүүдийн ажиллагаатай органик холбоотойгоор, анатомийн үүднээс тайлбарлахыг оролдсон нь туйлын сонирхолтой байна. ...Үүнд тухайн үеийн анагаах ухааны амжилтад дулдуудан янз бүрийн авиаг үүсэн гарахад биеийн дотоод эрхтнүүдийн оролцолгоог холбон тайлбарлахыг оролдсон зүйл мөн” [х. 19] гэж дүгнэсэн бол академич Д. Төмөртогоо “Монгол хэлний авиаг ийнхүү таван махбод болгон хуваасан нь хэлний авианы бодитой, тусгай талыг хүлээн зөвшөөрсөн төдийгүй авиа тус бүрийн бүтэх байр хийгээд хэлэгдэх аргыг нарийн тусгасан хэл шинжлэл физиологийн ангилал юм” [х. 421] гэжээ.

Харин эрдэмтэн Нуганзаяа “үсгийн махбодын ангилалд авиалах аргыг хэрхэн хэрэглэсэн талаар болон мөн орчин цагийн авиа зүйн ухааны үүднээс авч үзвэл хэрхэн зохирч буй, бас үл тохирох шинжүүд буйг гаргаж ирсэн нь ололттой ч махбодын шүтэн барилдлагын эерэг сөрөг шинж нь авианы зохицлын чухал хууль болохыг үл анзааран *тухайн үеийн шашины номлол нөлөөнөөс болсон* хэмээн дүгнэсэн нь ёсонд нийцэхгүй юм. Мөн тэрээр энэтхэг ба хятад үсгийн махбодын ангиллыг хооронд нь харьцуулаад “Энэ хоёр анги жишээний илэрхий зөрөө гэвэл энэтхэгийн ёсоор ангилах гэдэгт голдуу аялгуу нь *ямар орноос төрөх*-ийг анзаарч, хятадын ёсоор ангилах гэдэгт харин цаашид *аялгуу гарах үеийн эрхтний хөдөлгөөн*-ийг ч шинжлэн тэмдэглэжээ” [х. 66] гэж тайлбарласан байна. Өвөр Монголын эрдэмтэн Өлзийтогтох “*Хятадын ёсоор ялгах*-д хятад эмнэлгийн ухаанд үндэслэсэн байна. Ү.Мандах үүнийг *хятад үндэстний таван махбодын ухаан* (五行学说 wu xing xue shuo)-аар онолын суурь болгож монгол хэлний авиаг ангилсныг хэлж буй гэж өөрийн бичсэн өгүүлэлдээ дурдсан билээ. Огторгуйн маани”-д тэмдэглэснээр Чойжи-Одсэр хятадын таван махбодын ухаанаар монгол хэлний авиаг таван төрөл зүйлд ангилахдаа голдуу анагаах ухааны онолд холбогдуулж тайлбарласан нь тодорхой байна” [1989. 43] хэмээсэнд өгүүлсэн *Хятад эмнэлгийн ухаанд үндэслэсэн* гэсэн нь өмнө ямагт *хар зурхайн* гэдгээс өөр шинэ үндэслэлийг гаргаж ирсэн хэрэг болно. Бас үүнээс Чойжи-Одсэрийг анх тус ангиллыг хийсэн гэдэгт их л итгэлтэй байгаа нь мэдэгдэнэ.

Цааш нь Өлзийтогтох үсгийн махбодын *Огторгуйн маани* дахь ангиллыг доорх мэт хүснэгтэлжээ:

Махбод	Мод	Гал	Шороо	Төмөр	Ус
Цулын орон	Элэг	Зүрх	Дэлүү	Уушги	Бөөр
Авиа	<i>a e ng ya qa</i> (fa ft eit Ha Ga)	<i>i ya ša</i> (fl Ya Za)	<i>da ta na la sa</i> (da Da Na La Sa)	<i>ra ja ca</i> (Ra Ja Ca)	<i>o ö ma ba</i> <i>fa wa we</i> (fo foA Ma bEt qEt Wa Wa)
Онцлог	Элэгний хийгээс төрсөн	Зүрхний хийгээс төрсөн	Дэлүүний хийгээс төрсөн	Уушгины хийгээс төрсөн	Бөөрний хийгээс төрсөн

Хүснэгт 1. Огторгуйн маани дахь үсгийн махбодын ангилал

Тус ангилал нь хэлний авиаг бие махбодын зүйн талаас үүсэж ангилсан оролдлого болно. Хүн төрөлхтний өгүүлэх эрхтэн бол (1) уушги, ац мөгөөрсөн хоолой, мөгөөрсөн хоолой, (2) төвөнх, (3) амны хөндий, хамрын хөндий, багалзуурын хөндий зэрэг гурван хэсгээр бүрэлдэж байдаг. Харин элэг, зүрх, дэлүү, бөөр байхгүй юм. Иймээс ...хэлний авиаг гаргаж байгаа бие махбодын суурийг тогтоох нь шинжлэх ухаанч үндэсгүй болно. *Хэлний авиаг энэ мэтээр ангилж тайлбар өгөх нь зөвхөн хэлбэрийг баримталсан сэтгэлч үзлийн үндэс баримтгүй зүйл болжээ*¹ [1989. 43–44] гэж эрдэмтэн Ү. Мандахын гол дүгнэлтийг дагаж батлахдаа харамсалтай нь махбодын ангилал бол шинжлэх ухааны үндэсгүй оролдлого төдий зүйл юм гэж дүгнэжээ. Монлам равжамба Данзандагвын *Огторгуйн маани*-д буй зарим агуулга монгол бичгээр ханз үсгийг галиглаж бичсэнийг хожим уншсан танилт дуудлагаас үсгийн зөрүү бага сага гарсан байж болно.

2. *Билигийндалай “Монгол үсгийн ялгал ба махбодын өчүүхэн товчнууд” /Монгол үсгийн тольтоос өчүүхэн заавар болой/*: Хоёрдугаар, Хятадын ёсоор үсгийн махбодыг ялгах нь *Ха /ᠬᠡ/ хойд үндэс*-ээс анх цэг ацаглах махбод лугаа судсуныг найраад хэмээсэн нь *а э* хоёр *га ха* төрлөөрөө модон махбод бөгөөд элэгний хийгээс

¹ Мандах, Монгол хэлний авиаг таван махбодын ухаанаар ангилахын учир, ӨМИС-ийн ЭШС-ийн 1980 оны 2 дугаар хугацаа /т.45/.

² *Огторгуйн маани*-д *Эмийн ...* гэж бичжээ.

төрсөн, дуудахад дуу бүтээхүй (ОМ-д бүдэг гэжээ.) хоолой шахах мэт гарах. *И нэг яа ша* төрлөөрөө гал махбод бөгөөд зүрхний хийгээс төрсөн. Дуудахад шүдний завсраас дуун гарах. *Да, та, на, ла, са* төрлөөрөө шороо махбод бөгөөд дуудахад хамар агаарыг хураан манчин хийх ая гарах. *Ра, жа, ча* төрлөөрөө төмөр махбод бөгөөд уушгины хийгээс төрсөн. Дуудахад аман ангайж хэлийг дэлгэхүй хамраар уур гарах мэт аялгуу гарах. *О у ө ү* дөрвөн *ма ба фа* төрөл хийгээд *ва вэ* хоёр усан махбод бөгөөд бөөрний хийгээс төрсөн. Дуудахад уруул хураан хавчихуй аялгуу гарахын тул болой.

Махбод нугудын товчнууд-д буй хятад махбодын үсгийн ангилал нь *Огторгуйн маани*-ийн ангилалтай үндсэндээ тохирох ба тухайн махбодод хамрах үсгүүд, түүний хэрхэн бүтсэн тухай тайлбарыг байрын хувьд нийлүүлж, нэг дор оруулсан найруулсан, бас зарим утгыг хурааж товчилсон зэргээс өөр зөрүү үгүй тул судалсан эрдэмтэд энд анхаарал хандуулсангүй ажээ. Тэр бүү хэл монгол бичгийн хэл зүйн дурсгалуудыг өмнө хэвлүүлсэн нь уг судрыг оруулаагүй, хожим хэвлүүлсэн нь махбодын тухай мэдээлэлгүй оруулсан нь хачирхалтай бөгөөд ерөөс энэ судрын хэвлэмэл, бичмэл судар ховор хомстой холбоотой болов уу. Билигийндалайн хувьд Данзандагваас амьдарч туурвиж явсан цаг хугацааны хувьд тийм хол зөрүүгүй бөгөөд гол нь монгол бичгийн хэл зүйн бүтээлүүдийг олж үзэж, давтагдаагүй чухал агуулгыг товчилж эмхэтгэж, хожим хойчийн үзэх сурах хүнд хялбаршуулж, сурах бичгийн шинжтэй бэлтгэж өгч байсан болов уу гэхээр байдаг. Энэ нь хэл шинжлэлийн үүднээс ухаж, нягталж, өөрийн үзэл танилтыг шингээсэн нэмэлт тайлбар сэлт хийгээгүйгээс мэдэгдэнэ.

3. 1828 онд баруун *Түмэдийн эрдэмтэн Галсан* <<Монгол үсгийн бүгд тайлбар бичиг>>-ийн тэргүүн дэвтрийн хоёрдугаар бүлэгт: <<Арван хоёр цагаан толгойд арга билиг, таван махбодын ялгавар буйн учир нь хэр хэмээвээс үсгүүдийг хадан оройлохоор эр эмийг ялгасан бөлгөө. Арга гэгч эр, билиг гэгч эм. Таван махбод гэгч мөн эр эм болой. [БТБ. х. 37–41] гэж буй.

Энэ бүтээлийг Жанжаа хутагтын байгуулсан монгол үсгийн сургуульд багш агсан Түмэд Галсан 1828 онд зохиосон гэнэ. Тус эшид тайлбарласнаас үзвэл, монгол үсэг сурагчид зориулан хэлний шинжлэлийн авиа зүйн ухааны үүднээс бус, аль болох харьцуулах дохио болгож амар хялбар тогтоолгох зорилгоор ийн хуваасан гэсэн нь ойлгомжтой байна.

Дээр дурдсан Өвөр Монголын эрдэмтэн Нуганзаяа энэхүү *эш*¹-ийг бас өөрийн бүтээлдээ авч үзээд “Монгол үсгийг дөрвөн зүгтэй үлгэрлэн зохиосон нь хятад үндэстний заншилд модон махбод зүүн зүг, гал махбод өмнө зүг, төмөр махбод баруун зүг, усан махбод хойд зүг, шороон махбод дундад орныг эзэлмүй гэдэгтэй яв цав нийцэж буй. Дүн Жүн Шү (*dong zhong chu*)-гийн хэлэхээр: <<*tu ju zuo, jin ju yon, huo ju qian, shui ju hou, tu ju zhong yang, ci qi fu zi zhi xu, xiang shou er bu*>> үүнээс үзэхэд Галсан таван махбодыг дөрвөн зүгт тохируулан нэрлэсэн нь дураараа зохиосон биш, хятадын ном судраас авсан нь харангуут илхэн байна” гэж тодотгожээ. Ер энэ мэт дөрвөн зүгийг махбод, өнгө зэрэгт хувааж бэлгэдсэн нь дорно дахинд түгээмэл дэлгэрсэн ойлголт билээ. Хэвт ёсны анхны жил буюу 1909 онд мөн баруун Түмэдийн яамны занги бөгөөд сумын занги хавсарсан Дугаржав дээрх бүтээлийг Түмэд Галсангаас бараг зуу шахам жилийн хойно зохиохдоо *Бүгд тайлбар бичиг*-ийн дээрх эшийг бараг хэвээр нь авч ашигласан нь бий.

4. *Дугаржав “Монгол үсгийн чухлыг цуглуулсан бичиг” (1909) 6-р дэвтэр, Арга билиг таван махбодын ялгал 2-р бүлэгт:* үсэг зүйн үүднээс зурам, дүрс сэлтэд нь анхаарал хандуулж, дэлгэр тайлбарласан байна.

5. Эрдэнэтогтох *“Монгол үсгийн шинэ толь” /1942/ Хоёрдугаар анги. Монгол үсгийн махбод:* “Монгол үсгийн махбодыг таван махбодын үндсэн найрууллын чанар даруй элэг модон, зүрх гал, дэлүү шороо, уушги төмөр, бөөр усан хэмээгдэх эдгээр таван махбодоор ялган хувааваас доорх мэт болой.

а. Модон махбодтой нь *а, э, о, у* дөрвөн үсэг хийгээд *ха, га* төрлийн 14 үсэг лүгээ нийт 18 үсгийг уншихад элгэний хийгээс төрөгдөж, дуу бүдэг бөгөөд хоолой шахах мэт гарах тул модон махбодтой хэмээмүй. б. Галын махбодтой нь *и* хийгээд *яа, ша* төрлийн 14 үсэг лүгээ нийт 15 үсэг болбоос зүрхний хийгээс төрөгдөж, хэлний үзүүр, шүд, тагнайгаас гарах тул галын махбодтой хэмээмүй. в. Шороо махбодтой нь *да, та, на, ла, са* төрлөөр нийт 35 үсэг болбоос дэлүүний хийгээс төрөгдөж, хамрын уурыг хурааж мангжин гэх мэт аялгуу гарахын тул шороо махбодтой хэмээмүй. г. Төмрийн махбодтой нь *жа, ча, ра* төрлийн

¹ *Бүгд тайлбар бичиг*-ийн 2014 онд хэвлэгдсэн эхэд байгаагаас Нуганзаяагийн бүтээлд авсан эш бага сага зөрүүтэй байна. Гэхдээ утгын ялгаагүй юм [М. Ө].

нийт 21 үсэг нь уушгины хийгээс төрөгдөж, ам ангайж, хэл дэлгэн хамраар аялгуу гаргах мэт тул төмрийн махбодтой болой. д. Усан махбодтой нь *ө, ү, ва, вэ* дөрөв хийгээд *ма, ба, фа* төрлийн 21 үсэг лүгээ нийт 25 үсэг болбоос бөөрний хийгээс төрөгдөж, уруул хумбихын орноос гарахын тул усан махбодтой хэмээмүй.

Г. Эрдэнэтогтохын бүтээл бол монгол бичгийн үсгийн махбодын ангиллыг хамгийн сүүлд дурдаж оруулсан нь болно. Өмнөх судруудад авч үзсэн хар зурхайн үсгийн махбодын ангилал, цул эрхтний оролцоо болон өгүүлэх эрхтний оролцооны янз маяг, дуу аялга гарах бүтэх шинж зэргийг нэг дор оруулж авч үзсэнээрээ онцлогтой. Бас махбод хоорондын барилдлага, зохирох ёсыг машинд хурааж товчилжээ. Мөн хэл шинжээчийн хувиас дүгнэсэн, шинээр авч үзсэн, задалж шинжилсэн үр дүн үгүй юм.

Эцэст нэгтгэж үзвэл, Данзандагвын *Огторгуйн маани*-д байгаа ангилал нь нийт 113 толгой үсгийг ангилсан байх бөгөөд гагцхүү модон махбодтой үсэгт энэтхэг их таван махбодын ангилалд байгаа огторгуй махбодот үсгүүд цөм хамарсан байх ба энэ нь хоолойн орноор хэлэгддэг *ng* үсгээр л бусдаасаа ялгаатай юм. Билигийндалай *Махбодын өчүүхэн товч*-доо, Г. Эрдэнэтогтох *Монгол үсгийн шинэ толь*-доо энэ үсгийг аль ч махбодод оруулаагүйгээрээ Данзандагвын бүтээлээс ялгаатай юм. Харин Г. Эрдэнэтогтох модон махбодот үсэгт *о* *и* хоёр эгшгийг оруулснаараа бусдаас ялгаатай байна. Энэхүү гурван эх сурвалж дахь ангилал нь өөр зөрүүгүй бөгөөд бусад махбодод буй үсгүүд тохирч байна. Харин *Дугаржав* болон Түмэд Галсан нарын бүтээл нь уламжлалын залгамжийн тодорхой холбоотой бөгөөд хятадын гүн ухааны эртний уламжлалт арга билиг хийгээд таван махбодыг нэгтгэсэн үзлийн үүднээс үсгийг эгшиг үсгийн дууны шинжээр нь ялгаж хуваасан өвөрмөц ангилал юм.

Литература

1. Монлом равжамба Данзандагва. Огторгуйн маани. Mongyol kelen-ü sudulul-un durasqaltu bicig-üd, tuyay-a emkidkebe, mongyol tulγur bicig-ün cubural, qoyadyar emkidkel. Хөх хот, 2015. Х. 133–143.

2. Билигийндалай. Монгол үсгийн ялгал ба махбодын өчүүхэн товчнууд. Балданжапов П. Б. Jirūken tolta-yin tayilburi - Монгольское грамматическое сочинение XVIII века. Улан-Удэ, 1962. С. 118–125.

3. Тогтохтөр. “Лам өгүүлэхүйн арслан Манзшир эгшигт эхэд мөргөж монголын 123 цагаан толгойн үсгийг туурвисан оюун

билгийн соёрхол” Монгол бар, х. 14, 9x42 (8x36,5) см, 21 мөртэй, Монгол хэлний судлалын дурсгалт бичгүүд. Хоёрдугаар боть. Эмх. Чин Лин, Туяа. Хөх хот, 2015. Х. 257–258.

4. Түмэд Галсан. “Монгол үсгийн бүгд тайлбар бичиг” (Mongyol үсүг-үн тайилбурй бичиг) *1. № 06627. Doluyan boti, orusil nige boti. (cing) yalzang jokiyaba. — cing ulus-un segülci üy-e-yin üsün bir-ün bicimel. — 8 debter. Сумьяабаатар, 1972. Х. 44

5. Дугаржав. Монгол үсгийн чухлыг цуглуулсан бичиг. Монгол хэлний шинжлэлийн дурсгалт бичгүүд. Тавдугаар боть. Эмх. Чин Лин, Туяа. Хөх хот, 2015. Т. 189–285.

6. Эрдэнэтөгтох. Монгол үсгийн шинэ толь. Монгол хэл шинжлэлийн хдурсгал бичиг. Хоёрдугаар боть. Хөх хот, 1985. Т. 332–454.

7. Пагва Т. “Зүрхний тольтын тайлбар”-ыг судалсан тухай тэмдэглэл. Улаанбаатар, 1957. Х. 40–54.

8. Төмөртогоо Д. Монгол хэл шинжлэлийн онол түүхийн асуудлууд. Улаанбаатар, 2002. Х. 391–393.

9. Мандах Ө. Монгол хэлний авиаг таван махбодын ухаанаар ангилахын учир. *Монгол хэлний судлал*. ӨМСХХХ. Хөх хот, 1990. Х. 54–71.

10. Насан-Урт. “Огторгуйн маани”-ийн тухай анхан шинжилгээ. ӨМИС-ЭШС, ӨМИСХҮ, 1981 оны 1 дүгээр хугацаа (Ерөнхий 19 дүгээр хугацаа). Хөх хот, 1981. Х. 22–37.

11. Дугар П. Үзэмчин Данзандагва хийгээд “Огторгуйн маани”. ӨМНШУ, 4-р хугацаа. № 29. Хөх хот, 1987. Х. 91–99.

12. Өлзийтогтох. “Огторгуйн маани”-ийг шинжих нь. Өвөр Монголын Үндэстний Багшийн Дээд Сургууль. № 2. Хөх хот, 1989. Х. 27–45.

13. Нуганзаяа. Данзандагвын “Огторгуйн маани”-ийн хэлний шинжлэл дэх байр суурь. Монгол хэл утга зохиол. № 5. Хөх хот, 1992. Х. 61–69.

МОНГОЛ СОЛОНГОС ҮЛГЭРИЙН ЗАРИМ БЭЛГЭДЭЛ (НЕКОТОРАЯ СИМВОЛИКА В МОНГОЛЬСКИХ И КОРЕЙСКИХ СКАЗКАХ)

© Дашзэвэг Жигзмаа

докторант,

Монгольский госуниверситет образования

Монголия, 210648, г. Улан-Батор, VIII хороо, Бага тойруу-14

jigzmaa@msue.edu.m

Аннотация. Солонгосын “Газар доорх мангасыг дарсан тухай үлгэр” нь 60 орчим хувилбар байдаг бөгөөд дэлхийн олон оронд судлагджээ. Харин бид энэ үлгэрийг монгол үлгэрээс эхтэй байж болох баримтуудыг нэхэн судалж байна. Монгол үлгэрийг мангасыг дарсан үлгэрүүд гэж нэрлэж байснаас улбаалж эртний аман эх сурвалж/Хан Харангуй, Гэсэр, Жангар, Агай улаан хаан/-дахь адил өгүүлэмж дүрслэлийг сонгон авч бүтэц, өгүүлэмж, дүр, бэлгэдлийн талаас ижил болон ялгаатай зүйлийг харьцуулж үзэхэд сонирхолтой үр дүн гарч байна. Тодруулбал: мангас бүсгүйг олзлох, бүсгүйн эрэлд мордох, үхлийн тулаан, мангасыг устгах ба хурим гэсэн өгүүлэмжийн дагуу хуваан задлан шинжилсэн юм. Энэ удаа үндэсний өвөрмөц онцлогийг илэрхийлсэн монгол бэлгэдэлт утгыг агуулсан зарим жишээллийг энэхүү өгүүлэлдээ багтаахыг зорьсон болно.

Ключевые слова: домгийн сэтгэлгээ, солонгос ба монголын аман зохиол.

SOME SYMBOLS IN MONGOLIAN AND KOREAN FAIRY TALES

Dashzeveg Zhigzmaa

Doctoral student,

Mongolian State University of Education

Mongolia, Ulan Bator, VIII khoroo, Baga toyruu-14

jigzmaa@msue.edu.m

Abstract. A comparison study of folktale on the Annihilation of a Big Underground Thief between Mongol and Korea. This study compared four different works in Mongol, including “Geser”, “Jangar”, “Hang Harangui”, “A King of Agai u laan”, to mutant type of folktale on the Annihilation of a Big Underground Thief in Korea. The According present study, there are 60 different mutant types are known for folktale on the Annihilation of a Big Underground Thief. The hypothesis was made under the assumption that those tale in Korea might have originated from monster folktales in Mongol.

Therefore, close examination of contents, origin, form, symbolic meaning and statement of above folktales in Mongol between two countries of Mongol and Korea, characters in folktales, happens, and scene were compared. There are total of four stages in contents. Monster kidnap princess, main character go to adventures to find princess, main character fights with monster, death of monster.

Keywords: mythological thinking, Korean and Mongolian folklore.

Солонгосын мангасын тухай үлгэрүүдээс төлөөлөл болох нь “Газрын мангасыг дарсан тухай үлгэр” юм. Энэ үлгэр солонгосын ард түмний дунд их өргөн тархжээ. Энэ нь мангаст олзлогдсон бүсгүйг авран тусалж буй өгүүлэмж бүхий үлгэр юм. Солонгос улсад 1947 [1: 106] оноос эхлэн энэхүү үлгэр нь судалгааны хэрэглэгдэхүүн болж олон эрдэмтэд өөрийн орны шилдэг бүтээлүүдийн хөрсөн дээр амилсан үлгэр эсвэл Азийн олон орны үлгэртэй адил төстэй болохыг батлах гэж оролджээ. Харин энэ үлгэр нь монгол өгүүлэмж, дүр, бэлэгдлийг хадгалжээ. Энд бид зөвхөн монгол бэлэгдлийн утгыг хадгалсан жишээг танилцуулна.

Зөвхөн нүүдэлчдийн соёл иргэншил бол суурин соёл иргэншлээс эрс ялгарах бөгөөд домгийн сэтгэлгээгээрээ ч өвөрмөц ард түмэн билээ. Үндэсний сэтгэлгээний онцлогийг илтгэн харуулах Монгол үндэстний өв соёл, оюуны бүтээлийн охь “Жангар”, “Тэсэр” “Хан Харангуй”-н туульс “Агай улаан хаан” үлгэрүүд нь мангасын дүрийг элбэг баян дүрслэн үзүүлжээ. Мангасын дүрийг тайлбар толинд <Мангас-/мон.manguus, бур.Мангадхай, хал. Мус/. Нэрийн гарлын хувьд “муу”/maуu, maуus/ гэсэн үгнээс гаралтай. Газар дэлхийн хүнд гай түйтгэр учруулагч уран сэтгэмжийн дүр. Эрт галавын үлэмж биет үлэг гүрвэлийн дүрээс үүсэлтэй гэж зарим эрдэмтэн үздэг. Гэхдээ голдуу монгол ардын туулийн эсрэг дүр болж гардаг> [2: 308] хэмээн тайлбарлажээ. Энэхүү мангасын дүр дүрслэгдсэн монголын аман зохиол дахь дүрслэлүүд Солонгос ардын “Газрын мангасыг дарсан тухай үлгэр”-т дүрслэгдсэн байгааг ажиглая.

Дээд доод ертөнцийн дүрслэл: Монгол ардын домог үлгэр, туульсын сурвалжуудад ертөнцийг дээд доод тивд хувааж үзэж байжээ. Монгол аман зохиол судлаач С.Дулам, дээд гэгээн тунгалаг огторгуй, доод харанхуй бараан газар хоёр нь дээрх доорхи ялгалаараа ялгардаг [3: 158] гэжээ. Монгол домгийн ёсоор бол дээд тэнгэрт мөнх тэнгэр нэр, дунд газарт хар тэргүүт хүн, адгуус амьтан, доод тивд ад чөтгөр, шуламс байдаг байна... Газрын долоон

үе давхраа юмуу ертөнцийн модны үндсийг даган явсаар доод тивд очдог. Тухайлбал, Жангар баатар газрын өрхөөр орж гамшиг зовлон туулан явсаар газрын долоодогч давхраанд хүрч очиход ад шуламсууд эзнийхээ зарлигаар алдар Хонгор баатрыг хайрсан төмөр, суран ташуураар балбан гэсгээж байдагтай таардаг билээ [2: 71]. Харанхуй бараан, ад зэтгэр шүглэсэн газрын доод тив бол гаслан зовлонгийн эх, муу муухайн үүр уурхай болох нь илэрхий байна. “Газрын мангасыг дарсан үлгэр”-үүдийг судалсан эрдэмтэд <эх газар, газар доорх ертөнц/ хүн төрөлхтөний амьдран буй газар дэлхий нөгөөх нь мангасын эзэгнэдэг газрын гүний ертөнц/> [11: 140] хэмээгээд мангасын ертөнц бол муу муухай ад чөтгөр шүглэсэн болохыг дурджээ. <Энэ ертөнц нь 2 төрлийн утга агуулна. Нэг нь мангасын ноёлогч хар хорын үндэс шүглэсэн газар бол нөгөө нь аврагч, хүн орхоодой идэж, хүч тамир сэлбэн булаагдсан хүмүүсийг авран тусалж байгаа орон зай> [11: 158] хэмээсэн бол <гол баатар мангасыг энэхүү хар хорын ертөнцөд дарж устгаж байгаагаараа хүний амьдралын эгэл жирийн үйлүүдтэй харьцуулшгүй юм> [10: 249] гэж тодорхойлсон байна. “Газрын мангасыг дарсан үлгэр”-ийн хувилбаруудад мангасыг хайж явсаар газрын доод бие рүү орох бөгөөд тэнд хүмүүст гай тотгор учруулагч мангас амьдран суудаг дүрслэлүүд бий. Солонгос үлгэрийн энэхүү дүрслэл монгол домгийн ёсонд хэдийнээ байсныг “Жангар” туульсын жишээнээс харж байна.

Мангасын тив рүү орох нүхэн гарцны дүрслэл: Эрдэмтэн С. Дулам “Монгол домог зүйн дүр” бүтээлдээ: ертөнцийн үүслийн домогт эрлэгт хувь оногдоогүй улмаас ганц савааны үзүүр дээр зогсох эрх олж, тэр саваагаараа шинэ тулгар газрын хөрсийг цоо хатган газар доор алга болсон гэж гардаг билээ. Энэ нь газар дээр суух хувь оногдоогүйн улмаас газар доорх ертөнцийн эзэн болсон гэсэн утга санаа агуулж байгаа юм. Эрлэгийн цоолсон нүхээр элдэв дээдийн эгдүүцэм дүрстэй амьтад цуврахад хоёр тэнгэрийн нэг нь галтай цучлаар бөглөн зогсоов гэж гардаг юм [2: 72] хэмээн газар луу орох нүхний утгыг таниулсан байна. Эртний аман зохиолын дурсгал Жангарын туульд: Догшин Шар Гүргэ мангас Бумбын орныг цөлмөөд нэгэн нүх рүү орно. Араас нь Жангар

“... Өвгөн! Энэ морь барьж байгтун!” гээд
Хавтаганаасаа хоёр алтан таяг аваад
Уужимд нь хоёр тулаад

Уйтанд нь нэг тулаад ороод ир” [4: 127] -сэн тухай дүрсэлнэ. Мөн Жангарын туулийн Догшин шар Гүргэ мангас хааныг Дуут Улаан Шовшуур доройтуулсан бүлэгт Араг Улаан Хонгор аргагүйн хүчинд дийлдэж мангаст цохигдож

<Хүний их биеийн чинээн бүдүүн
Хар болдоор хүлэв.
Найман мянган шулмын гарт өгөв.
“Өдөр дунд
Найман мянга цохигтун!
Найман мянга цоргигтун! Гэв.
Амьсгалахад арван хоёр тамын
Аманд хийснээс илүү зовлон үзүүлэв.
Долоон давхар газар дор
Догшин улаан тэнгисийн ёроол дор хая!” гэв.
Асар улаан нүхээр
Аваад ороод одов.> [4: 120]

Ийнхүү Араг Улаан Хонгорыг газрын доод тамын ертөнц рүү авч одсон тухай дүрсэлсэн байна. Тэр оронд очсоныхоо дараа элдэвтэй эмгэн шулмыг дийлээд түүний орсон газар руу аргамжаар татуулаад нүх рүү бууна. Тийш орж мангасын үр үндсийг тастаад дээд Гинайр тэнгэрийн охиныг аварч нүхнээс гаргана. Хүний шөрмөсөн аргамжийг татаж байсан хоёр хүвгүүн Жангарыг таталгүй нүхэнд нь унагааж буй дүрслэл бий. Солонгос үлгэр дэх таягаар хатгасан нүхээр орох, доод тив рүү олсоор татуулан буух, түшмэлийг нүхэнд үлдээж олсоо орхилгүй хаяж байгаа тухай, тэнд муу муухайн хор үндэс шингэсэн байгаа дүрслэлүүд эртний аман зохиолын өв соёлд хадгалагдан байсныг харуулж байна.

Үнсний тухай дүрслэл: Гэсэрийн туужид, <Гэсэр хоёр болд сүхээ барьж ирэв. Арлан гуад хоёр атга нүүрс атгуулав. <<Намайг цавчихад чи энэ нүүрсийг тэр шарханд нь хийж орхи>> гэв. Гэсэр хоёр мөрөн дэх алтан загасыг хоёр мөртэй нь тас цавчив. Цавчсан хойно Арлан гуа өнөөх нүүрсээ шарханд нь хийж орхи [1: 91] -сон тухай дүрслэл нь солонгос үлгэрийн хувилбаруудад дайсанд архи өгч унтуулсны хойно баатар эр мангасын хоолойг тасчин хаяна. Гэвч салангид толгой их биетэйгээ буцаж нийлэхээр өнхөрнө. Гүнж үнс цацаж орхитол эргэж наалдсангүй үхэж орхино. “Газрын мангасыг дарсан үлгэр”-ийн хувилбаруудыг солонгос эрдэмтэд судалж үзээд салсан толгой руу <үнс цацаж буй дүрслэл 6, давс

болон нунтаг чинжүү 3, элс цацсан нь 1 хувилбарт тус тус дүрслэгдэнэ. Үнс цацах дүрслэл бүхий үлгэр нь эх хувилбар юм. Учир нь үнс нь хамгийн амархан олох зүйл бөгөөд чийгийг шингээдэг тул цусанд холилдсон салангид бие цогцсыг нийлүүлэхгүй байхад хамгийн тохирсон зүйл. Гэтэл үнснээс гадна нунтаг чинжүү, элс, давс зэрэг нь өгүүлэгч үлгэрийг дэвжээх үүднээс нэг хоёр зүйлийг нэмэлтээр оруулсан байдалтай харагдана> [11: 150] хэмээжээ. Солонгост тархсан эх хувилбар дах үнсний яриа нь хожимдоо солонгосчуудын ахуй нөхцөлд шингэж чинжүү, элс, давсыг оруулсан болох нь харагдана. Ийнхүү хоёр орны аман зохиолд мангасын толгойг цавчихдаа үнс, нүүрс хэрэглэж дахин амьдруулахгүй болгож буй ижил дүрслэл байна. Солонгосын ард түмэн үнсийг бордоо болгон ашиглах ба эмчилгээ, ариутгалд тухайлбал ургамлын навч, төмсний үр идсэн хорхойг устгах зэрэгт л ашигласаар ирсэн бол тулгаа тойрч галаа өрдөж амьдарсан монголчуудын сэтгэлгээнд үнс бол уламжлалт соёлын нэг төдийгүй, муу муухай бүхний үндсийг таслан зайлуулахын тулд үнсийг цацдаг ажээ.

Нисдэг морины дүрслэл: Монголчууд эртнээс морийг уналга эдэлгээнд хэрэглэхээс гадна эрхэмлэн дээдэлж тэр бүү хэл анд нөхрөө хэмээн итгэж аман зохиолдоо хэтрүүлэн өргөмжилсөн байдаг. Монгол ардын аман зохиолд дүрслэгддэг тусагдхуунуудын дотроос морины дүрслэл онцгой байр суурьтай бөгөөд энэ сэдэв өгүүлэмж нь Монголчуудын ертөнцийг үзэх үзэл, амьдралыг ойлгох ойлголт дотор дээд хүслэн, чин эрхэмнэлийн хэмжээнд үнэлэгддэг [9: 123] хэмээн уран зохиолын судлаачид тайлбарлажээ.

Монгол үлгэр туульст нисдэг морь гардаг бол европын олон орны аман зохиолд нисдэг хивс өгүүлэгддэг. Эдгээрийн аль аль нь хурдан нисэх оньсон техник үүсгэн зохиохын хүсэл мөрөөдөл зөн билэг юм [8: 56] гэж судлаачид дүгнэсэн байна. Солонгосын “Газрын мангасыг дарсан үлгэр”-ийн гол хувилбарт морины дүр цухас дүрслэгдэнэ. Баатар эр мангасыг агуйгаас гарч чадахгүй арга мухардах үед зүүдлэгдсэн азай буурал өвгөн дахин гарч ирж нэгэн морь өгнө. Баатар эр моринд мордон ташуур өгмөгц нэг том янцгааснаа нүхнээс нисэн гарч ирнэ [7: 161]. Хөөрхий морь нүхрүүгээ буцан орохоор шургатал хүзүүгээ хугалан амь тавьж байна. Солонгос хувилбарт хэдийгээр жижиг дүрслэл боловч эзэндээ үнэнчээр тусладаг нисдэг морины бэлгэдэл хадгалагдсан байна. Нисдэг морь, ид шидийн дүрслэлүүд солонгос үлгэрийн

дараах хувилбаруудад байна. Тухайлбал солонгос эрдэмтний судалгаанд <Энд гол баатар урвагчдын уршигт үйлээс болж газар доороос гарч ирж чадахгүйд хүрнэ. 7 хувилбарт энэ нөхцөл байдлаас ангижрахад нь туслах ид шид бүхий туслагч гарсан тухай өгүүлнэ. Нэгдэх хувилбарт буурал үст өвгөн нисдэг мориор тусалдаг> билээ [11: 146]. Эндээс бид эхний гол хувилбарт эзэндээ үнэнч морины дүрслэл буйг бэлхнээ харж байна. Мөн нисдэг мориноос гадна хун шувуунд хувилах дүрслэлийг дурдаж болно. Жишээлбэл, “Жангар” туульд Хонгор хоол ундгүй, морь нь өвс усгүй ангаж цанган, эцэж цуцаж явахад Гэрэнзэл хун шувуунд хувилан хоол гэжээл, ус унд, өвч аваачиж өгдөг бол “Хаан Цэцэн Зурхайч”-д Ноёлхуу Зандан хатан хар эрэн харцагад хувилж очин мангасын хамаг сүнсийг мэдэж ирээд баатруудад хэлж түүнийг устгуулж> [5: 139] байна. Монголчууд шувууг тэнгэрийн амьтан гэж үздэг байсан бөгөөд газрын доорх, дээрх ертөнцийг холбоход чамгүй үүрэг гүйцэтгэж байна. Пэ Ду Шиг эрдэмтэн судалгаандаа < Мөн 10 ширхэг загас барьж өгвөл нуруундаа суулган нүхнээс гаргах тогорууны тухай дүрслэл 1 хувилбарт, бас 1 хувилбарт 7 загас барьж өгвөл нүхнээс гарахад туслах тогорууг дүрсэлсэн байна. Загасыг нь барьж өгөөд тогорууг унаад нисэж байтал маш их эцсэн тул гол баатар шууныхаа магнаас идүүлж тамир тэнхээ оруулна. Ийнхүү газрын гүнээс гарч иртэл тогоруу алга болж гарын шуу урьдын хэвэндээ орсон байв. Мөн өөр нэгэн хувилбарт дайсны унадаг тэнгэрийн хүлгийг гол баатар гүнжийн хамт унаж зугтсан> [11: 146] тухай өгүүлнэ. Тогоруу шувуу гол баатрыг нүхнээс гарахад тусалж байгаа солонгос үлгэрийн дүрслэл Гэрэнзэл хатан хун шувуунд хувилан тамир тэнхээ сэлбэх хүч болж байгаа дүрслэлтэй ижил ажээ.

Бэлгэдэл нь тухайн үндэстний сэтгэлгээний онцлогийг илэрхийлэгч учраас уг үлгэрийн уламжлал нөлөөллийг судлах чухал хэрэглүүр билээ.

Солонгос ардын “Газрын мангасыг дарсан үлгэр”-ийн 60 орчим хувилбарыг монгол үлгэрүүдтэй тодорхой хэмжигдэхүүний дагуу харьцуулалт хийж байна. Солонгосын “Газрын мангасыг дарсан үлгэр”-ийн эх хувилбар нь монголчуудын сэтгэлгээний онцлогийг илтгэсэн бэлгэдэлт утга, үнэт зүйлсийг хадгалж үлдсэн байна. Тухайлбал дээд доод тив, газрын нүхээр мангасын гэрт шурган орох, хар хорын үндсийг агуулсан мангасын толгойг их биетэй нь нийлүүлэхгүй хэмээн үнс цацах, монголчуудын “чин эрхэмнэл” болсон нисдэг морь цаашлаад хонины арьсыг хүртэл дүрсэлжээ.

Солонгосын газрын мангасыг дарсан үлгэрүүд нь домог үлгэр, туульс, үлгэр, шидэт үлгэрийн шинжийг хадгалсан байдаг. Монголчууд мангасын үлгэрийг өлгийдсөн баялаг сэтгэлгээт ард түмэн төдийгүй тууль-үлгэр гэх нэршлийг мангасыг дарсан үлгэр гэж нэрлэж байсан учраас мангасын үлгэр бол монголын үлгэр гэх үндэстэй бөгөөд солонгос үлгэр дэх мангасын үлгэрийн бэлгэдэл дүрслэлийн эх улбааг монголын аман зохиолоос хайх оролдлогыг эхлүүлсэн болно.

Цаашид Монгол Солонгосын төр нийгэм, хүн амын шилжин суурьшилт, аман болон бичгийн зохиолын харилцаа шүтэлцээ, монгол үлгэрийг бүтээх нийтлэг арга дээр суурилсан, Солонгос үлгэрийн дүрийн яв цав нийцэл, монгол үлгэр бүтэх нийтлэг аргад суурилсан, аман үлгэрийн харилцан нөлөөлөл болоод орчин үеийн амьдралын хэмнэлд ойртож ирсэн болох нь хожуу тархсан үлгэр болохыг гэрчлэх үндэслэлүүдээр монголоос эхтэй байж болох таамаглалыг гүнзгийрүүлэн судалж байна.

Литература

1. Гээр / под ред. Ц. Дамдинсүрэн. Улаанбаатар: Монгол, 1986. 106 х.
2. Дулам С. Монгол домог зүйн дүр. Улаанбаатар: Монгол, 2009. 308 х.
3. Дулам С. Монгол бэлгэдэл зүй. Улаанбаатар: Монгол, 2007. 158 х.
4. Жангар. Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т. Дүгэрсүрэн. Улаанбаатар: Монгол, 2000. 127 х.
5. Жигзмаа Д. Агуйн мангасыг дарсан нь хэмээх солонгос үлгэр монгол үлгэр туурвилаас эхтэй юу? // МУБИС-ийн Монгол судлалын чуулган эрдэм шинжилгээний сэтгүүл. 2012. № 12(47). 161 х.
6. Катуу Б. Монгол туульсын судалгаа. Улаанбаатар: Монгол, 2013. 139 х.
7. Энхбаяр С. Суурин ба нүүдэлчин иргэдийн үлгэрт илэрч буй үнэт зүйлс болоод үнэлэмжийн ялгаа // МУБИС МоСС Харьцуулсан аман зохиолын асуудлууд. 2011. 123 х.
8. 강봉근. 지하국대적퇴치설화와 해란강설화의 비교 연구. 한국언어문학: 한국언어문학회, - 제 37. 1996. 249 х.

9. 배도식. 지하국대적제치설화연구. - 동남어문논집: 제 14 집. 2002. 146–150. 158 x.
10. 손진태. 한국민족설화연구. 서울: 을유문화사, 1947. 132 x.

**АНТРОПОЦЕНТРИЧЕСКАЯ НАПРАВЛЕННОСТЬ СЕМАНТИКИ
ОБРАЗНЫХ ФРАЗЕОЛОГИЧЕСКИХ ЕДИНИЦ В ОЛОНХО
«АЛА БУЛКУН БОГАТЫРЬ»**

© **Захаров Максимилиан Андреевич**

магистрант,

Северо-Восточный федеральный университет им. М. К. Аммосова
Россия, 677000, г. Якутск, ул. Белинского, 58
maksimilian.zakharov@gmail.com

© **Прокопьева Светлана Митрофановна**

доктор филологических наук, профессор,

Северо-Восточный федеральный университет им. М. К. Аммосова
Россия, 677000, г. Якутск, ул. Белинского, 58
dsmplana@mail.ru

Аннотация. В статье анализируется антропоцентрическая направленность семантики образных ФЕ в олонхо «Ала Булкун богатырь» Т. В. Захарова-Чээбий. Изучение языковой картины мира, ее репрезентация в языковых единицах является способом проникновения в творческую лабораторию сказителя с использованием компонентного, контекстуального анализов, методом фразеологической идентификации. Образное описание положительных и отрицательных персонажей связано с мотивами скотоводческой культуры.

Ключевые слова: эпос олонхо, языковая картина мира, архаический жанр, фразеологическая единица, гиперболизация.

ANTHROPOCENTRIC DIRECTION OF THE SEMANTICS OF SIMPLE
PHASEOLOGICAL UNITS IN OLONKHO "ALA BULKUN BOGATYR"

Zakharov Maximilian Andreevich

Undergraduate,

North-Eastern Federal University them. M. K. Ammosova
Russia, 677000, Yakutsk, st. Belinsky, 58
maksimilian.zakharov@gmail.com

Prokopyeva Svetlana Mitrofanovna

Doctor of Sciences (Physiology), Professor,
North-Eastern Federal University them. M. K. Ammosova
Russia, 677000, Yakutsk, st. Belinsky, 58
dsmplana@mail.ru

Annotation. The article analyzes the anthropocentric orientation of the semantics of figurative phraseological units in the olonkho "Ala Bulkun bogatyr" T. V. Zakharova-Chebiy. The study of the linguistic picture of the world, its representation in linguistic units is a way of penetrating into the creative laboratory of the narrator using component, contextual analyzes, the method of phraseological identification. The figurative description of positive and negative characters is associated with the motives of the pastoral culture.

Keywords: epic olonkho, linguistic picture of the world, archaic genre, phraseological unit, hyperbolization.

Якутский эпос как многослойное произведение сохранил в себе реликты магическо-мифологического и символического мышления, обусловившего некоторые его художественные особенности: например, мифологизацию героики, гиперболизацию, символическо-семантической образности и т. д. [3: 6].

Эпический символ — один из видов языковых и информационных знаков, порожденных мышлением древнего человека, который можно описать, объяснить и расшифровать. В этом контексте эпический символ является знаковой категорией наряду с сигналом, языковым кодом, при этом чаще субститутотом первичного содержания. Символика и их расшифровка расширяют наши представления об эпической картине мира.

Новизна статьи обусловлена тем, что, несмотря на общую изученность языка олонхо с разных позиций, данная проблематика слабо разработана в якутской лингвистике, где образная семантика ФЕ отдельно взятого сюжета олонхо не стали предметом специального исследования.

Целью статьи является исследование антропоцентрической направленности семантики образных фразеологических единиц в олонхо «Ала Булкун богатырь» Т. В. Захарова-Чээбия.

В олонхо богатыри стоят в центре "вселенной", они могут управлять миром и природными стихиями, а потому они великаны, всесильные и обладающие сверхъестественными магическими способностями [3: 50].

Как пишет Д. Т. Бурцев, богатырь айбы мифологизируется все-сторонне, являясь “существом, обладающим сверхъестественными способностями, в котором заключены стихийные силы природы:”...его слово становится громом, его дыхание — ветром, крик — бурей, взгляд — молнией” [1: 43].

ФЕ возникают в национальных языках на основе образного преломления действительности, что отражает духовный опыт народа, связанный с его культурными традициями, и, следовательно, ФЕ являются носителями национального видения мира. Именно во фразеологизмах запечатлен исторический опыт народа, представления о быте, культуре, труде, животном и растительном мире, они — одни из самых ярких компонентов, которые создают языковую картину народов мира. Под фразеологическими единицами подразумеваются устойчивые словесные комплексы с единичным сцеплением компонентов, значение которых возникает в результате полного или частичного семантического преобразования компонентного состава. Релевантными признаками ФЕ являются семантическое переосмысление компонентного состава, раздельнооформленность, устойчивость и воспроизводимость компонентного состава. Образная маркированность семантики компонентов в составе ФЕ связана с антропометрическим параметром и релевантна для образования ФЕ [4: 5].

Средний мир в олонхо как сфера обитания людей айбы аймаҕа, маркирующихся в эпической картине мира как солнечная, божественная сторона (почитание востока), накладывает свой отпечаток на образном описании внешнего вида главных персонажей, в частности, богатыря айбы. В языковой картине мира на первый план выступают культурные концепты и коды, исходящие из ассоциативных понятий геоцветового и пространственного символизма. Например, один из кодов: ”үрүн” — белый со всеми оттенками; “күн” - солнечный имеет много вариантов и соответственно ассоциаций (үрүн күн, үрүн ыраахтааҕы, аламай манган күн и т. д.) связан в олонхо с понятием традиционных верований, идентифицирующегося с понятием “божественность” [2: 39; 2: 75]. Данный код в олонхо представлен с точки зрения наилучший, красивый, светлый, белый, божественный.

В традиционной внешней характеристике богатыря айбы перечисляются все лучшие физические и моральные качества, которые соотносятся с содержанием и в соответствии с эталонами морали и

идеалами патриархально-родового общества. Характеристика богатыря айыы как самого сильного, статного, красивого соответствуют моральным качествам самого мужественного, храброго и непоколебимого богатыря, высокое предназначение которого — быть защитником племени и продолжателем рода, предопределенным изначально на эту миссию самими божествами айыы [3:18]. В этом контексте судьба богатыря айыы записана в берестяных архивах у божеств айыы, на каменных скрижалях, на 9–12-гранных прозрачных столбах Верхнего мира.

Образное описание внешнего вида богатыря айыы Ала Булкун:

Ой хара тыаны	Словно колок темный
Ортотунан ойо баттаан	В поле открытом
ылбыт курдук	Посередине кругом вырезанный,
<i>Ойбонноох оройдоох</i>	С теменем открытым;
	(АБ, Стлб.50)
Аллаах ат сототун	Словно коня ретивого
Сулуйа баттаан баран	Голень ободрали и
Туруору туппут курдук	Прямо поставили
<i>Хансаардаах үрүн көмүс муруннаах.</i>	Нос точеный имеет;
	(АБ, Стлб.70)
Уон атыыр туллугу	Словно десять снегирей крупных
Кэккэлэччи туппут курдук	В ряд ровный поставили
<i>Аалыылаах дьырыы көмүс тиистээх;</i>	Зубы белые имеет;
	(АБ, Стлб.70)

Здесь внешность богатыря айыы сравнивается с наилучшими качествами предметов или объектов. Например, его белый точеный нос сравнивается с белой, ободранной костью голени ретивого коня. Сказители часто пользуются при сравнении богатыря айыы со всеми частями особо любимого якутами быстроногого коня-жеребца, который также в традиционных верованиях предстает одним из 9 божеств Верхнего мира Джесегей айыы, младшего брата Верховного божества. Это традиционные и любимые образы скотоводческого народа. Или зубы богатыря — ровные и крепкие как десять белых весенних снегирей, когда они особенно упитаны и красивы, а пух их наиболее пушист и бел. Данное сравнение исходит из непосредственного наблюдения якута-охотника, который до тончайших подробностей изучает повадки и внешний вид птиц или зверей, на ко-

торых он охотится. Снегирь — традиционный, изблюбленный образ не только в фольклоре, но и в лирике якутских поэтов, когда они белоснежную грудь любимой женщины сравнивают с двумя белыми снегирями и т.д. В данном примере сказитель сравнивает зубы богатыря с этим традиционным образом.

Таким образом, образное описание положительных и отрицательных персонажей связано с мотивами скотоводческой культуры при разнице и степени их качества.

Напротив, богатыри абаасы одноноги, одноруки, одноглазы как циклопы, поскольку они не обладают полным, цельным набором органов, а только половиной, в эпосе они всегда изображаются как неполноценные [3:20]. Поэтому при их описании используются объекты, элементы и вещества низшего качества, а качества сравниваемых вещей тоже аномальные.

Образное описание внешности богатыря абаасы:

Улуу уус кыстыгын курдук
Икки балбаах хоннорор хорууру
Хардарыта бырахпыт курдук
Ханньылаах хардастыгас *дьэс килиэ
тиистээх эбит.*

Как кузнеца наковальня
С кривым лицом безобразным,
оказывается.
Будто две узкие лопаты навозные
Рядом брошенные,
С зубами красномедными,
оказывается.

(АБ, Стлб.780)

Элгээн көлүйэни ортотунан
Быһа далайбыт курдук
Энкэ-дьэҥкэ харахтаах.

Будто озеро овальное
пополам рассеченное
С глазами темными.

(АБ, Стлб.790)

Икки сыарҕалаах хагдаг оту
Хардарыта тартарбыт курдук
*Күдэн өрүкүнэй сахсаһын
баттахтаах.*

Будто два воза сена блёклого
Рядом стоящие,
С косматыми волосами лохматыми.

(АБ, Стлб.790)

В целом в эпосе мир также строится по простой модели: “свой-чужой”. Устроенный таким образом мир уже по своей природе несет в себе уже конфликт, ибо оказывается поляризованным основной семантической структурой “свое-чужое” [3: 20].

В данном примере чудовище-абаасы как существа уродливые и неполноценные, всегда видят плохо, они близоруки в противопо-

ложность зоркости глаз богатырей, как правило, у них больные глаза. Здесь ФЕ “*Энкэ-дьэнкэ харахтаах*” — неперебиваемое выражение, обозначающее неполноценное, а частичное зрение. Здесь первый компонент ФЕ “*энкэ*” означает редкое, а второй компонент “*дьэнкэ*” означает прозрачное, часто у них глаза больные с бельмом посередине, потому они имеют такой белесый, прозрачный, непривычный для восприятия якута вид, т. е. не темные, черные или карие глаза. В переводе наоборот, почему-то глаза абаасы представлены темными.

Вторая ФЕ “*Күдэн өрүкүнэй сахсааһын баттахтаах*” — редкие, торчком стоящие лохматые волосы, сравниваемые с двумя возами прошлогоднего блёклого сена. Здесь мы видим традиционное сравнение, исходящее из менталитета якута-скотовода, который использует знакомые ему объекты. Пожухлое, прошлогоднее сено, естественно, уступает по своим питательным свойствам и качествам только что выкошенному свежему, зеленому селу, особо питательному для скота.

Таким образом, характеристика персонажей строится по принципу бинарной оппозиции: “свой-чужой”, “хороший-плохой”, где левый элемент дается в превосходной степени и с лучшими качествами (человеческое, носитель божественности по происхождению, герой) и объектами и предметами, а правый — реализуется как “нечеловеческое”, “зооморфное”, “потустороннее”, “этнически чужое”, “иноземное”, “плохое”, “уродливое”, “враждебное”, “неполноценное” [3: 20].

ФЕ выступают как средство гиперболизации внешнего вида богатыря и выразительности изобразительных средств. В этом контексте эпическая картина мира оживает на глазах слушателей/читателей через ФЕ, представляя своеобразие и богатство языка эпоса, вновь и вновь воссоздавая на наших глазах давно ушедший мир предков.

Литература

1. Бурцев Д. Т. Якутский эпос олонхо как жанр. Новосибирск: Наука, 1998. 85 с.
2. Захаров-Чээбий Т. В. Ала Булкун бухатыыр. Ала Булкун богатырь: на якут. и рус. языках. Якутск: Алаас, 2018. 520 с.
3. Захарова А. Е. Архаическая ритуально-обрядовая символика народа саха (по материалам олонхо). Новосибирск: Наука, 2004. 312 с.

4. Прокопьева С. М. Проблема фразеологической образности в исследовании универсально-типологического и национально-специфического в фразеологической системе языка. М.: Мир книги, 1995. 163 с.

**ДИАЛЕКТНАЯ ЛЕКСИКА В СИБИРСКИХ РАССКАЗАХ
В. Г. КОРОЛЕНКО (на материале якутского цикла)**

© **Филиппова Айяна Александровна**

аспирант,

Северо-Восточный федеральный университет им. М. К. Аммосова

Россия, 677000, г. Якутск, ул. Кулаковского, 42

fiayalex11@yandex.ru

Аннотация. В статье рассматривается употребление диалектных слов в сибирских рассказах В. Г. Короленко. Диалектная лексика выполняет определенную стилистическую функцию, и в зависимости от этого используется разные её типы. Использование диалектизмов помогает передать местный колорит, особенности речи героев. свидетельствует о глубоком языковом реализме, народности и интернациональной сущности творчества писателя. В анализируемых рассказах В. Г. Короленко выявлены разные типы диалектизмов. Наиболее часто в рассказах Короленко встречаются собственно лексические диалектизмы. Они называют явления природы, предметы быта, действия и т. п.

Ключевые слова: русская литература, Сибирь, сибирская тема, В. Г. Короленко, диалект, лексика, диалектная лексика.

**DIALECT LEXICA IN SIBERIAN STORIES V. G. KOROLENKO
(based on the Yakut cycle)**

Filippova Ayana Aleksandrovna

Graduate student,

North-Eastern Federal University named after M. K. Ammosova

Russia, 677000, Yakutsk, st. Kulakovsky, 42

fiayalex11@yandex.ru

Abstract. The article discusses the use of dialect words in the Siberian stories of V. G. Korolenko. Dialectal vocabulary performs a certain stylistic function, and depending on this, its different types are used. The use of dialectisms helps to convey the local flavor, peculiarities of the characters' speech. Testifies to the

deep linguistic realism, nationality and international essence of the writer's work. In the stories analyzed by V. G. Korolenko identified different types of dialectisms. Most often in the stories of Korolenko there are actually lexical dialectisms. They call natural phenomena, household items, actions, etc.

Keywords: Russian literature, Siberia, Siberian theme, V. G. Korolenko, dialect, vocabulary, dialect vocabulary.

Владимир Галактионович Короленко начиная с 30 ноября 1881 г. по 9 сентября 1884 г. отбывал ссылку в Амгинской слободе за отказ от присяги царю Александру III. Но край изгнания сыграл важную роль для становления и развития его личности как писателя. Он кропотливо изучал историю, традиции, обычаи, нравы якутов, записывал и изучал фольклор, тем самым стал первооткрывателем якутской тематики в русской литературе. Благодаря сибирским рассказам В. Г. Короленко российские читатели впервые узнали о жизни жителей якутского края. Он посвятил Якутии более 20 рассказов, очерков, черновых набросков, этюдов, заметок, записей в дневниках.

В творчестве В. Г. Короленко Якутия занимает особое место, так как Амгинская слобода на три года стала местом его сибирской ссылки. Это был период самой плодотворной литературной деятельности В. Г. Короленко. Он посвятил Якутии более 20 рассказов, очерков, черновых набросков, этюдов, заметок, записей в дневниках.

В данной статье материалом послужили «Сибирские рассказы» Короленко, что писались в восьмидесятые годы в период ссылки, и в девяностые годы. В рассказах Короленко можно встретить много диалектных слов.

Диалектизм — это лексическая единица, характерная для территориального и социального диалекта. В литературе диалектизмы используются для придания речи героев индивидуальной окраски.

Основная целевая установка Короленко заключается в том, чтобы через диалектизмы передать местный, сибирский колорит, оправдываемый содержанием и темой рассказов, а также индивидуализировать язык героев. Он использовал слова, свойственные, в основном, сибирскому наречию русского языка. Из общего количества диалектизмов почти половина отмечена в словарях пометой «сибирский» [3, 87].

Вполне понятно, Короленко, находясь в Якутии, интересовался речью сибиряков. Он свои наблюдения отразил в «Записных книжках» и «Дневниках». Впоследствии они послужили материалом для

рассказов [3, 87]. Диалектизмы классифицированы по лексическим, морфологическим и фонетическим особенностям.

Лексические диалектизмы. Среди лексических диалектизмов в количественном отношении преобладают названия явлений природы, рельефа местности, названия бытовых предметов, действий, понятий. Торосья — нагроможденные льдины (273, 275, курья — залив (155), лиман — залив (155), забереги — тонкий лед у берегов (391), пади — ущелья (153), сало — ледяная каша (459), морок — сумерки, насыщенные туманом (158, 474); сполох — северное сияние (170); сивер — северо-восточный ветер (403, 408, 410); виска — ручей, речушка (452).

Глаголы: пофартить — посчастливить (477, 478), забалакать — заговорить (334), булгачить — беспокоить (408), сгношить — сделать (326), ободнять — рассветать (336), каталажиться — шуметь (469); кричать (469); заиграть песни — запеть песни (322), прокинуться — прийти в себя (324).

Имена прилагательные и наречия: фартовый — счастливый, удачливый (137, 477); щепоткий — мелкий шаг (277), хлынь — тихая рысь (314); квольый — слабый, хилый (387); ноне — нынче (163); больно — очень, отселе — отсюда, намеднись — на днях, недавно (163).

Морфологические диалектизмы. Окончание «ы» вместо литературного «а». «Кабы так что лошадь, да соха, да *семены* — землю бы пахать, чего боле!» (333); «А отсель и письмо-то не дойдет. Где поди! Далеко, братец мой! Каки *письмы!*» (339). «*Вороты заперты накрепко*» (162).

Окончание -ов, -ев в род.пад.множ.числа для всех родов. «Ему бы с Абрашкой с Ахметзяновым стакаться — они бы *делов* наделали» (240). Сам с собой разговаривает, голова у него мотается; да и *распоряжениев* от него никаких не видится» (152).

Фонетические диалектизмы. Переход вн. — в мн., бн-мм, св-сл, мн-мл. «А у меня *мнук* не застыл, что ли? — злобно выкрикнул в толпе какой-то старик» (408). «А ты мне свою лахудру подсудобила... Это есть *амбан!*» (473). «Ты, Тимоха, человек выходит *слободнай*» (338). В сочетаниях ст, см, зн — утрачивается начальный согласный: *тупай, мотри, наю*. «Не задень, *мотри...* Камень... тут» (452). Произношение двойных согласных в служебных словах. «*Этто* — годов с пять человек тут попалал, от нашей деревни *недальной*» (339). «*Этто* Абрашка — татарин приезжал» (341), «*Экка* беды!» (452).

Широко распространен перенос ударения к концу слова: «У нас свой климат, значит, якутской, у меня климат руськой» (355). «Морозище трещит за тсеной или выюга воег...» (290). «Исправник ноне живет бойкой» (163). «Конь якутской дикой» (335).

Таким образом, использование диалектизмов в художественной литературе помогают передать местный колорит, а также особенности речи героев. Использование в сибирских рассказах диалектизмов помогало писателю отражать материальную духовную и жизнь якутского народа, раскрывать якутскую действительность.

Литература

1. Короленко В. Г. Повести и рассказы. Переиздание / Оформ. П. Ф. Космолинского. Якутск: Кн. изд-во, 1980. 536 с.

2. Короленко В. Г. Повести и рассказы. Переиздание / Оформ. П. Ф. Космолинского. Якутск: Кн. изд-во, 1980. 456 с.

3. Платонова К. И. Средства и приемы лексической экспрессии в сибирских рассказах В. Г. Короленко: монография. Якутск: Изд-во Якутского ун-та, 2003. 170 с.

“ҮЛҮГЭРЭЙ ДАЛАЙ ТААЛХА” ХЭМЭЭХ ХЭЛЦ ГИЙН ТУХАЙД (ОБ ИДИОМАХ В ТЕКСТЕ “ҮЛҮГЭРЭЙ ДАЛАЙ” (ОКЕАН ПРИТЧ))

© **Лувсанцэрэнгийн Цэрэнчимэд**

кандидат филологических наук,

Монгольский госуниверситет образования

Монголия, 210648, г. Улан-Батор, ул. Бага тойруу-14

tserenchimed@msue.edu.mn

Аннотация. Бурхны шашны сургаал, дорно дахины уран зохиолоор дамжин монголын ард түмэн, буриад-монголчуудын дунд дэлгэрсэн нэгэн заншил, оюуны соёлын тухай энэ товч судалгаанд өгүүлнэ. “Үлгэрийн далай” судартай холбоотой хэлэлцэх болсон “Үлигэр далай таслах” хэмээх хэлц үгийн утгыг одоо цагт мэдэх хүн цөөн болжээ. Бид энэ судалгаанд хэд хэдэн мэдээлэгчийн өгүүлсэн мэдээг (шууд ба дам тэмдэглэн авсан) баримт болгосон. Хэлний хөгжлийн хуулиар аль нэг үгээр оноон нэрлэсэн юм, үзэгдлийг хэрэглэхгүй, түүнийг мэддэг хүн нь байхгүй болоход түүнтэй холбоотой бүхэн адил бүдгэрч, хэлний үгийн сангаас хасагдаж байдаг. Үүний нэг тодорхой жишээ бол энэ хэлц үг юм. Цаашид өөр газар нутаг, угсаатны дунд ямар байдалтай байсан хийгээд ийм заншил ёс

дэлгэрсэн эсэхийг сурвалжилж, угсаатны оюуны соёлын үүднээс сонирхон үзэх нь зүйтэй.

Ключевые слова. Үлгэрийн далай судар, буриад угсаатан, зан заншил, хэлц үг.

ABOUT IDIOMS IN THE TEXT “YLGEREI DALAY” (OCEAN OF PARABLES)

Luvsantserengiin Tserenchimed

Candidate of Philology,

Mongolian State University of Education

Mongolia, 210648, Ulan Bator, st. Baga toyruu-14

tserenchimed@msue.edu.mn

Abstract. In this short study, one tradition or intellectual culture that is spread among Buryat-Mongols and Mongolian people through the literature of the East and religious preaches is described. There are not many people who know the meaning of the idiom “Üliger- ün dalai tahalkha” discussed in connection with “Üliger- ün dalai” sutra. Here, we relied on the documents gained and stated from the informants directly or indirectly. According to the laws of a language development, when the thing or phenomenon named with any word is not applied or the people who know it disappear, everything connected with it fades and the name is expelled from the vocabulary. The distinct example of it is this idiom. There is a need to inquire about how this tradition is stalked in different places and ethnicities and study further in terms of ethnic spiritual culture.

Keywords: Ocean of fairy tales, Buryat ethnos, customs and idioms.

“Үлгэрийн далай” хэмээх судар эртний соёлт Энэтхэг орноос гаралтай ажээ. Энэхүү үлгэрийг санскритаар Даммамука, төвөдөөр Дозанлүн буюу “Цэцэн тэнэгийн үлгэр” гэж нэрлэдэг. Энэ үлгэр төв Азийн олон оронд тархжээ. Академич Б.Ринчен: “Хуучин монголын уншигчдын дунд хамгийн их дэлгэрсэн судрын нэг бол Үлгэрийн далай бөгөөд энэ ном байхгүй малчны хот, тийм айл байгаагүй” гэж тэмдэглэсэн байдаг [Бүрнээ Д., Энхтөр Д., 2017: 6].

Үлгэрийн далай судар барын хэвлэлээр дэлгэрснийг дараах баримтаас харж болно. Энх-Амгалангийн 53 дугаар он буюу 1714 онд “Үлгэрийн далайн судар оршив” хэмээх хэвлэлийг хуулбарлан буулгасан буриад бар бий [Бүрнээ Д., Энхтөр Д., 2017: 6]. Энэхүү барын хэвлэл буриадуудын дунд ихэд дэлгэрэн тархсан ажээ. 1728 онд “Элдэв Үлгэрийн далай хэмээгдэх оршив” гэсэн нэртэйгээр

модон бараар дахин хэвлэснийг тэмдэглэсэн байна [Шүгэр Ц., 1991: 78].

Ламын шажантай хамта хэлэ бэшэг, эрдэм ухаан, урлаг (искусство) ухаан, архитектура гэхэ мэтэ манда нэбтэрэн ороһон юм. Түб Азиин оронуудай арадуудай нэн түрүүн Монголой, Түбэдэй, Энэдхэгэй, Хитадай соёл, уран зохёолой, урлагай, ёһо заншалай, гүн ухаанай баялагые буряадууд шүүрэжэ абahan, тиигээд өөһэд дундаа хүгжөөжэ эхилэһэн байна. Түбэд, Монгол, Хитад, Энэдхэг оронуудай зохёолшодой, эрдэмтэдэй бүтээлнүүд Буряадта тараба. Эдэ юүн бэ гэхэдэ: *Панчатантра*, *Аржа Буржа хаан*, *Шэдитэ хүүр*, *Бэгэрмижэдэй туужа*, *Субшад гэхэ мэтэ* [Чимитдоржиев Ш. Б., 1992: 3–4] гэснээс үзэхэд дорно дахины уран зохиолын нэг “Үлгэрийн далай” ч байгаа нь тодорхой.

“Үлгэрийн далай” судрыг Шэрээт гүүшийн орчуулгаар “Шулуун онолт”, Чүлтэмлодойн орчуулгаар “Сайн муу үйлийг ухуулахуй”, Зая бандид Намхайжамцын орчуулснаар “Мэдээтэй мэдээгүйг ялгагч” гэх зэргээр нэрлэсэн байдаг байна. Ойрдуудын дунд 1655 оны орчимд Зая бандид Намхайжамц орчуулж тод үсгээр буулгахдаа: “Мэдээтэй мэдээгүйг ялгагч судар” хэмээн нэрлэснээр дэлгэрсэн ажээ. Үлгэрийн далай судар нь тод үсгийн гол дурсгалын нэг гэдгийг эрдэмтэн Х.Лувсанбалдан: “Дэлхий дахины томоохон номын сан хөмрөгт тухайлбал: Улсын нийтийн номын санд - 1, Ленинград хот дахь Дорно дахиныг судлах хүрээлэнд 1, Германд - 2 байгаагаас үзэхэд ховор дурсгалын нэг болох юм. Монгол эх 52 бүлэгтэй бол тод эх 51 бүлэгтэй” гэжээ. [Лувсанбалдан Х., 2015: 82]. Ийнхүү 17-р зууны үеэс монголчуудын дунд тархан дэлгэрсэн энэхүү судар нийгэм улс төрийн өөрчлөлтөөс нэг хэсэг хэрэглээ хумигдсан цаг үе байсан. 1959 онд академич Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын дээж “Зуун билиг” оршвой” хэмээх бүтээлийн 295–298-р талд “Үлгэрийн далай” судрын 40 дүгээр зүйл (Гэрийн эзэн Илдандийн тухай) -ийг орчуулагч Гүүш Цоржийн бичсэн төгсгөлийн үгийн хамт оруулсан байдаг. Энэ номоос 20-р зууны 60-аад оны сурагчид зохих хэмжээгээр уншиж, унших байсан ч удалгүй үзэл суртлаас болж, хурааж байсан бодит явдлын талаар мэдээ бий.

Монголчууд 13 дугаар зуунаас модон бараар ном хэвлэдэг дорно дахины нэгэн аргыг эзэмшжээ. Урт хугацааны турш хүрэл, зэс, чулуун бараар ном судар хэвлэж байсан байна. Нийт монголын дотор модон бараар ном хэвлэх нь ихэд хөгжжээ [Шүгэр Ц., 1991: 51].

18 дугаар зуунд Монголд шарын шашин улам гүн нэвтэрч, хүрээ хийд олноор байгуулан ном, судар орчуулах хэвлэх нь хүрээгээ тэлэв. Эдгээр газарт “Сундуй”, “Долоон өвгөн нэрт одны судар оршив”, “Хутагт огторгуйн зүрхний судар оршив”, “Хутагт Молон тойн эхдээ ач хариулсан хэмээх судар оршив”, “Цагаан лянхуа нэрт их хөлгөн судар оршив” зэрэг олон арван бүтээлийг орчуулж, барлан хэвлэж байжээ. Мөн үед монголчуудын дунд олон дахин хэвлэж, үлэмж тархаасан судар бол Үлгэрийн далай мөн [Шүгэр Ц., 1991: 78; 79]. Бидний тайлбарлаж буй “Үлгэр далай таһалха” хэмээх хэлц үг эртний Энэтхэг орноос гаралтай, бурхны шашны онол сургаалыг адилтгал, зүйрлэлийн хэлбэрээр тайлбарласан, танин мэдүүлэх сурган хүмүүжүүлэх утга агуулгатай “Үлгэрийн далай” хэмээх хөлгөн судартай холбоотой билээ. Иймээс удиртгал хэсэгт Үлгэрийн далайтай холбоотой хэвлэлийн тоймоос дурдлаа.

Бурхны шашин 16-р зууны эхээр Монголд дэлгэрэхийн сацуу Байгалын зүүн талын буриадын дунд нэвтэрч эхэлсэн. Байгал далайн баруун талын Алайр, Эхирэд буриадын дунд хожим 19-р зууны сүүл, 20 дугаар зууны эхээр нэвтэрсэн түүхтэй. Монгол бичиг дэлгэрэх, сургах судлах цаг боломж гараагүй. Харин Цанид хамба Доржийн Агвааны 1905 онд зохиосон Вагиндра үсгийг Байгалын хойд биеийн хэсэг буриад сэхээтэн хэрэглэж байсан ч нийтийн бичиг болж цааш хөгжижи чадаагүй [Жанчив Ё., 2010: 7]. Энэ учраас “Үлгэрийн далай”-д холбогдох заншил, бидний тайлбарлаж буй хэлц үгийн хэрэглээ баруун буриадад байхгүй, мэдэхгүй байх үндэстэй юм. Энэ судрын тархалт, үүнтэй холбоотой заншил уламжлал Байгалын өмнө болон зүүн талын буриадчуудын дунд түгээмэл байсан нь тодорхой байна.

Модон барын хэвлэл бүхий уг судрыг буриад айлууд бурхан шүтээндээ залж, лам эсвэл нутаг усандаа алдаршсан эрдэм, номтой ахмад буурлаар уншуулдаг, яриулдаг сайхан заншил нэгэн үе дэлгэрч байв. Монголчууд энэ судрыг унших хийгээд уншуулбал ялж төгс нөгчсөн бурхантай биеэр учирсан мэт буян оршиж, гурван муу заяанд үл унана хэмээн бишрэн дээдэлж байв. Сүм хийдүүд төвөд хэлээрх судраар хурал ном айлдах, айл өрхүүд гэртээ залж, өлзий буянаа арвижуулж, гарзгүй байх насны түйтгэр, өвчин зовлонгоос хамгаалах элдэв гай барцдыг арилгах зэргээр жилийн засал болгон уншуулж, даллага хүртэл авхуулдаг заншил бий болжээ. Энэ байдлаас үүдсэн, “Үлгэрийн далай”-г дээдлэн шүтэх болсны учир нь:

- “Энэ хөлгөн сударт бурхан буддын урьд төрлийн намтар түүх, буддын шашны сургаал номлолыг хүүрнэн өгүүлсэн”.

- Үлгэрийн далай зохиолд буддын шашны гол номлол сургаал болох “үйлийн үр, дөрвөн үнэн”-ий талаар энгийн ойлгомжтой өгүүлжээ. Хүний энэ насандаа баян чинээлэг, үгээгүү ядуу, үзэшгүй муу зүстэй байх нь тохиолдлын бус харин хувь хүний өөрийн хийсэн урьд насны үйл бүхэнтэй нягт уялдаа холбоотой болохыг тодорхойлжээ... Үйлийн үрийн сургаал буюу сайн, муу үйлийн үр дагаврыг ил тод харуулахын сацуу зургаан зүйл хамаг амьтан нэг төрлөөс нөгөө төрөлд хийсэн үйлийнхээ эрхээр хэрхэн эргэн төрж буй үйл явцыг үлгэр домгийн хэлбэрээр уран яруу өгүүлжээ...[Бүрнээ Д., 2014: 97]

- “Үлгэр далайг хамаг амьтны тусын тулд буяны хотол чуулган болгох үүднээс айлтгадаг, мөн цагаан сарын шинэдээр ихэс гэвш нар олон шавиа суулгаж, хөтлөн гэгээрүүлдэг” уламжлалтай байсан. Одоо ч манай гандан хийдүүд энэ судрыг хурдаг.

- “Ном судар барлана гэдэг маш нарийн арга ажиллагаа, хичээл зүтгэлийн үр дүн, тодорхой цаг хугацааны эцэст бүтдэг няхуур ажил тул бараар хэвлэсэн ном сударт ямар нэг андуу эндүү гардаггүй.” зэрэг учир шалтгаан, зан үйлээс хамааралтай ажээ.

Эдгээр онцлог байдал, уламжлалтай уялдуулан, буриад-монголчуудын дунд дэлгэрсэн заншлын талаарх хэдэн баримт дурдъя.

Нэг. Нохой Ураг хүгдүүд овгийн Цэдэний Чимэджав гуай (1917–2014, Дорнод аймаг Дашибалбар сумын харьяат) ийнхүү өгүүлжээ. “Бидний багад хойд нутаг (одоогийн ОХУ-ын Өвөр Байгалын Хязгаар, Агын раойн Цогтхангил тосгоны нутаг)- таа байхад, зуслангаас бууж намаржаанд орох цагаар гэртээ лам залж, лүйжин тавиулж засал хийлгэдэг байлаа. Энэ нь налгар намрын улирал шувтарч, хүйтэн өвлийг өнтэй давахад бэлтгэж бас бэлгэдэж буй хэрэг байсан биз ээ. “Үльгэр далай” гэж судар байдаг байв. Засал хийх үед тэр судраас уншина. Тэр гэрийн хүмүүсээр өөрийнх нь санасан хэсгээс хуудас сугалуулж, тэнд юун тухай өгүүлсэн байна, түүгээр болно гэж үзнэ. Ер нь өнгөрсөн-одоо-ирээдүй гурван цагийн үйлийг илэрхийлдэг.” хэмээн 7 настай байсан үеийнхээ үйл явдлыг охин Доргош Галзууд овгийн Самбуугийн Цэцэгмаад ярьж үлдээснийг дам тэмдэглэн авсан болно. (2018 оны 03 дугаар сар.)

Хоёр. Үлгэрийн далайг Ширээт Гүүшийн орчуулснаар барласан буриад хувилбар, кирилл бичгээр халх аялгуунд буулгасан хувь

(орч. Д. Бүрнээ, Д. Энхтөр), Ю. М. Парфионовичийн төвөдөөс орос руу орчуулж, 1978 онд хэвлүүлсэн эхүүдийг зэрэгцүүлэн үзэж, сэтгүүлч Гунгаа Чимитов (*ОХУ-ын БурБНУлс Мухаршиивэр аймаг*), түүний гэргий Цыпилма Чимитов нар кирилл бичгээр буриадчилжээ.

Тус хэвлэлийн өмнөтгөлд: “Дэлхийн II дайны өмнө сургуулийн сурагч байхдаа нутгийнхаа дархан, номч өвгөн Доржийн Санжийнд модон бараар хэвлэсэн “Үльгэрэй далай” гэж нарийн бөгөөд урт гонзгой тэвхгэр номыг анх түрүүн харсан юм. Санж дархан жирийсэн олон бурхантай гүнгэрвааны араас шоголтой номоо ширээн дээр гаргаж тавиад, улаан торгон жанчийг нь задалж:

- За, одоо даруйхан гараа угаагаад, нэг нэгээрээ бурхны ном тасалцгаа! гэж гэрт нь цугласан хүүхдүүдэд хандав. - Ямар хувь заяатай улс болохыг чинь таалгая гэж билээ. Тэгээд л бид ээлж ээлжээр хуудас сугалав. Хүн бүхэнд өөр өөр, элдэв сонин үйл хувь таарна. Миний тасалсан хэсгийг дархан Санж уншихад: “аяны замд олон хүн гарч, зам зууртаа хэдий зовсон ч хүрэх газартаа очсон тухай” өгүүлсэн байв. — Чи холын замд сайн явах хүн байна. Зорьсон хэрэг чинь бүтэх юм байна гэж дархан Санж тайлсан билээ. “Үльгэр далай” дотор миний зам тун зөв заагдсан байжээ. Дайны дараа би Улан-Үдэд суралцаад, улмаар Москва хотод Утга зохиолын дээд сургууль төгссөн билээ” хэмээн дурсжээ [Үльгэрэй далай, 2006: 6].

Гурав. Улаалзай Хүгдүүд Гэниний Дарийм (*1927–2009, Дорнод аймаг Баян-Уул сумын харьяат*) гуайд тохиолдсон жишээг сонирхье. Дарийм гуай нутгийн залуу Гомбын Базартай гэр бүл болоход хадам аав Гомбынд “Үльгэр далай” судар байдаг байжээ. Гомбо гуай “Үльгэр далай”-гаа их уншдаг хүн байж. Айл болж хэдэн жил болсон ч хүүхэдтэй болохгүй байсан учир Дарийм гуай амьдралынхаа ирээдүйн байдлыг асууж, хадам ааваараа “Үльгэр далай” таслуулсан гэнэ. Тэгэхэд сайн сайхныг зөгнөсөн хүүхэдтэй болж буй тухай үйл явдалтай хэсэг таарч дээ. Удалгүй тэд айлаас хүүхэд үрчилж, гурван хүүтэй өнөр айл болж амьдарсан байна. Энэ тухай Дарийм гуайн хүү Бодонгууд овгийн Базарын Ондрий, түүний гэр бүл Харгана овгийн Бадамжавын Урантуяа нарын ярьснаар тэмдэглэн авсан болно. (2019 оны 1 дүгээр сар.)

Дөрөв. Харгана Аюурын Жалам (*1934–2012, Дорнод аймгийн Дашбалбар сумын харьяат*)-ын үр хүүхдэдээ хэлж үлдээсэн баримт. Жалам гуай үр хүүхдүүддээ “Үльгэр далай” гээшэ их санй судар

гэдэг. Айлд байхад их сайн. “Үльгэр далай таһалж” мэргэ үздэг байсан тухай үргэлж ярьдаг байсан ажээ. Жалам гуайн хадам ээж нь их ном уншдаг, бичиг үсэгтэй хөгшин байсан бөгөөд тэднийх бурхны ном судар арвинтай айл байсан тул ийнхүү уламжлалыг таслахгүйн төлөө хэлдэг байжээ. Энэ учраас бэр Жаргалан нь 2006 онд Улан-Үдэд хэвлэсэн “Үльгэрэй далай” хэмээх судрыг Жалам абгайн амьд сэрүүн ахуйд олж авч уншдаг болсон тухайгаа: *“эжы маань байнга хэлдэг байсан болохоор “Үльгэрэй далай” судрыг олж авах сан гэж боддог болоод байсан юм. Тэгээд нэг удаа Улаанбаатар хотод очоод байсан үед минь Улаан-Үдээс ирсэн буриад хөгшин тааралдаж, түүнээс хожмын шинэ хэвлэлийг нь авсан билээ. Судар олсон хүн ихэд олзуурхаж, гэртээ ирээд эжийдээ уншиж өгсөн. Тэр судраа аравнайлуулсан, бурхандаа залаад байдаг. Хааяа уншина, бас тасалж үзнэ. Биднээс хойш та нар авч явах ёстой, ийм уламжлалтай гэдгийг хүүхдүүддээ ойлгуулж захьдаг”* хэмээн өгүүллээ. Энэ баримтыг Лэглүүд Хүгдүүд Гөмбөсүрэнгийн Жаргалан (1964, Дорнод аймаг Баян-Уул сумын 1-р баг), гэр бүлийн хүн Бодонгууд омгийн Жамбалын Баттөмөр (1963, Дорнод аймаг Баян-Уул сумын 1-р баг) нараас сурвалжлан тэмдэглэв. (2020-12-18;19-нд утсаар холбогдож тэмдэглэв.)

Тав. Цагаангууд Цэдэнжавын Цэрэгмаа (1937 онд төрсөн. Дорнод аймгийн Дашибалбар сумын уугуул) -гаас тэмдэглэн авсан баримт. Бидний залуу цагт “Үлигэр далай” гээшэ ехэ найн судар юм гэж хөөрөлддөг сөн. Үлигэр далайе тасалбал тухайн хүний ирээдүйн явдлыг зөгнөн өгүүлдэг гэх мэтээр ярилцахыг сонсож байсан билээ. Би айлын бэр болоод хэдэн жил болоход хүүхэдтэй болохгүй байлаа. Тэгээд Үлигэр далай олж таслаад үзэх юмсан, юу гэж гардаг бол гэж их боддог байсан. Гэвч манайх удалгүй айлаас охин үрчлэн авч, өнөөх Үлигэр далай таслах тухай бодлоо орхисон билээ. (2020 оны 07 дугаар сар.) зэрэг жишээ тэмдэглэлийг дурдаж болох байна. Дээр өгүүлсэн баримтуудыг настай голдуу 1940 оноос өмнө төрсөн хүмүүс хэлж үлдээсэн нь харагдаж байна.

Харин 1940 оноос хойш 1950 оны эхэн хүртэл хугацаанд төрсөн хүмүүс төдийлөн сайн мэдэхгүй ажээ. Дайны дараах их бүтээн байгуулалт, нийгэм журмын ёс, шашингүйн үзэл ноёрхож байсан цагт төрж өсөөд, сургууль соёлд орсон. Идэр насандаа мөн л социализмын дэг журамтай цагт ажиллаж явсан хүмүүс учраас иймэрхүү мэтийн заншил, бурхан шашинтай холбоотой асуудлаас

хол хөндий байсан нь ойлгомжтой. Энэ тухай өгүүлсэн өөр жишээг сонирхуулъя.

Доргош галзууд овгийн Махбадарын Намжилмаа (1949 онд төрсөн. Улаанбаатар хот, Баянгол дүүрэг.) ийнхүү өгүүлэв. “1963–1964 оны хичээлийн жил Дорнод аймгийн Баян-Уул сумын 10 жилд сурч байсан үе. Өвлийн амралтаараа гэртээ (Ддашбалбар сум) очлоо. Монгол бичгийн багш маань үсэг заагаад улирал дууссан болохоор гэртээ сайн уншиж давтах даалгавар өгснийг хэлэх үү? Юу уншихыг ээж Удвалаас асуухад, манайд байсан “Монголын уран зохиолын дээж бичиг зуун билиг оршвой” хэмээх том далбагар номыг гаргаж өгсөн юм. Ингээд зах зухаас нь үсэглэн уншиж эхэллээ. Нэг удаа номоо уншиж байтал аав гаднаас орж ирээд “юун хуучин үсэгтэй ном уншиж байна вэ? Энэ чинь хориотой болохгүй” гээд далд хийлгэснээр дахин тэр номыг үзэж чадаагүй. Харин оронд нь Ж.Самбуу даргын “Малчдад өгөх зөвлөгөө” номыг уншиж, үзсэн үсгүүдээ бататгаж байлаа. Зуны амралтаар ирээд нөгөө номоо асуухад аав намын үүрээс хураасан гэж хэлсэн билээ. (2020-12-8-нд утсаар холбогдон тэмдэглэж авав.)

Бэхтэр Хуасай Допрогийн Цэрэнханд (1949 онд төрсөн. Дорнод аймаг Дашбалбар сум) Миний багад манайд “Үлигэр далай” судар байдаг байсан. Аав минь номтой хүн байсан тул их уншдаг байсан. Тухайн цагт эжы, аавын үеийн хөгшчүүл дамжуулж бас уншдаг байлаа. Нэг удаа нутгийн ахай Содномдорж унших гээд авч явсныг санадаг. Удалгүй намын үүрээс бурхан шашинтай холбоотой ном судар хурааж авах, устгах зэрэг ажил өрнөсөн. Тэр байдлаас мултрах гэж олон айл судар ном, бурхан тахилаа голд урсгаж тавьсан билээ. Энэ жишгээр манайд байсан “Үлигэр далай” судрыг голд урсгасан гэдэг. Би тэр үед бага байсан болохоор нарийн учрыг сайн мэдэхгүй үлджээ. Одоо бодоход ямар нэг зүйл асууж мэдээгүй үлдсэн минь харамсалтай санагддаг. (2020-12-09-ний өдөр утсаар холбогдон тэмдэглэж авав.)

Улаалзай Хүгдүүд Пүрэвийн Цэдэнжав (1949 онд төрсөн. Дорнод аймаг Дашбалбар сум, Сэвсүүл-Жараахай баг) Цэдэнжав ахын аав Пүрэв гуай залуудаа лам явсан аж. Тэгээд 1939 онд Халхголын дайнд явах үеэс хар болсон байна. Хожим болтол сумандаа албан ажил хийж байгаад тэтгэвэрт гарсан хүн юм. Угийн дуу цөөтэй тэрээр баргийн юманд дуугардаггүй, яасан ийсэн тухайгаа ярьдаггүй хүн байсан гэж хүү нь дурсав. Тэднийх ном судар арвинтай айл байсан тухай дуулсан тул холбогдож

тодрууллаа. Одоо байгаа ном дотор нь “Үлгэрэй далай” байгаа эсэхийг асуухад: “Бигэрмэжид хааны тагужи гэсэн судар л байна. Уг нь манайд “Үлгэрэй далай” байсан юм. 1959 оны хавар намайг 7 настай байхад усанд хэдэн шоголтой ном тавьсан юм. Тэр номуудтай хамт л усанд урсгасан байх даа.” гэж өгүүлэв. (2020-12-07-нд утсаар холбогдон тэмдэглэж авав.)

Энэ мэт шалтгаанаар дараагийн үеийнхэн уншиж танилцах боломж байсан ч цаг үеийн байдал, намын үзэл суртлаас хамаарсан бурхан шашинтай холбоотой бүхнийг хорьж хаасны эрхээр “Үлгэрийн далай” судартай холбоотой заншил, түүнээс үүдэн бий болсон үг хэллэг өнөөдөр ийнхүү мартагдахад хүрчээ. Энэ явдал зөвхөн ганц үг хэллэгийн хүрээнд, өгүүлсэн нутаг орны хүмүүст тохиолдсон биш билээ. Тухайн цагт бүх нийтэд тулгарч, нэгэн үеийнхэн туулж өнгөрөөсөн.

Үлгэрийн далайг унших энэхүү зан үйл, бэлгэдлийг “Үлгэр далай тагалха” хэмээн хэлэлцэж байсан байна. Одоо цагт зарим айл (түгээмэл биш) кирилл үсэгт буулгасан “Үлгэр далай”-г дээдлэн шүтэж, унших нь цөөн боловч байгаа нь дээр өгүүлсэн “баримт-4”-өөс харагдаж байна. Үлгэрийн далай судар бол буддын шашны сургаалын үзэл санаа, мөн чанарыг гүнзгий тусгаж, түүнийг энгийн үлгэр домгийн зохиомжоор дамжуулан, нийт олныг ухааруулах зорилготой сургаалын зохиол учраас монгол угсаатны дунд зохих хэмжээгээр дэлгэрч, шүтлэг бишрэл, заншлын өвөрмөц нэгэн зан үйл болж байжээ. Энэ ч учраас энэ зохиол шашны бурангуй үзлийг тусгасан, сурталчилсан хэмээн унших, бусдад ярихыг хориглож байсан нь илэрхий юм.

1. Аливаа нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухааны гэх мэт салбарт гарч буй өөрчлөлт шинэчлэлтийн үйл явц нэн тэргүүнд хэлний үгийн санд нэвтрэн ордог нь хөгжлийн жам билээ. Энэ жишгээр дорно дахины соёлт орнуудын уран зохиол монголчуудын оюуны соёлд оруулсан хувь нэмрийн нэгээхэн жишээг эндээс харж болно.

2. Буддын шашны сургаал, номлол, дорно дахины уран зохиолоор дамжуулан, монголын ард түмэн, буриад-монголчууд оюуны соёлын тодорхой өвийг бүтээж, амьдрал ахуй, шүтлэг бишрэлдээ ашиглаж байсны нэгээхэн баримт бол “Үлгэрийн далай судар”, түүнтэй холбоотой хэлэлцэж байсан “Үлигэр далай таслах” хэмээх хэллэг мөн.

3. Хэлний хөгжлийн хуулиар аль нэг үгээр оноон нэрлэсэн юм, үзэгдлийг хэрэглэхгүй, түүнийг мэддэг хүн нь байхгүй болоход түүнтэй холбоотой бүхэн адил бүдгэрч, хэлний үгийн сангаас хасагдаж байдаг. Үүний нэг тодорхой жишээ бол энэ хэлц үг юм.

4. Хүний хувь төөргийг урьдчилан мэддэг арга, монголчуудын хэлдэг номтой хийгээд номгүй хүн гэсэн хэмжүүр, үнэлэмж зэргийг тодруулж үзэх шаардлага ганц хэлц үгийн тайлбар хийхэд илэрч байна. Цаашид өөр газар нутаг, угсаатны дунд ямар байдалтай байсан хийгээд ийм зан үйл ёс дэлгэрсэн эсэхийг угсаатны оюуны соёлын үүднээс сурвалжлах, нөгөө талаас судрын хэл найруулга, үгийн сангийн бүрэлдэхүүнийг харьцуулан үзэх хэрэгцээ байна.

Литература

1. Дамдинсүрэн Ц. Monggol uran jokiyal-un degeji jagun bilig ogusibai. Улаанбаатар: БНМАУ-ын Шинжлэх ухаан ба дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл, 1959. 605 х.

2. Бүрнээ.Д. Үлгэрийн далай монголын бурхны шашны уран зохиол болох нь // ШУА. Хэл зохиолын хүрээлэн. Төвд судлал. Боть 3. 2014. X. 92–103.

3. Жанчив Ё. Вагиндра үсгийн дурсгалууд. Улаанбаатар: Удам соёл, 2010. 188 х.

4. Лувсанбалдан Х. Тод үсэг түүний дурсгалууд. Улаанбаатар: Адмон, 2015. 397 х.

5. Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл шинжлэлийн тэнхим. Шашин судлалын тэнхим. Үлгэрийн далай. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар бичсэн Д. Бүрнээ. Д. Энхтөр. 5 дахь хэвлэл. Улаанбаатар: Удам соёл, 2017. 380 х.

6. Оюунтунгалаг А. Монгол Улсын буриадууд. Улаанбаатар, 2008. MGL DESIGN

7. Ульгэрэй далай. Буряадшалхан Гунгаа Чимитов, Цэпылма Чимитова. Улан-Удэ: Республиканская типография, 2006. 568 х.

8. Чимитдоржиев Ш. Б. Буряадай түүхэ бэшэгүүд. Улан-Удэ: Республиканская типография, 1992. 236 х.

9. Черемисов К. М. Буряад-Ород словарь. М.: Советская энциклопедия, 1973. 803 с.

10. Шүгэр Ц. Монгол модон барын ном. Улаанбаатар, 1991. 261 х.

Мэдээлэгчид

1. Нохой ураг Хүгдүүд Цэдэний Чимэджав (1917–2014), охин Доргош галзууд Самбуугийн Цэцэгмаа (1960, Дорнод аймаг Дашбалбар сумын харьяат).

2. Гэнийн Дарийм (1927–2009, Дорнод аймаг Баян-Уул сумын харьяат), хүү Бодонгууд Базарын Ондрий (1959, Дорнод аймаг, Хэрлэн сум), бэр Харгана Бадамжавын Урантуяа (1960, Дорнод аймаг, Хэрлэн сум).

3. Харгана Аюурын Жалам (1934–2012, Дорнод аймаг, Дашбалбар сумын харьяат), хүү Бодонгууд Жамбалын Баттөмөр (1963, Дорнод аймаг, Баян-Уул сум, 2-р баг), бэр Лэглүүд Хүгдүүд Гомбосүрэнгийн Жаргалан (1963, Дорнод аймаг, Баян-Уул сум, 2-р баг).

4. Цагаангууд, Цэдэнжавын Цэрэгмаа (1937, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг).

5. Доргош галзууд Махбадарын Намжилмаа (1949, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг).

6. Бэхтэр Хуасай Допрогийн Цэрэнханд (1949, Дорнод аймаг, Дашбалбар сум).

7. Улаалзай Хүгдүүд Пүрэвийн Цэдэнжав (1952, Дорнод аймаг, Дашбалбар сум).

8. Е. В. Бембеев, Дөрвөд (1976, ОХУ-ын Халимагийн Бүгд Найрамдах Улс, Элст хот).

ЛИТЕРАТУРНОЕ ОБРАЗОВАНИЕ: ПРОБЛЕМЫ И ПЕРСПЕКТИВЫ

LITERARY EDUCATION: PROBLEMS AND PROSPECTS

МЕТОДИЧЕСКИЕ ВОЗМОЖНОСТИ ИСПОЛЬЗОВАНИЯ УЧЕБНИКА «ЗАБАЙКАЛОВЕДЕНИЕ. ФОЛЬКЛОР ЗАБАЙКАЛЬСКОГО КРАЯ. 5–6 КЛАССЫ» ПРИ РЕАЛИЗАЦИИ РЕГИОНАЛЬНОГО КОМПОНЕНТА ЛИТЕРАТУРНОГО ОБРАЗОВАНИЯ ШКОЛЬНИКОВ

© Баранова Олеся Юрьена

кандидат филологических наук, доцент,
Забайкальский государственный университет
Россия, 672039, г. Чита, ул. Александро-Заводская, 30
olesja2774@rambler.ru

© Тарасова Елена Валентиновна

кандидат педагогических наук, доцент,
Забайкальский государственный университет
Россия, 672039, г. Чита, ул. Александро-Заводская, 30
tarasova.chita@mail.ru

Аннотация. Статья посвящена методическим возможностям организации изучения региональной забайкальской литературы с опорой на недавно изданную первую часть учебника «Забайкаловедение» — «Фольклор Забайкальского края. 5–6 классы». Первая книга представляет собой достаточно подробную характеристику фольклорного наследия Забайкалья с опорой на полиэтничный характер региона. В учебник включены произведения устного народного творчества разных жанров (сказки, мифологические рассказы, легенды, предания, обрядовая поэзия) основных этносов региона — русских, бурят и эвенков. Это даёт возможность выявить диалоговые связи разнонационального фольклора Забайкальского края.

Ключевые слова: фольклор, фольклорные жанры эвенкийский этнос, бурятский этнос, полиэтничный регион, забайкаловедение, региональная специфика, диалектизмы, этнографические особенности.

METHODOLOGICAL POSSIBILITIES OF USING THE TEXTBOOK
“ZABAICALOVEDENIE. FOLKLORE OF THE ZABAICALSKY REGION.
5–6 CLASSES” IN THE IMPLEMENTATION OF THE REGIONAL
COMPONENT OF LITERARY EDUCATION OF PUPILS

Baranova Olesya Yuriena

PhD in Philology, Associate Professor,
Transbaikal State University,
Russia, 672039, Chita, Alexandro-Zavodskaya str., 30
olesja2774@rambler.ru

Tarasova Elena Valentinovna

Candidate of Pedagogical Sciences, Associate Professor
Transbaikal State University,
Russia, 672039, Chita, Alexandro-Zavodskaya str., 30
tarasova.chita@mail.ru

Abstract. The article is devoted to the methodological possibilities of organizing the study of regional Trans-Baikal literature based on the recently published first part of the textbook "Transbaikal studies" — "Folklore of the Trans-Baikal Territory. 5–6 grades ". The first book is a fairly detailed description of the folklore heritage of Transbaikalia based on the multi-ethnic character of the region. The textbook includes works of oral folk art of different genres (fairy tales, mythological stories, legends, traditions, ritual poetry) of the main ethnic groups of the region — Russians, Buryats and Evenks. This makes it possible to reveal the dialogue links of the multi-ethnic folklore of the Trans-Baikal Territory.

Keywords: folklore, folklore genres, Evenk ethnos, Buryat ethnos, polyethnic region, Transbaikal studies, regional specifics, dialectisms, ethnographic features.

Включение национально-регионального компонента образования в Федеральный государственный образовательный стандарт, определяющий содержание литературного образования школьников, связано с решением нескольких важных, в первую очередь, воспитательных задач:

- обеспечить единство и преемственность содержания образования в рамках региона и Российской Федерации, решая задачу целостности образовательного пространства;

- способствовать интеграции предметных знаний;

- создать условия для возрождения отечественной народной культуры, воспитания патриотизма;
- способствовать адаптации школьника к окружающей социальной и природной среде в условиях региона;
- формировать региональную общность людей.

Региональный литературный материал наполнен знаниями об историческом прошлом и настоящем народов региона, их культуре, национальных традициях и обычаях, знакомит с традиционными национальными видами деятельности.

Решению этих задач и реализации национально-регионального компонента способствует созданный авторским коллективом преподавателей кафедры литературы историко-филологического факультета Забайкальского государственного университета (О. Ю. Баранова, Л. В. Камедина, В. А. Сергеева, Е. В. Тарасова) учебник «Забайкаловедение. Фольклор Забайкальского края. 5–6 классы» — учебное пособие для 5–6 классов общеобразовательных организаций [1]. Подготовленный к печати издательством «Русское слово (Москва), он вышел в 2019 году, что дало возможность учителям Забайкалья с 2020 года использовать его материал в литературном образовании школьников края.

Необходимость данного учебника была обусловлена включением в школьную программу отдельной учебной дисциплины «Забайкаловедение», которая предполагает углубленное изучение регионального материала по основным учебным дисциплинам (язык, литература, мировая художественная культура, история, география, биология и др.). Материал учебника по фольклору Забайкалья могут быть использованы учителем-практиком в различных вариантах: как самостоятельные темы урока «Забайкаловедения», как фрагментарное его включение в уроки литературы для сравнительно-сопоставительного анализа произведений разнонационального фольклора, как организация внеклассного литературного образования и самостоятельной проектной деятельности школьников.

В основу структуры учебного пособия положен жанровый принцип, что согласуется с концепцией учебников по литературе для 5–6 классов автора-составителя Г. С. Меркина [2; 3].

В учебник включены как эпические, так и лирические жанры устного народного творчества, отражающие национальное сознание основных этносов региона. Первый раздел учебного пособия — «Сказки» — характеризует региональное своеобразие русских ска-

зок Забайкалья с приведенными в качестве примеров конкретными произведениями («Лисичка-сестричка», «Ореховая веточка», «Конёк-горбунок»), а также эвенкийские («Медведь и бурундук», «Умусликэн» и др.), и бурятские («Хилгэндэй Мэргэн», «Лисица-сваха»). Такой подбор разнонационального сказочного материала позволяет закрепить теоретические знания школьников о специфической классификации сказок, полученные в основном курсе литературы: сказки о животных, волшебные и бытовые. Тексты произведений предваряются развернутой информацией о выдающихся фольклористах Забайкалья — собирателях сказок. После знакомства с текстом учащимся предлагается ответить на вопросы и выполнить задания по произведению, а также познакомиться с развернутым комментарием специфического языка сказок, который принципиально сохранен составителями пособия как образец живой разговорной речи забайкальцев. Это и обилие диалектных слов и выражений, и особенности произношения и словообразования, и лексика, отражающая географические, климатические и этнографические особенности края [1: 18–19].

Заложенный в концепцию учебников литературы издательства «Русское слово» принцип диалога культур дает возможность расширить представление школьников о специфике жанров сказки и сопоставить предлагаемые региональные образцы как с произведениями общерусских сказок, так и зарубежного фольклора, а также их литературного переложения такими выдающимися авторами, как В. А. Жуковский, А. С. Пушкин, П. П. Ершов, Ш. Перро, бр. Гримм, Х. К. Андерсен [1: 27–28]. Таким образом, региональный фольклор гармонично вписывается в пространство и русской и, более широко, мировой культуры.

По такому же принципу в учебник включены мифологические рассказы Забайкалья, народные легенды и предания, а также фрагменты героического бурятского эпоса — улигера «Абай Гэсэр» и эвенкийского — улгура «Всесильный богатырь Дэвэлчэн в расшитой-разукрашенной одежде». В качестве итоговых вопросов и заданий к последнему разделу предлагается оценить и прокомментировать высказывание выдающегося ученого В. М. Жирмунского о жанре героического эпоса, что предполагает элементы частично поисковой и исследовательской деятельности учеников [1: 171].

Завершающими разделами учебной книги становятся главы, посвященные обрядовой поэзии и народным песням. Дается разверну-

тая характеристика понятия обряда и его классификация. Рассказывается история становления обрядовой традиции Забайкалья и приводятся лучшие образцы фольклорных песен, сохранившиеся в Забайкалье и сегодня.

Задания, сопровождающие фольклорные произведения, предполагают разные виды учебной деятельности: они могут быть аналитического характера и требуют от ученика текстуального анализа; задания, объединённые рубрикой «Живое слово», направлены на организацию частично поисковой и исследовательской деятельности школьников, активизируя их остаточные и фоновые знания по литературе; итоговые вопросы и задания призваны обобщить и систематизировать изученный материал. Отдельно представлены темы итоговых проектов, соответствующих современным тенденциям литературного образования, направленных на формирование навыков самостоятельной поэтапной интеллектуальной деятельности учащегося.

Учебник сопровождается списком рекомендуемых произведений, объединённых рубрикой «Советуем прочитать» [1: 203].

Несомненным достоинством учебника является богатый иллюстративный материал, визуально представляющий своеобразие климата, природы, этнографических особенностей и наиболее выдающихся исторических и культурных достопримечательностей.

В настоящий момент к печати подготовлена вторая часть учебника «Забайкаловедение. Литература Забайкальского края». В него включены наиболее выдающиеся образцы поэтического и эпического литературного наследия забайкальских авторов. Материал систематизирован по тематическому принципу: возникновение региональной литературы, природа края, Забайкалье как поликультурное и полиэтничное пространство, писатели Забайкалья детям, судьба страны в истории края.

Данное пособие, несомненно, способствует более глубокому, осмысленному и творческому восприятию учениками специфики региональной литературы представляет серьёзное методическое подспорье учителю-словеснику для организации литературного образования школьников края.

Литература

1. Забайкаловедение. Фольклор Забайкальского края: учеб. пособие для 5–6 классов общеобразовательных организаций / О. Ю. Бара-

нова, Л. В. Камедина, В. А. Сергеева, Е. В. Тарасова. М.: Русское слово, 2019. 208 с.: ил. (Региональный компонент).

2. Литература: учебник для 5 класса общеобразовательных организаций: в 2 ч. / авт.-сост. Г. С. Меркин. 6-е изд. М.: Русское слово, 2016. Ч. 1. 328 с. (Инновационная школа).

3. Литература: учебник для 6 класса общеобразовательных организаций: в 2 ч. / авт.-сост. Г. С. Меркин. 6-е изд. М.: Русское слово, 2017. Ч. 2. 328 с. (Инновационная школа).

УРАН ЗОХИОЛЫН БОЛОВСРОЛЫН УЛАМЖЛАЛ БА ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД (ВОПРОСЫ МОДЕРНИЗАЦИИ ЛИТЕРАТУРНОГО ОБРАЗОВАНИЯ)

© Лувсаням Болормаа

старший преподаватель,

Университет Дорнод

Монголия, 21071, г.Чойбалсан, микрорайон 10

l.bolormaa@dornod.edu.mn

© Ганболд Баярцэцэг

магистр,

Университет Дорнод

Монголия, 21071, г.Чойбалсан, микрорайон 10

g.bayartsetseg@dornod.edu.mn

Аннотация. Уран зохиолын уламжлалт боловсролын агуулгыг өөрчилж, шинэ парадигмын дагуу өнөөгийн нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ерөнхий боловсролын сургуулийн уран зохиолын сургалтын агуулга, хөтөлбөр өөрчлөгдөж, сургалтын зарчим нийгэмтэйгээ зохицох нөхцөл бүрдэнэ. Уран зохиолын сургалт, боловсролын агуулгын бүтэц бүрэлдэхүүний элементүүдийг өөр хоорондын уялдаа холбоонд авч үзэхдээ уламжлалынх нь тогтвортой хөгжлийг шинэчлэлтэй нь холбож чадвал энэхүү боловсрол сургалтын үйл явц оновчтой болж үр өгөөжөө өгөх боломж нөхцөл бүрэлдэнэ.

Ключевые слова: Уран зохиолын боловсрол, мэдээлэл харилцааны технологи, сургалт, шинэчлэл

ISSUES OF LITERARY EDUCATION MODERNIZATION

Luvsannyam Bolormaa

Senior Lecturer,

Dornod University

Mongolia, 21071, Choibalsan city, microdistrict 10

l.bolormaa@dornod.edu.mn

Ganbold Bayartsetseg

master,

Dornod University

Mongolia, 21071, Choibalsan city, microdistrict 10

g.bayartsetseg@dornod.edu.mn

Abstract. Education principles will be coordinated to the society by carrying out reforms with the content and curriculum of literature education in secondary schools, changing the traditional ways of literature teaching according to the new paradigm. We should associate the sustainable development aspects to the reforms when we treat the correlations between the elements in the education system. This can make the literature program could be more efficient. The introduction of information and communication technologies in the curriculum and content of literature teaching in accordance with the needs of society and students, could fully meet the objectives of the curriculum and make the literature disciplines appropriate and effective.

Keywords. Literary education, ICT, education, reform.

Боловсролын агуулга гэж юуг хэлэх вэ? юуг яаж өөрчлөх ёстой вэ?, түүний дотор бидний тусгайлан авч үзэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн уран зохиолын сургалтын агуулга, хөтөлбөрт хэрхэн мэдээлэл, холбооны технологийг нэвтрүүлэх нь шинэчлэгдэн буй нийгмийн болон суралцагчийн эрэлт, хэрэгцээтэй уялдсанаар хөтөлбөрийн зорилтыг бүрэн хангах, сургалтыг чанартай, үр дүнтэй болгох сайн талтай.

Боловсролын агуулгыг олон янзаар тодорхойлдог. МУ-ын Боловсролын тухай хуулийн 3.1.3-р зүйлд “Боловсролын агуулга” гэж боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, төлөвшлийн цогцыг хэлнэ,, гэж заажээ. Энэ тухайд онолч, эрдэмтэд өөр өөрийнхөөр тодорхойлжээ¹.

¹ Unjiipsychology. Сургалтын технологи. 2016 оны 3-р сарын 29. URL: http://unjiitechnology.blogspot.com/2016/03/blog-post_29.html

- Сургалтын агуулга нь сургалтын явцад суралцагчид зайлшгүй эзэмших ёстой мэдлэг, чадвар, дадал болон ертөнцийг үзэх үзэл, ёс суртахуун, гоо сайхны үзэл санааны тогтолцоо; И. Ф. Харламов

- Сургалтын агуулга нь бие хүний хөгжлийг хангаж байдаг мэдлэг, чадвар, дадал, бүтээлч үйл ажиллагааны туршлага болон ертөнцөд хандах сэтгэл хөдлөл, үнэлгээний хандлагын сурган хүмүүжүүлэх зүйн үүднээс хялбаржуулсан тогтолцоо; И. Я. Лернер

- Сургалтын агуулга нь бие хүний шинж чанар дэвшин өөрчлөгдөх үйл явцын агуулга юм. В. С. Леднев.

Мэдээлэл, холбооны технологийн хөгжил нь эдүгээ энгийн ахуй, иргэдийн өдөр тутмын хэрэглээнд хурдацтайгаар нэвтэрч, XXI зууны хүмүүсийн суралцах, ажиллах уламжлалт арга, хэлбэр, тогтсон хэв маягт хүчтэй өөрчлөлтийг үзүүлж, амьдралын чанарт хувьсгал хийж байна. Мэдээлэл, холбооны технологийн өөрчлөлт нь боловсролд их боломж, нөөцийг олгож байгаагийн зэрэгцээ боловсролыг өөрчлөх зайлшгүй хэрэгцээг нөхцөлдүүлж байна¹.

Монголд системт боловсрол үүсч бий болсон үеэс өнөөг хүртэл ерөнхий боловсролын сургуулийн уран зохиолын агуулгыг

1. Үндэсний хэлбичиг хэмээх агуулга дор уран зохиолын хичээлийг хамтатган үзэж байсан үе буюу ардын аман зохиол гол судлагдахуун болж байсан үе (1921–1930 он хүртэл)

2. Уран зохиолыг үндэсний хэлбичгийн хичээлээс салгаж, бие даалган судлах болсон үе буюу сургалтын агуулга гадаадын уран зохиолоор өргөжсөн үе (1930–1949 он хүртэл)

3. Уран зохиолын сургалтыг хэт үзэл сурталжуулсан үе буюу социалист реализмын хөгжлийн оргил үеийн уран зохиолын сургалт (1949–1990 он хүртэл)

4. Ардчилал шинэчлэлийн үзэл санаа уран зохиолын сургалтад нөлөөлсөн үе буюу сургалтын агуулга стандартыг шинэчлэх шаардлага тулгарсан үе (1990 оноос өнөөг хүртэлх үе) гэсэн дөрвөн үед хуваан авч үзсэнээр нийгмийн оюуны ухамсар болсон уран зохиолын сургалтын үүрэг ач холбогдлыг ямар үед яаж үнэлэн үзэж байсныг тодруулж танин мэдэхүйн үе цагийн гинжин холбоонд авч үзэхийг зорьсон юм [1].

¹ Цогзолмаа Ц. Тогтвортой хөгжлийн гарц-Чанартай боловсрол. 2018 оны 1-р сарын 24. <https://sites.google.com/a/school1.edu.mn/1school/news/hen-uu-helev/togtvortojhgzlijngarc-canartajbolovsrol>.

Ерөнхий боловсролын систем бүрэлдэн тогтсон 1921 оноос хойших уран зохиолын сургалтыг үечлэн үзэх болсон нь аливаа түүхэн үйл явдлыг үечлэхийн тулд бус тухайн нийгэм цаг үе, улс төрийн тогтолцоо, нийгмийг үзэх онол үр дагавар, учир холбогдол зэргээс урган гарсан зүй тогтолт үзэгдэл юм.

Ерээд оноос өмнө уран зохиолын сургалтыг заах арга, зөвлөмжийн хэлбэрээр судалж ухуулж гэгээрүүлсэн, зааварлаж чиглүүлсэн, чиглэл удирдамж болгож байсан. Харин Д. Гомбожав, Т. Гомбосүрэн нарын редакторлаж 1990 онд хэвлүүлсэн “Дунд сургуульд уран зохиол заах арга” бүтээлээрээ уран зохиолын хичээлийн үүрэг зорилго, ач холбогдол, энэ хичээлээр сурагчдад олгох мэдлэг чадвар, дадал, эх зохиолын задлал хийх арга, заах аргын зарчмын асуудал зэргийг цогц байдлаар дэвшүүлэн тавьж сургалт руу гүнзгий орсон бүтээл болсон юм. Энэ мэтчилэн “Монгол хэл бичгийн багш нарт тусламж” “Уран зохиол, заах аргын зөвлөмж” /1987/ СХУХ-гийн “Эрдэм шинжилгээний бичиг” /1970/ нэртэй цуврал гаргаж байсан нь багш нарт чухал гарын авлага болж байв. Системт боловсролын дэвсгэр суурь тавигдсан 1921 оноос хойш өнөөг хүртэл гарсан уран зохиолын хичээлийн хөтөлбөр, сурах бичгүүдэд байгаа зохиол бүтээл болон заах арга зүйн зөвлөмжүүд, эрдэмтдийн шүүмж судалгаа, ном бүтээл, тухайн үеийн МАХН-ын төв хороо. Засгийн газрын тогтоолууд, Ардын боловсролын яамны албан баримт, Монголын зохиолчлын эвлэлийн удаа дараагийн их, бүгд хурлын материал зэрэгт уран зохиолын боловсролын уламжлал, шинэчлэлийн үйл явцыг тодорхой тусган харуулсан байдаг¹.

Харин «сургалтын хөтөлбөр нь нэг талаас шинжлэх ухааны мэдлэгт суурилсан харьцангуй тогтвортой агуулгаар тодорхойлогдох хэдий ч шинжлэх ухаан, технологийн хөгжил дэвшил, хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэн буй нийгмийн болон суралцагчийн эрэлт, хэрэгцээтэй уялдан байнга боловсронгуй болж байх шаардлагатай үйл явц юм»².

¹ Цогзолмаа Ц. Тогтвортой хөгжлийн гарц-Чанартай боловсрол. 2018 оны 1-р сарын 24. <https://sites.google.com/a/school1.edu.mn/1school/news/hen-uu-helev/togtvortojhgzlijngarc-canartajbolovsrol>.

² Монгол улс. ШУА. Хэл зохиолын хүрээлэн. Хэрэглээний хэл шинжлэл. Улаанбаатар, 2017. Х. 10.

Ерөнхий боловсролын уран зохиолын сургалтын хөтөлбөрт зааснаар уран сайхны эх дээр ажиллах арга зүйг дараах байдлаар тодорхойлсон байдаг¹.

- Уран сайхны эхийг уншиж ойлгох, эргэцүүлэн тунгаах, шүүмжлэлт задлан шинжилгээ хийх замаар шинэлэг бүтээлч санаа, зохиогчийн шийдэл, эргэлзээ төрүүлж байдаг таамаглал, үзэл санаа зэргийг тайлбарлах, үзэл бодлоо илэрхийлэх, соёлын үнэт зүйлийг тодорхойлох арга аргачлалд суралцана. Энэ нь сурагчдын өөрийн өнцгөөс харж санаагаа илэрхийлэх, эргэцүүлэн бодох ба асуудал дэвшүүлэх, шийдлийг олох чадварыг хөгжүүлэхийн тулд илүү хичээнгүйлэн ажиллах шаардлагатайг харуулна. Үүний тулд хүний сэтгэл хөдлөлийн олон янз байдлыг үзүүлсэн зохиолоос гадна түүх, нийгэм, соёлын хам сэдэв бүхий зохиолыг сонгох, судлах боломжийг сурагчдад олгох

- Зохиолын агуулгыг ойлгон түүнд үндэслэн үнэлж дүгнэх, эерэг санааг тусган авч өөрийн бодол санаа ба мэдрэмжтэй уялдуулах, далд утгыг тодорхой болгох, өөрийн ойлголт, үзэл бодолтой холбон гүнзгий тунгаан бодоход сургах зэрэг ойлголтыг гүнзгийрүүлэх сургалтын арга зүйг чухалчлах

- Тухайн сонгосон зохиолыг ойлгоход зохиогч ба зохиолын түүх соёлын үндэс, утга зохиолын онол, судалгааны бүтээлүүд зэрэг нь өөр хоорондоо харилцан хамааралтай байгааг олж тогтоох түүний талаарх уншигч судлаачдын сэтгэгдэл, шүүмж судлал болон тухайн зохиолоор хийсэн тайз дэлгэцийн бүтээлүүдийг судлан зохиол бүтээлийг бүхэлд авч үзэх, өөрийн санааг нэмэх зэргээр бүтээлч арга барилд сургах

Харин орчин үеийн суралцагчид нь технологид суурилан аливааг уншиж ойлгох, задлан шинжлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн бодол санааг мэдрэмжтэй уялдуулах зэрэг олон талт чадвартай. Иймд дээр «өгүүлсэнчлэн уран сайхны эх дээр ажиллуулахдаа цахим нээлттэй эхүүдийг ашиглавал илүү үр дүнтэй цаг хугацаа хэмнэсэн, сонирхол татахуйц, танин мэдэхүйг хөгжүүлсэн сургалт болох юм» [2].


Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ уран зохиолын сургалтад TextStat программыг хэрхэн ашиглах боломжтойг уран сайхны эх дээр туршиж судлан танилцуулахыг зорилоо. «Мөн цаашид бүх

¹ БСШУСЯ. Монгол хэл, бичиг. Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК, 2019. Х. 21—22.

төрлийн хичээлд хөрвүүлэн ашиглах боломжтой нээлттэй эхийн программ хангамж юм»¹.

TextStat нь текстэд дүн шинжилгээ хийдэг компьютер хэл шинжлэлийн нээлттэй программ юм. Энэхүү программын тусламжтайгаар үгийн давтамжийг тооцоолох түүнд дүн шинжилгээ хийх боломжтой. Ингэхдээ HTML болон өөр өөр кодчилол бүхий файлуудын үгийн давтамжийг гаргах үгсийг цагаан толгойн дараалалд оруулах гэх мэт өргөн боломжтой. Тус программыг ухаалаг утсанд суулгаж ашиглах боломжтой.

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн Уран зохиолын сурах бичгийн (2019) “Монголын орчин үеийн өгүүллэг, тууж” бүлгийн С. Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгт хийсэн туршилт




Бидний сонгож авсан дээрх өгүүллэгт давхардсан тоогоор 4860 үг байна. Харин үгийн давтамжийг TextStat программаар тооцоолж үзэхэд давхардаагүй тоогоор 2380 үг байна. Эдгээр үгсийг бид хамгийн их давтагдаж байгаагаар нь эрэмбэлсэн. Зохиолч эзэмшигч эзэн, эзэмшигдэгч юм хоёрын хоорондын хамаатах харьцааг заах, нэрлэсэн зүйлээ төрлийнх нь олон юм

¹ БШУЯ. “Сурах бичиг”, 9-р анги (econtent.edu.mn), 12-р анги (econtent.edu.mn)

үзэгдлээс онцлон ялгах, өгүүлэгдэхүүний илтгэгч (subject marker)-ийн үүргээр хэрэглэхийн тулд монгол хэлний 3-р биед хамаатуулах “нь” нөхцөлийг 166 удаа хамгийн их давтамжтай хэрэглэсэн байна.

2. Ерөнхий боловсролын сургуулийн 9 дугаар ангийн Уран зохиолын сурах бичгийн (2019) “Сонгодог уран зохиол” бүлгийн Гэсэрийн туужийн Тэргүүн бүлэгт хийсэн туршилт



Дээрх туужийн тэргүүн бүлэгт давхардсан тоогоор 5693 үг байна. Харин үгийн давтамжийг TextStat программаар тооцоолж үзэхэд давхардаагүй тоогоор 1996 үг байна. Эдгээр үгсийг бид хамгийн их давтагдаж байгаагаар нь эрэмбэлсэн. Гэв-110, гэж-110, нь-89, Жур-70, минь-55 хамгийн их давтамжтай байна. Үүнээс харахад “нь” нөхцөлийг мөн л нэлээд олон удаа давтсан байгаа нь эзэмшигч эзэн, эзэмшигдэгч юм хоёрын хоорондын хамаатах харьцааг заах, нэрлэсэн зүйлээ төрлийнх нь олон юм үзэгдлээс онцлон ялгахын тулд хэрэглэсэн нь тодорхой байна. Мөн “Жур” гэдэг үгийг олон давтсанаар зохиолын явдалд чухал үүрэгтэй гэдэг нь харагдаж байна.

TextSTAT программыг ашиглан Ерөнхий боловсролын сургуулийн 6 дугаар ангийн Уран зохиолын сурах бичгийн (2019) Ч. Лодойдамба “Шаргачин”, 7 дугаар ангийн уран зохиолын сурах бичиг (2018) Г. Мэнд-Ооёо “Нутаг буюу гүйсэн унаганы дууль”

өгүүллэгийн тодорхой хэсгээс сонгон авч, харьцуулан үгсийн давтамж, үгийн баялаг олон талт чанарын коэффициентийг гаргаж тооцоолов. Тооцоолон гаргаснаас харахад зохиолч Ч. Лодойдамбын сонгосон зохиолын хэсэг нь 1222 үгтэй байснаас нь 786 давтагдаагүй үг, Г. Мэнд-Ооёогийн зохиол 482 үгтэй байснаас 359 нь мөн давтагдаагүй үгтэй байсан нь зохиолчид найруулан бичихийн эрдэмд гойд суралцсан болох нь тодорхой байна. Учир нь тухайн зохиол дахь үгийн давтамж бага байх нь найруулга сайн байгааг илтгэх төдийгүй баялаг олон талт чанарын коэффициент тус бүр 0.9 байв. Энэ нь байх ёстой үнэмлэхүй дээд хэмжээ 1.0-д ойртсон найруулга сайн байгаа нь харагдаж байна.

Монгол улсын Дорнод аймгийн Чойбалсан хотын Ерөнхий боловсролын 12 жилийн сургалттай 8 дугаар сургууль, 2 дугаар сургуулийн нийт 85 сурагчийг тус судалгаанд хамруулсан.

1. Та уран сайхны бичвэр дэх үгсийн давтамжийг тооцож гаргахдаа ямар программ ашиглаж байсан бэ?

- a. Microsoft Word — 10%
- b. Бусад — 17%
- c. Огт ашиглаж байгаагүй — 73%

2. Монгол хэлний хичээлд хэл шинжлэлийн программ ашиглах нь танд хэр үр дүнтэй санагдаж байна вэ?

- a. Боломжийн
- b. Сонирхолтой, сурах хүсэлтэй болдог
- c. Гараар тоолохоос илүү хялбар. Ялангуяа тодорхойлсон үгсийг гараар тоолохоос TextStat программаар тоолох нь илүү хялбархан.


- d. Ойлгомжтой
- e. Хугацаа хэмнэдэг
- f. Хөгжилтэй санагдсан
- g. Ирээдүйд хэрэгтэй
- h. Мэргэжлийн хүрээнд сайжрах боломжтой.

3. Монгол хэлний хичээлд хэл шинжлэлийн программ ашиглахад танд ямар ямар хүндрэл гарч байсан бэ?

- a. Программыг сайн судлаагүй тохиолдолд хүндрэл гарч байна.
- b. Эхийг задлан шинжлэх агуулгыг тодорхой гаргавал зүгээр.
- c. Энэ аргаар улам гүнзгийрүүлэн судалмаар байна.
- d. Эхнээс нь нямбай ойлговол бүр илүү сонирхолтой болно.

е. Маш их зүйл мэдэхийг, өөр ямар ямар нөхцөлөөр дүгнэлт гаргаж болдог талаар мэдэхийг хүсэж байна

4. Танд уран сайхны бичвэрээс зохиолын гол дүрийн холбоо хамаарлыг тодруулах программын аль хувилбарыг нь илүү үр дүнтэй санагдсан бэ?



5. Цаашид хэл шинжлэлийн бусад программыг сургалтад ашиглавал ямар үр дүн гарна гэж та бодож байна вэ?

а. Бодит үр дүн

б. Сургалтад тогтмол ашигласнаар задлан шинжлэх чадварт сайн суралцана.

Уран зохиолын хичээлд Textstat программыг ашигласнаар үгсийн давтамжийг тооцоолон судлах, тухайн уран сайхны эхийг ойлгох боломж нэмэгдэх, «хамгийн идэвхтэй үгийг мэдсэнээр зохиолд ямар үүргээр орох, гол дүрийн үүрэг роль ямар байгаа, зохиолын явдалд хэрхэн холбогдож байгааг богино хугацаанд программын тусламжтайгаар мэдэх давуу талтай»¹.

Тухайн зохиол дахь үгсийн давтамжийг тооцоолон гаргаснаар үгийн баялаг олон талт чанарын коэффициентийг гаргах боломжтой. Учир нь тухайн зохиол дахь үгийн давтамж бага байх нь найруулга сайн байгааг илтгэх төдийгүй баялаг олон талт чанарын коэффициент байх ёстой үнэмлэхүй дээд хэмжээ 1.0-д ойртсон найруулга сайн байгааг харуулах төдийгүй зохиолчид найруулан бичихийн эрдэмд гойд суралцсан нь тодорхой болох юм.

«Уран зохиолын хичээлийн зорилго, агуулгыг монгол өв уламжлал, ёс заншил, соёл, түүхийг таниулдаг, өвлүүлдэг, эх оронч, үндэсний бахархал, дархлааг хөгжүүлдэг байдлаар өргөжүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл уран зохиолын хичээлийг бие даан судалдаг байхаар өөрчилнө» [3].

¹ БСШУСЯ. Монгол хэл, бичиг. 1-д Суурь боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК 2019. Х. 21–22.

ЕБС-ийн уран зохиолын хичээлийн уран сайхны эхийн үгийн тоо нь анги ахих тусам нэмэгдэж байгаагаас үзвэл тухайн суралцагчийн мэдээлэлтэй ажиллах чадвартай холбоотой байна.

Зохиолчид эзэмшигч эзэн, эзэмшигдэгч юм хоёрын хоорондын хамаатах харьцааг заах, нэрлэсэн зүйлээ төрлийнх нь олон юм үзэгдлээс онцлон ялгах, өгүүлэгдэхүүний илтгэгч (subject marker)-ийн үүргээр хэрэглэхийн тулд “нь” нөхцөлийг судалж үзсэн зохиол бүрт хэрэглэсэн нь онцлог байна.

Нээлттэй эхийн программ хангамжийг хичээлийн хөтөлбөртөө тусгаж, сургалтдаа ашиглах нь орчин үеийн суралцагчдыг чадваржуулах нэгэн түлхүүр хэрэглэгдэхүүн болох юм. Мэдээлэл, холбооны технологийн өөрчлөлт нь боловсролд их боломж, нөөцийг олгож байгаагийн зэрэгцээ боловсролыг өөрчлөх зайлшгүй хэрэгцээг нөхцөлдүүлж байна.

Мэдээлэл, холбооны технологийн дэвшлийг уран зохиолын сургалтад нэвтрүүлснээр орон зай, цаг хугацааны саадыг гэтэлгэж, суралцагчийн хүсэл, сонирхол, хэрэгцээ, боломжид нийцсэн, илүү үр дүнтэй, үр ашигтай сургалтыг зохион байгуулах боломж бүрдэх юм.

Литература

1. Цэнджав Д. Уран зохиолын боловсролын уламжлал шинэчлэлийн асуудалд. Улаанбаатар, 2005. Х. 15–16.

2. Баттөгс Ш. Хэрэглээний найруулга зүй ба найруулах эрдэмд суралцах нь. Улаанбаатар, 2017. Х. 5.

3. Энхбаяр С., Батсуурь Г. Утга зохиол шинжлэлийн удиртгал хичээлийн гарын авлага. Улаанбаатар, 2018. Х. 4.

ОБУЧЕНИЕ БУРЯТСКОМУ ЯЗЫКУ НА ОСНОВЕ ПРОГРАММ В МАССМЕДИА И ИНТЕРНЕТ-ТЕХНОЛОГИЙ

© Ошоров Сергей Гармаевич

кандидат педагогических наук, доцент,
Бурятский госуниверситет им. Д. Банзарова
Россия, 670000, г. Улан-Удэ, ул. Смолина, 24а
oshorovsg@mail.ru

© Сухеева Туяна Бальжинимаевна

аспирант 3 года обучения,
Бурятский госуниверситет им. Д. Банзарова
Россия, 670000, г. Улан-Удэ, ул. ул. Смолина, 24а
tsuheeva@mail.ru

Аннотация. В статье рассматриваются различные формы, методы и средства обучения, используемые при создании обучающих программ по бурятскому языку, сайтов и сетевых сообществ на бурятском языке. Чуть более подробно раскрывается опыт создания авторского видеокурса по обучению бурятскому языку «Буряадар дуугараял» преподавателя Восточного института Бурятского государственного университета г. Улан-Удэ и одного из известных монголоведов в мире Жаргала Бадагарова. Видеоматериал снабжен интерактивными картинками различных типов, с помощью которых вырабатываются основные умения и навыки. Авторы также дают свое видение перспектив развития образовательных ресурсов в области бурятского языка.

Ключевые слова: образовательные и информационные технологии, Интернет, социальные сети, преподавание, бурятский язык, развитие цифровизации, электронный учебник, сетевые сообщества.

BURYAT LANGUAGE TRAINING BASED
ON PROGRAMS IN MASS MEDIA AND INTERNET TECHNOLOGIES

Oshorov Sergey Garmaevich

Candidate of Pedagogical Sciences, Associate Professor
Buryat State University named after D. Banzarov
Russia, 670000, Smolina str.24 a
oshorovsg@mail.ru

Sukheeva Tuyana Balzhinimaevna

post-graduate student of 3 years of study,

Oriental Institute Buryat State University named after D. Banzarov

Russia, 670000, Ulan-Ude, Smolina str.24 a

tsuheeva@mail.ru

Abstract. The report examines various forms, methods and means of teaching used in the creation of training programs in the Buryat language, websites and online communities in the Buryat language. A little more detail reveals the experience of creation of author's video course teaching the Buryat language "of Baradar was buharal" teacher of the Oriental Institute of the Buryat state University Ulan-Ude, one of the famous of Mongolian in the world of Argala Batagarawa. The video material is provided with interactive images of various types, with the help of which basic skills and abilities are developed. The author also gives his vision of the prospects for the development of educational resources in the field of the Buryat language.

Keywords: Educational and information technologies, Internet, social networks, teaching, Buryat language, digitalization development, electronic textbook, network communities.

Создание обучающих и тестирующих программ по изучению бурятского языка начали появляться относительно недавно. Новый этап развития цифровизации различных предметных областей в республике дали Бурятский научный центр (БНЦ СО РАН) и Бурятский государственный университет имени Доржи Банзарова. Только за последнее десятилетие с их помощью переведены тысячи бумажных книг в электронный (цифровой) формат. Стали появляться электронные учебники, курсы по изучению бурятского языка. В школах и детских садах республики и вовсе появились увлекательные учебные курсы с использованием различных мультимедийных средств: озвученные мультяшные тексты, картинки, интерактивные упражнения. Были разработаны Этимологический словарь бурятского языка, звуковые алфавиты, интерактивные 3D-словари бурятского языка для детей дошкольного и младшего школьного возраста, интернет-сервис для изучения бурятского языка, телевизионная викторина «Түхэриг» и так далее. Все эти электронные курсы, как правило, организованы таким образом, что содержат автоматические программные электронные системы, которые со временем устаревают, а иногда и вовсе исчезают. Это можно отметить, как один из больших минусов. Поэтому возникает необходимость по-

стоянного развития средств и методов обучения, обновления методической базы, к тому же, периодически меняются и федеральные стандарты. Кроме этого, в век информационных технологий, есть возможность осваивать другие формы и средства обучения. Это и социальные сети, коммуникационные сервисы Skype, ZOOM, специализированные информационные сайты для изучения языков и т. д. Следует отметить, что государственная программа сохранения и развития бурятского языка в регионе на сегодняшний день способствует активному развитию электронных мультимедийных образовательных технологий.

В статье мы попробуем проанализировать особенности преподавания бурятского языка с использованием Интернет-технологий, рассмотрим возможности организации учебного процесса с помощью видеокурсов, социальных сетей и т. д.

Всем известен тот факт, что успешность любого образовательного процесса зависит от правил разграниченности методов обучения в зависимости от уровня владения языком. К большому сожалению, в настоящее время таких индивидуальных обучающих программ практически нет. Хотя во всемирной паутине можно найти большое количество различных источников, посвященных бурятскому этносу, его национальным особенностям. Среди них есть ресурсы, содержащие различные продвинутые обучающие материалы. Так, например, сайт SOYOL.RU — это энциклопедический портал, содержащий информацию о бурятской культуре, искусстве, традициях и обычаях. Все публикации на сайте снабжены фото- и видеоматериалами, перекрестными ссылками для предоставления более полной информации по теме.

Вопросам изучения бурятского языка посвящен сайт литературы potiian.com — интернет-библиотека бурят-монгольской литературы. Республиканский центр народного творчества совместно с Институтом монголоведения, буддологии и тибетологии СО РАН формирует электронную базу данных «Бурятские народные песни: по материалам фольклорных экспедиций по Бурятии».

Для себя мы можем отметить перспективным проект видеокурса: «Буряадар дуугараял». В 2014 году телеканал АТВ запустил один из успешных, на наш взгляд, видеокурсов по обучению бурятского языка «Буряадар дуугараял»¹. Руководитель проекта — пре-

¹ TV «АТВ» от 26.02.2014 // Буряадаар дуугараял. URL: <http://tvatv.ru/news/5/294276>.

подаватель Восточного института Бурятского государственного университета г. Улан-Удэ и один из известных ученых монголоведов в мире Жаргал Бадагаров, который не только знакомит обучающихся с особенностями устной речи и грамматики, но и создает базу для дальнейшего изучения языка.

Суть методики состоит в том, чтобы предложить слушателям, прежде всего, изучать активные слова, которые чаще всего употребляются в бурятском языке, постепенно увеличивая свой словарный запас. Таким образом, процесс обучения сначала включает в себя наиболее часто используемые слова, а затем те, которые используются реже.

